

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021.07.02

Даланзадгад сум.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

1.1. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл болон холбогдох эрх зүйн баримт бичигт тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Цагдаагийн газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын даргаар хянуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, 2021 оны хагас жилийн биелэлтийг гарган Төлөвлөлт зохион байгуулалтын хэлтэст хүргүүлсэн. Гүйцэтгэлийн төлөвлөгөө хагас жилийн байдлаар 80.2 хувьтай хэрэгжсэн байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2021 онд хяналтад авч, биелэлт үр дүнг тооцох албан бичгийн жагсаалтын дагуу орон нутаг дахь Цагдаагийн газраас хэрэгжүүлэх 91 төрлийн албан бичгийн 203 холбогдох заалтуудыг хяналтад авч, эзэнжүүлэн хуваарилав.

Цагдаагийн ерөнхий газраас хяналтад авч, биелэлт үр дүнг тооцох баримт бичгүүдийн 2021 оны 1-р улирлын байдлаар болон хагас жилийн байдлаар 67 төрлийн албан бичгийн 186 холбогдох заалтын биелэлтийг хугацаанд гаргаж холбогдох газарт хүргүүлсэн байна.

Мөн баримт бичгүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүнг нэмэгдүүлэх, зорилгоор шийдвэр, үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж буй холбогдох алба, нэгжтэй тухайн тасгийн дарга нар байнга холбоотой ажиллаж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнан ажиллаж байна.

Тасгийн дарга болон биелэлт үр дүнг хариуцсан алба хаагчдад баримт бичгийн биелэлт үр дүнг тайлагнахад анхаарах асуудлын талаар Захиргааны удирдлагын тасгийн дарга мэдээлэл хийж, цагдаагийн газрын “Бид нэг хамт олон” хаалттай бүлэгт байршуулсан.

Баримт бичиг, үйл ажиллагааны хэрэгжилтийг цагдаагийн газрын дарга биечлэн хянаж, цахим гарын үсэг зурж, тэмдэг дарж албажуулан холбогдох алба, нэгжид хүргүүлэн ажиллаж байна.

Үүний үр дүнд бичиг баримтын хэрэгжилтийн хугацаа хоцроосон, тайлагнахгүй орхигдуулсан зөрчил гараагүй байна.

1.2. Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, тушаал, шийдвэрийн талаар:

2021 оны хагас жилийн байдлаар Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 18 удаа хуралдаж 153 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн бөгөөд үүнээс хяналт шалгалт буюу албаны шалгалтын талаар 28, алба хаагч нарын сарын ажлын үр дүнгийн талаар 6, алба хаагчийн шагналын талаар 3, хүний нөөц болон

бусад чиглэлээр 113 асуудал тус тус байна. Алба хаагч нарын сарын ажлын үр дүнгээр 2021 оны хагас жилийн байдлаар нийт 39 алба хаагчийн цалинг хасаж, 148 алба хаагчийн цалинг нэмж олгосон байна.

Цагдаагийн газрын даргын тушаалыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан ЦБҮАЖурам /код 136/ журмын дагуу төлөвлөн, тушаалын төслийг тасаг албадын дарга нарт танилцуулан шаардлагатай гэж үзвэл нэмэлт саналыг тусган, хууль эрх зүйн актад бүрэн нийцүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2021 оны эхний хагас жилд Цагдаагийн газрын даргын 43 тушаал буюу байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой 22, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 67 тушаал боловсруулж гарган биелэлтэд нь хяналт тавьж хэрэгжүүлэн ажилласан байна.

Цагдаагийн алба хаагчтай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл, дотоодын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил бүрийг бүртгэн авч албаны шалгалт явуулан, шалтгаан нөхцөлийг тогтоож буруутай этгээдэд хариуцлага тооцох, буруугүй болох нь тогтоогдсон алба хаагчийн талаар нэр төрийг сэргээхэд анхаарч ажиллаж байгаа бөгөөд 2021 оны хагас жилийн байдлаар 28 алба хаагчдад албаны шалгалт явуулахад 43 алба хаагч холбогдон шалгагдсан байна.

Албаны шалгалт явуулсан зөрчлийг хэлбэрээр нь авч үзэхэд Аюулгүй байдлын хэлтэс, ХШҮДАХэлтсийн бусад төрийн байгууллагын хяналт шалгалтаар 5, иргэд аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтнаас гомдол гаргасан буюу мэдээлсэн 17, байгууллагын дотоод хяналт шалгалтаар 6 зөрчил бүртгэгдсэн бөгөөд албаны шалгалтын дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн 3 алба хаагчид сануулах, 6 алба хаагчийн сарын цалинг 3 сар хүртэлх хугацаагаар 20 хувь бууруулах, 2 алба хаагчийг нэг жилийн хугацаанд цагдаагийн албанд эргэж орох эрхгүйгээр халах, 10 алба хаагчид даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр сануулж шийдвэрлэсэн байна. Сахилгын шийтгэл оногдуулсан алба хаагчдыг албан тушаалаар нь авч үзэхэд тасгийн дарга 1, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, хэсгийн цагдаа 2, хилийн төлөөлөгч 1, хэсгийн төлөөлөгч 1, зохицуулагч 1, цагдаа зохицуулагч 1, цагдаа жолооч 1, бусад цагдаа 2 алба хаагч тус тус холбогдон шалгагдсан байна.

Иргэд аж ахуй нэгж байгууллага, алба хаагчдаас удирдах албан тушаалтанд хандаж гаргасан 122 өргөдлийг хүлээн авсан бөгөөд үүнээс ажилд орох, суралцахыг хүссэн 11, ажил өөрчлөх, шилжихийг хүссэн 40, тэтгэвэр, тэтгэмж хүссэн 3, захиргааны чөлөө хүссэн 28, бусад 40 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан байна. Цагдаагийн газрын даргын тушаалаар 2020, 2021 онд сахилгын шийтгэл оногдуулсан нэр бүхий 13 алба хаагчдыг хугацаанаас өмнө сахилгын шийтгэлгүйд тооцсон байна.

1.3. Алба хаагчдын дунд зохион байгуулсан албаны сургалт, түүний үр дүнгийн талаар:

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021 оны албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг алба хаагчдын сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлон дэвшүүлсэн зорилт, хяналтад авч хэрэгжилтийг хангах хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалттай уялдуулан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “сургалтын бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх” /код 118/ журмын 118.11.2 дахь заалтын дагуу 60-80 цагийн багтаамжтайгаар 3.5-5 кредит байхаар тооцон боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2021 оны “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” А/02 дугаар тушаалын хүрээнд Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар нь 2021 онд эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, алба хаагчдын ажлын байранд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газраас 2021 оны хагас жилийн байдлаар албаны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр төлөвлөгөөний дагуу ажлын байр дахь сургалт, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран нийт 69 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 12712 алба хаагч хамрагдсан байна.

Мэдвэл зохих хууль, тогтоомжийн сургалтын талаар:

Шинэ төрлийн коронавирус /Covid-19/-ийн халдвар гарснаас хойш дэлхийн улс орнуудад тархац халдвар нь хурдацтай өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан алба хаагчдыг болзошгүй аюулт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төр засаг, улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд албаны үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр албаны сургалтыг Цагдаагийн газрын “Бид нэг хамт олон” хаалттай группт байршуулж хуваарийн дагуу нийт алба хаагчдад цахим хэлбэрээр сургалтыг зохион байгуулж ажиллалаа. Мэдвэл зохих хууль тогтоомжийн талаар 35 удаагийн 65 цагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 6596 алба хаагч хамрагдсан.

Тус цагдаагийн газраас 2021 оны хагас жилийн байдлаар албаны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр төлөвлөгөөний дагуу ажлын байр дахь эрх зүйн сургалт болон мэдвэл зохих хууль, тогтоомжийн сургалтын чиглэлээр Төрийн албаны тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал, Шинэчлэн батлагдсан сонгуулийн тухай багц хуулийн ойлголт, үзэл баримтлал, Авлигын эсрэг хууль, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмээр Захиргааны удирдлагын тасаг, Цагдаагийн албаны тухай хууль, Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиар Эрүүгийн цагдаагийн тасаг, Зөрчлийн тухай хуулийн ойлголт, Цагдаагийн албаны тухай хуулийн 4, 5 дугаар бүлэг, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаал “Цагдаагийн алба хаагчийг биеийн хүч тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журам”, Цагдаагийн эргүүл харуулын дүрмээр Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Цагдаагийн албаны тухай хуулийн 6 дугаар бүлэг, Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр Шуурхай удирдлагын тасаг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн ойлголт, үзэл баримтлалаар цагдаагийн хошууч Г.Цолмон, цагдаагийн хошууч Ж.Буянтогтох нар, Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Хүний эрхийн тухай ойлголт, үндсэн зарчмаар Мөрдөн байцаах тасаг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар Замын цагдаагийн тасаг хуваарийн дагуу тус тус сургалт зохион байгуулсан.

Сахилга ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр цагдаагийн газрын “Сахилга ёс зүйн зөвлөл”-ийг цагдаагийн газрын даргын тушаалаар байгуулж тус зөвлөлөөс сар бүр соён гэгээрүүлэх ажил, сургалтыг зохион байгуулж, байгууллагын цахим хуудас болон фейсбүүк хаягт байршуулсан. Тус зөвлөлөөс Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар баталсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм” болон “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ээр өврийн ном бэлтгэн 200 ширхгийг хэвлүүлж алба хаагчдад өгч, бие даан суралцах боломжоор хангасан.

Алба хаагчийг хөгжүүлэх сургалтын талаар:

Алба хаагчдын ур чадвар, бие бялдрыг хөгжүүлэх амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2020 онд эхлүүлсэн 420 сая төгрөгийн өртөг бүхий спорт заалны барилгын ажил энэ онд дуусаж, 2021 оны 01 дүгээр сард Улсын комиссоос хүлээн авсан. Тус спорт заал нь иогийн өрөө, алба хаагчдын бие

бялдрыг хөгжүүлэх, биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх сургалт ороход бэлтгэсэн өрөө, танхимтай бөгөөд цахим сургалтад бэлтгэж интернэт, дотоод сүлжээ оруулсан.

Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, сахилга, ёс зүй, харьцаа хандлага, биеэ авч явах соёл, хувь хүний төлөвшил, хөгжлийн түвшнийг ахиулах зорилгоор “Монгол хэл, бичиг, соёлыг уламжлан өвлөх, үндэсний ёс, зан үйлийг танин мэдэх, хэрэглэж занших талаар болон гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх” “Гамшиг аюулаас урьдчилан сэргийлэх нь” “Хүний эрхийн ойлголт” “Авлига гэж юу вэ” “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй хувийн соёл”, “Стрессийг даван туулах арга зам”, “Алба хаагчийн буудлага үйлдэх үеийн дадлага сургуулилт”, “Жагсаал цуглааныг албадан тараах ажиллагаа” зэрэг сэдвүүдээр албаны сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Алба хаагчийг хөгжүүлэх сургалтыг 31 удаагийн 47 цагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 5568 алба хаагч хамрагдсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2021 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөр”-ийн дагуу алба хаагчдад зориулсан шаталсан сэтгэл зүйн сургалтад Өмнөговь аймгийн цагдаагийн газрын алба хаагчид энэ оны 03 дугаар сарын 16-аас 19-ны өдрүүдэд 16.00-17.00 цагийн хооронд алба хаагчдын сэтгэл зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх зорилгоор Тээврийн цагдаагийн албаны ахлах сэтгэл зүйч, цагдаагийн хошууч Э.Бямбажаргалын зохион байгуулсан “Ажлаас халшрах хам шинж, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын 19, Цогтцэций сумын цагдаагийн тасгийн 8 нийт 27 алба хаагч, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн сэтгэл зүйч цагдаагийн хошууч Н.Наранзулын зохион байгуулсан “Удирдлагын манлайлал” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын 17, Цогтцэций сумын цагдаагийн тасгийн 8 нийт 25 алба хаагч, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын чиглэлийн ахлах сэтгэл зүйч, цагдаагийн дэд хурандаа Д.Эрдэнэчимэгийн зохион байгуулсан “Уур бухимдлын менежмент” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын 14, Цогтцэций сумын цагдаагийн тасгийн 9 нийт 23 алба хаагч, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн ахлах сэтгэл зүйч, цагдаагийн хошууч Ж.Эрдэнэцэцэгийн зохион байгуулсан “Цагдаагийн алба хаагчийн харилцаа, ёс зүй, мэргэжлийн онцлогоос шалтгаалах сэтгэл зүйн өөрчлөлт” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын 12, Цогтцэций сумын цагдаагийн тасгийн 12 нийт 24 алба хаагч тус тус хамрагдсан.

Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн сэтгэл зүйч цагдаагийн хошууч Н.Наранзулын зохион байгуулсан “Удирдлагын манлайлал” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын 17, Цогтцэций сумын цагдаагийн тасгийн 8 нийт 25 алба хаагч хамрагдсан.

Нийслэлийн цагдаагийн удирдах газрын чиглэлийн ахлах сэтгэл зүйч, цагдаагийн дэд хурандаа Д.Эрдэнэчимэгийн зохион байгуулсан “Уур бухимдлын менежмент” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын 14, Цогтцэций сумын цагдаагийн тасгийн 9 нийт 23 алба хаагч хамрагдсан.

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн ахлах сэтгэл зүйч, цагдаагийн хошууч Ж.Эрдэнэцэцэгийн зохион байгуулсан “Цагдаагийн алба хаагчийн харилцаа, ёс зүй, мэргэжлийн онцлогоос шалтгаалах сэтгэл зүйн өөрчлөлт” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын 12, Цогтцэций сумын цагдаагийн тасгийн 12 нийт 24 алба хаагч хамрагдсан.

Мерит төслийн хүрээнд зохион байгуулагдсан “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт сургалтад цагдаагийн газрын үйл ажиллагааны тайлан гаргах, нэгтгэх 16 алба хаагч тус сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэн зохих үнэлгээг авч, гэрчилгээ авсан.

Дадлагажуулах сургалтын талаар:

Бичиг хэргийн эрхлэгч бичээч архивч цагдаагийн дэд ахлагч “М.Марал-Эрдэнэ Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хурандаа Ш.Эрдэнэбаяр “Цагдаагийн байгууллага алба хаагчаас албадлагын арга хэмжээ хэрэглэх, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх журам”, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ц.Эрдэнэбаатар “Жагсаал цуглаан албадан тараах” сэдвээр тус тус 1 удаа 2 цагийн цахим сургалтыг тус тус зохион байгуулж давхардсан тоогоор 548 алба хаагч хамрагдсан байна.

Иргэд олон нийтэд чиглэгдсэн сургалтын талаар:

Тус Цагдаагийн газраас иргэд олон нийтэд чиглэгдсэн сургалтыг төрийн болон төрийн бус байгууллага аж ахуй нэгжүүдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт яриа таниулгыг тогтмол зохион байгуулж ажилласан. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Зүрх зогсохгүй”, “Хүчирхийлэлгүй нийгмийг бүтээхэд иргэдийн оролцоо”, “Нууц”, “Бүхнийг хүүхдийн төлөө”, “#Би хариуцлагатай”, “Архины эсрэг хамтдаа” зэрэг аяныг зохион байгуулж 95 удаа сургалт, мэдээлэл сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллагад, уулзалт, ярилцлагыг сургуулийн багш, ажилтан нарт 8 удаа хийж, нийт 1989 иргэнд төрийн болон Төрийн бус байгууллагын алба хаагчид давхардсан тоогоор 1883, хувиараа хөдөлмөр эрхэлдэг 2, малчин 6, оюутан 1, ажилгүй 46 иргэнд 163 цагийн сургалтыг сургалтыг тус тус орсон байна.

“Архи ба амьдрал”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Архинд донтох өвчний үе шатууд” зэрэг 45 минутын видео хичээлийг Насан туршийн боловсролын төвтэй хамтран DVD-д буулгаж Даланзадгад сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус 30 байгууллагын 854 ажилтанд судлуулсан байна. Мөн баривчлах байранд шүүгчийн шийтгэврээр баривчлагдсан нийт 168 иргэн түүнээс согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 123, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 26, өмчлөх эрхийн эсрэг зөрчил үйлдсэн 7, хорио цээрийн дэглэм зөрчсөн 6, хүүхдийн тэтгэмж төлөөгүй 3 иргэн тус бүрд зан үйлд нөлөөлөх бүлгийн ярилцлага болон баривчлагдсан этгээдийн өөрсдийн оролцоотойгоор багт хувааж сонирхолтой хэлбэрээр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Зам тээврийн ослын шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх нь”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт” сэдвээр 3 цагийн сургалтуудыг орж ажилласан.

Соён гэгээрүүлэх чиглэлээр:

Тус Цагдаагийн газраас соён гэгээрүүлэх ажлын 2 зорилтын хүрээнд 14 заалттай салбар төлөвлөгөө боловсруулан хэлтэс, тасаг, хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулан ажиллаж байна.

Цагдаагийн газраас 2021 оны эхний хагас жилд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Соён гэгээрүүлэх ажил зохиох /код 939/ журам”-ын дагуу алба хаагчдын оюун санаа, сэтгэхүйг хөгжүүлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, албаны онцлогоос үүссэн сөрөг нөлөө, сэтгэл зүйн алжаалыг тайлах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын, мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангах зорилгоор зохион байгуулагдаж байгаа Харилцаа хандлага аяны нээлтийн үйл ажиллагааг 2021 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр 12 цагт цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Тус аяны хүрээнд “Харилцаа-Хандлага” нөлөөллийн аян зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хөтөлбөр гарган тус төлөвлөгөөний хүрээнд дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд

- “Харилцаа-Хандлага” нөлөөллийн аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулах салбар төлөвлөгөөг боловсруулан цагдаагийн газрын даргаар батлуулан алба хаагчдад танилцуулж, алба хаагчдын санал хүсэлтийг сонсов.
- Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын судалгааг гарган 2020 оны мөн үетэй харьцуулсан мэдээллийн танилцуулга,
- “Харилцаа-Хандлага” нөлөөллийн аяны лого, таних тэмдэг, баннер бэлтгэх санхүүжилтийг шийдвэрлүүлэн эхийг боловсруулж үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн тухай,
- Сахилга ёс зүйн зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах, тэмдэглэх зорилгоор цагдаагийн газрын тасаг, сум дундын цагдаагийн хэлтэс, сум дахь тасаг, хэсгүүдээр аялах дэвтэр, дарцгийг бэлдэн Эрүүгийн цагдаагийн тасаг, Гурвантэс сумын цагдаагийн тасаг, НХЖХТ-т аялуулаад байна.
- “Харилцаа-Хандлага” нөлөөллийн аяныг сурталчилсан агуулга бүхий ширээний дарцгийг газар, тасгийн дарга нарт хүлээлгэн өгөв.
- Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар батлагдсан цагдаагийн алба хаагчийн “Сахилгын дүрэм, Ёс зүйн дүрэм”-ээр бэлтгэсэн энгэрийн дэвтрийг хэвлүүлж алба хаагчдад тараасан.

Харилцаа хандлага аяны хүрээнд Тус цагдаагийн газрын дарга алба хаагчдын гэр бүлийг долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гаригт урьж “Бид нэг гэр бүл” уулзалтыг зохион байгуулж санал хүсэлтийг хүлээн авч ажиллаж байна. Энэхүү арга хэмжээг Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэр, Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу халдвар хамгаалалтын дэглэмийг чанд баримтлан 5-с дээш хүн цуглуулахгүйгээр зохион байгуулж байна.

Гурвантэс сум дахь Цагдаагийн тасагт 2021 оны 01 сарын 14-өөс 18-ны өдрүүдэд Мөрдөн байцаах тасгийн дарга, Цагдаагийн газрын даргаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа С.Батчулууныг урьж оролцуулан тасгийн үйл ажиллагаатай танилцуулан “Албандаа хандах хандлага, анхаарах зүйлс” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан ба тус тасагт ажиллаж байгаа алба хаагч нартай ганцаарчлан уулзуулж шалгаж байгаа хэргүүдтэй болон өрөө сейфийн эмх цэгц, аюулгүй байдал нууцлал, бүртгэл судалгаатай танилцуулж тус бүрд нь зааварчилга, зөвлөмж өгүүлж ажилласан. Мөн 2021 оны 01 сарын 11, 12, 20, 26-ны өдрүүдэд мөрдөгч цагдаагийн ахмад Т.Төгөлдөр, 2021 оны 01 сарын 14-нд мөрдөгч, цагдаагийн ахмад Ц.Мөнхдэлгэр, 2021 оны 01 сарын 25, 27, 28-ны өдрүүдэд мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Баярбат, 2021 оны 02 сарын 02, 03-ны өдрүүдэд мөрдөгч, цагдаагийн ахмад М.Саранчимэг нартай ганцаарчлан уулзуулж, шалгаж байгаа хэргүүдтэй болон өрөө сейфийн эмх цэгц, аюулгүй байдал нууцлал, бүртгэл судалгаатай танилцуулж тус бүрд нь зааварчилга, зөвлөмж өгүүлж биелэлт үр дүнг тооцон ажилласан.

Өмнөговь аймгийн хэмжээнд Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомж, Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 28 дугаар тогтоолоор “Архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, архианаас татгалзсан иргэдийг ажлын байраар хангах бодлого”, 2020 онд бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийн судалгаа, нөхцөл байдлыг аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлд танилцуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор гэмт хэрэг зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Ээлтэй Өмнөговь” хөтөлбөр, аймгийн хууль эрх зүйн хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран “Хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөр зэргийг батлуулан хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд нийт “Мэдэгдэл”, “Шаг”, “Хулгайн тээвэр”, “Судалгаа”, “Сар шинэ-2021”, “Гэрчилгээ”, “Тусгай гэрэл дохио”, “Бид хариуцлагатай жолооч”, “Согтуу”, “Бүхнийг хүүхдийн төлөө”, “Зүрх зогсохгүй”, “Хүчирхийлэлгүй нийгмийг бүтээхэд иргэн бүрийн оролцоо” зэрэг нийт 12 хэсэгчилсэн арга хэмжээний төлөвлөгөө, удирдамжийг боловсруулан газар, хэлтсийн даргаар батлуулж, үр дүнг алба хаагчдад танилцуулж ажилласан.

Монгол улсад Коронавирусын цар тахал тархсантай холбоотойгоор хүний эрхийн сургагч багш ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Эрзориг нь тус цагдаагийн газрын Соён гэгээрүүлэх ажил болон албаны сургалтын цахим хуудас" хаалттай фейсбүүк групп хуудсанд хүний эрхийн үндэсний комиссоос эрхлэн гаргасан "Хүний эрх гэж юу?", "Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх", "Бэлгийн цөөнхийн эрх", "Хүүхдийн эрхийн цахим сургалт"-ын цуврал 1,2,3,4 зэрэг сэдвүүдээр, Мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Батсүх цагдаагийн байгууллагын нэгдсэн систем /system.police.gov/-ийн гарын авлага хэсгийн сургалтын материал хэсгээс сонгуультай холбоотой хэрэг материалыг шалгаж шийдвэрлэх талаар 5 төрлийн видео сургалтыг татан авч гэмт хэрэг, зөрчил шалгах эрх бүхий алба хаагчдад 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдрийн хооронд халдвар хамгааллын дэглэмийг сахиулж танхимын сургалтыг зохион байгуулан тэмдэглэл хөтлүүлж ажилласан.

Соёл, хүмүүжлийн чиглэлээр

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2021 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөр”-ийн дагуу алба хаагчдад зориулсан шаталсан сэтгэл зүйн сургалтад Өмнөговь аймгийн цагдаагийн газрын алба хаагчид энэ оны 03 дугаар сарын 16-аас 19-ны өдрүүдэд 16.00-17.00 цагийн хооронд цахимаар хамрагдлаа.

- Алба хаагчдын сэтгэл зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх зорилгоор Тээврийн цагдаагийн албаны ахлах сэтгэл зүйч, цагдаагийн хошууч Э.Бямбажаргалын зохион байгуулсан “Ажлаас халшрах хам шинж, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын 19, Цогтцэций сумын цагдаагийн тасгийн 8 нийт 27 алба хаагч хамрагдсан.

- Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн сэтгэл зүйч цагдаагийн хошууч Н.Наранзулын зохион байгуулсан “Удирдлагын манлайлал” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын 17, Цогтцэций сумын цагдаагийн тасгийн 8 нийт 25 алба хаагч хамрагдсан.
- Нийслэлийн цагдаагийн удирдах газрын чиглэлийн ахлах сэтгэл зүйч, цагдаагийн дэд хурандаа Д.Эрдэнэчимэгийн зохион байгуулсан “Уур бухимдлын менежмент” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын 14, Цогтцэций сумын цагдаагийн тасгийн 9 нийт 23 алба хаагч хамрагдсан.
- Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн ахлах сэтгэл зүйч, цагдаагийн хошууч Ж.Эрдэнэцэцэгийн зохион байгуулсан “Цагдаагийн алба хаагчийн харилцаа, ёс зүй, мэргэжлийн онцлогоос шалтгаалах сэтгэл зүйн өөрчлөлт” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын 12, Цогтцэций сумын цагдаагийн тасгийн 12 нийт 24 алба хаагч хамрагдсан.

Аймгийн хэмжээнд архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Архины эсрэг хамтдаа” аяныг энэ оны 2 сарын 05-аас 3 сарын хугацаатай зохион байгуулж байна. Тус аяны хүрээнд ажлын байран дээрээ архи согтууруулах ундаа хэрэглэх магадлалтай 3 алба хаагчтай уулзаж сэтгэл зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж цаашид архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх талаар амлалт бичүүлж аянд нэгдүүлсэн.

2021 оны 01 дүгээр сарын 19-ны өдрөөс Захиргааны удирдлагын тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Тусгай салаа, Мөрдөн байцаах тасаг, Шуурхай удирдлагын тасгийн нийт алба хаагчдаас зан чанар тодорхойлох судалгаа, бие биедээ хэрхэн хүндэтгэлтэй байх талаар дасгал ажил, ажлаас халшрах хам шинжээс урьдчилан сэргийлэх зоригор сэтгэлийн үгээ илэрхийлэх сургалтыг зохион байгуулан ажиллаа. Зан чанар тодорхойлох судалгаанд тулгуурлан тасаг тус бүрээс 2-оос доошгүй алба хаагчидтай уулзан ганцаарчилсан болон бүлгийн аргаар сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, урлагийн аргаар сэтгэл зүйн тайвшруулах үйл ажиллагаа зохион байгуулан ажиллалаа.

Цогтцэций сумын цагдаагийн хэлтэс, Ханбогд сумын цагдаагийн тасаг, Гурвантэс сумын цагдаагийн тасаг, Гэрээт цагдаагийн тасгийн нийт 78 алба хаагчдаас зан чанар тодорхойлох сэтгэл зүйн дэлгэрэнгүй судалгаа авч, темпераментыг тодорхойлж цаашид хэрхэн ажиллах төлөвлөгөөг гарган ажиллаа. Мөн алба хаагчдын гэр бүлийн нөхцөл байдлыг тодорхойлох зурган аргаар сэтгэл зүйг оношлох судалгаа авсан.

Алба хаагчдыг стресс бухимдалд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор тус оны 03 дугаар сарын 11-ны өдөр тасаг тус бүр урлагийн аргаар сэтгэл зүйг оношлох сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулав. Сургалтад нийт 56 алба хаагч хамрагдаж тайвширч, өөрийн дотоод сэтгэлтэй ярилцаж, тархиа амраах дасгал ажлыг хийлгэлээ.

“Харилцаа, хандлага” нөлөөллийн аяны хүрээнд арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын салбар төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу алба хаагчдын ажиллах урам зоригийг сэргээх, ажлын стрессийг бууруулах, алхалт гүйлтээр хичээллэхэд уриалах, илүүдэл жингээс урьдчилан сэргийлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж бие бялдрыг чийрэгжүүлэн эрүүл зөв амьдралын дадал хэвшил суулгах зорилгоор “Эрүүлээр дархлаагаа дэмжье” цахим гүйлтийн уралдаан 4 дүгээр сарын 01-ны өдрөөс 4 дүгээр сарын 19-ны хооронд зохион байгуулагдлаа. Оролцогчид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Strava” гүйлтийн аппликэйшны “Өмнөговь цагдаагийн газар” хаалттай группт нэгдсэнээр уралдаанд оролцох боломжтой болсон. Тухайн Оролцогч нь өдөрт хэдэн ч удаа, хаана ч, хэчнээн ч км гүйж боломжтой байсан бөгөөд хурд, хугацаа, орон зай, орчин нөхцөл хамаарахгүй, гүйгээд биед ядралт, цуцалт үүссэн тохиолдолд алхаж болох боломжтой байсан. Уралдаанд нийт 30 гаруй алба хаагч идэвх санаачилгатай оролцож хамгийн хол зам туулсан эхний 3 байрыг шалгарууллаа. Нэгдүгээр байранд - Дотоодын цэргийн Тусгай салааны харуулын дарга, ахмад

Б.Батмагнай нийт 252км гүйж цалингийн 20%, Хоёрдугаар байранд – Дотоодын цэргийн Тусгай салааны харуулчин, дэд ахлагч Б.Мөнхгэрэл 185,12км гүйж цалингийн 15%, Гуравдугаар байранд - Дотоодын цэргийн Тусгай салааны харуулчин, ахлагч С.Чулуунбат 168,18км гүйж цалингийн 10%-аар тус тус шагнуулсан.

Аймгийн хэмжээнд 2 сарын хугацаатайгаар **“Архины эсрэг хамтдаа”** аяныг архидан согтуурах, мансуурах бодистой тэмцэх, архинаас татгалзсан иргэдийг нийгэмшүүлэх ажлын байраар хангах бодлогыг хэрэгжүүлэх, архидан согтуурснаас үүдэлтэй гэмт хэргийг бууруулах, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, согтууруулах ундааны уршиг, мөн чанарыг олон нийтэд таниулж, албан байгууллага хамт олноороо архидан согтуурдаг байдлыг таслан зогсоох, хойч үе, үр хүүхдэдээ үлгэрлэн дуурайх замаар архидан согтуурах явдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргаар удирдамж боловсруулж 8.900.000 төгрөг, аймгийн Засаг даргаар “Архидан согтуурах, мансуурах бодистой тэмцэх, архинаас татгалзсан иргэдийг нийгэмшүүлэх ажлын байраар хангах бодлого”-ын хүрээнд 20.000.000 төгрөгийн төсвийг тус тус шийдвэрлүүлж, “Архины эсрэг хамтдаа” аяны удирдамжийг батлуулж, төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, сумдад аяныг дэмжиж идэвхтэй оролцох талаар Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг даргын нэр дээр үүрэг ажлын чиглэл хүргүүлж ажилласан.

- Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газруудтай хамтран ар гэртээ архидан согтуурдаг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч иргэдийг 1.980.000 төгрөгийн “Сайн дур”-ын эмчилгээнд эрэгтэй 8, эмэгтэй 3 нийт 13 иргэнд архины хордлого тайлах, архины дур буулгах, өвөрмөц эмчилгээ болох архины харшил урвал үүсгэх тосон тараа хийж, сэтгэл заслын эмчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө ганцаарчилсан зөвлөгөөг тус тус өгч ажилласан. Мөн хамтран оролцож буй байгууллагуудыг оролцуулж эмчилгээнд хамрагдсан нийт 13 иргэдтэй чөлөөт ярилцлага зохион байгуулж, батламж, итгэлцлийн гэрээ байгуулсан.

-Аяны хүрээнд тус цагдаагийн байгууллагын “Говийн наран” АА бүлгэмийг үүсгэн байгуулагч Т.Дашцэрэнг оролцуулан архинаас болж алдаж яваа олон залуучуудад сургамж, зөвлөмж, бүлгэмийг орон нутагтаа сурталчилж “Мэлмий” сайтаар “Лонхонд гээгдсэн амьдрал” нэртэй нэвтрүүлгийг хийлгэж олон нийтэд сурталчилж ажилласан. Мөн “Сайн дур”-ын эмчилгээнд хамруулсан 11 иргэнийг тус бүлгэмийн сэтгэл заслын үйлчилгээнд хамруулж байна. Архинаас татгалзаж дээрх эмчилгээнд хамрагдсан ажилгүй 4 иргэнийг Оюу толгойн гэрээт Саппорт сервисес монголиа ХХК-нд ажилд жуулчилж ажилласан.

-Хэсгийн байцаагч нараас хариуцсан багт амьдардаг, архидан согтуурч гэр бүлдээ айдас түгшүүр төрүүлдэг, хүчирхийлэл үйлддэг иргэдийн судалгааг гаргуулж, судалгаанд үндэслэн тухай багт байрлах архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг аж ахуй нэгжүүд архидан согтуурдаг иргэдийг хариуцуулж архинаас татгалзах ажлыг даалгаж, Даланзадгад сумын 8 багийн дунд “Архины эсрэг хамтдаа” челленжийг зарлан тухай багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийг нийгмийн хариуцлагын хүрээнд татан оролцуулж байна.

-Өмнөговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд “Архигүй хамт олон” челленж зарлаж, дарцаг, тайлангийн дэвтэр аялуулж “Архи ба амьдрал”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Архинд донтох өвчний үе шатууд” зэрэг цахим сургалтын материал бэлдэж Даланзадгад сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус 30 байгууллагад DVD

хэлбэрээр хүргүүлэн өнөөдрийн байдлаар 26 байгууллагын 854 ажилтан, алба хаагчдыг сургалтад хамруулсан бүртгэл болон сургалт хийгдэж буй нотломжийн хамт хүлээн аваад байна. Мөн баривчлах байранд шүүгчийн шийтгэврээр баривчлагдсан нийт 71 иргэн түүнээс согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 56, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 13, өмчлөх эрхийн эсрэг зөрчил үйлдсэн 2 иргэн тус бүрт зан үйлд нөлөөлөх бүлгийн ярилцлага болон баривчлагдсан этгээдийн өөрсдийн оролцоотойгоор багт хувааж сонирхолтой хэлбэрээр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Зам тээврийн ослын шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх нь” “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт” сэдвээр сургалтуудыг орж ажилласан.

- “Түмэн итгэлт”, “Ти Жи Эм Си” ХХК-уудтай гэрээ байгуулан, 4 видео шторк, 2 уриалга, 10 ширхэг зурагт постор, фрэйм, ковор, логоны санааг гаргаж тухай компаниудаар хийлгэж, 10 төрлийн 10.000 ширхэг санамж, сэрэмжлүүлгийг хэвлүүлж, тараасан, уриалгыг 984 группэд, шторкуудыг 1157 группэд шэйрлэн түгээгдсэн байх бөгөөд 945.892 хүний хандалт авсан байна.

Цагдаагийн байгууллагын 100 жилийн ойг тохиолдуулан “Зурагт ном бүтээх” ажлын хэсгийг ахмадын зөвлөлийн гишүүдийг оролцуулан цагдаагийн газрын даргын 2021 оны 04-р сарын 19-ний өдрийн А/38 дугаар тушаалаар байгуулж, зурагт номын эхийг баталсан загварын дагуу гарган ажлын хэсгийн хурлаар 2 удаа хэлэлцүүлэн цагдаагийн газрын даргын зөвлөлд танилцуулан эцэслэж, 05-р сарын 15-ны өдөр Мөнхийн үсэг ХХК-ийн борлуулалтын албанд эх бэлтгэлийг хүргүүлсэн. Уг зурагт номд цагдаагийн газрын үүсэл, хөгжил, он дарааллын түүхэн зураг 150 нүүрэнд тавигдсан бөгөөд ахмад-залуу үеийн залгамж, амжилт бүтээлийг сурталчлан харуулсан эмхэтгэл дурсгалын цомог хэлбэртэй болсон нь давуу талтай юм.

“Харилцаа хандлага 2021” нөлөөллийн аяны хүрээнд арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын салбар төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Олон улсын гэр бүлийн өдрийг угтан алба хаагчдын гэр бүлд халуун дулаан уур амьсгал бүрдүүлэх, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, алба хаагчдын ажиллах урам зоригийг сэргээх, тэдгээрийг стресс бухимдалд орохоос урьдчилан сэргийлж дархлааг дэмжих зорилгоор “Бид нэг гэр бүл” арга хэмжээ зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд тасаг тус бүр Ажлын хэт ачаалалтай байгаа алба хаагчийг сонгон ажлын нэг өдөр гэр бүлтэйгээ цагийг өнгөрүүлэх, хүнс витаминь дэмжлэг тусламж үзүүлэх зэрэг тухайн хүнд тохирсон үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. Тухайн арга хэмжээнд нийт 7 алба хаагч хамрагдсан.

Алба хаагчдын идэвх, санаачилгыг дээшлүүлэх, идэвхжүүлэх чиглэлээр

Олон улсын гэр бүлийн өдрийг угтан алба хаагчдын гэр бүлд халуун дулаан уур амьсгал бүрдүүлэх, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор “Эерэг харилцаа амжилтын үндэс” ил захидлын аян зохион байгууллаа. Аяны хүрээнд газрын дарга, тасгийн дарга нар алба хаагч тус бүрт зориулсан талархлын ил захидал бичиж тэдгээрийн гэр бүлд баярын мэндчилгээ гарын бэлгийн хамт хүргүүлж нийт 86 гэр бүл ил захидал хүлээн авсан.

Тус цагдаагийн газрын дарга алба хаагчдын гэр бүлийг долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гаригт урьж “Бид нэг гэр бүл” уулзалтыг зохион байгуулж санал хүсэлтийг хүлээн авч ажиллаж байна. Энэхүү арга хэмжээг Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэр, Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу халдвар хамгаалалтын дэглэмийг чанд баримтлан 5-аас дээш хүн цуглуулахгүйгээр зохион байгуулж байна.

Тус цагдаагийн газрын Соён гэгээрүүлэх ажил болон албаны сургалтын цахим" хаалттай фейсбүүк групп хуудсанд сэтгэл зүйч, цагдаагийн дэслэгч Э.Сувданчимэг Америкийн нэгдсэн улс болон, Герман улсад хэрхэн тэтгэлэгтэй суралцах талаар 2 төрлийн видео сургалтыг байршуулж алба хаагчдад сурталчилж ажилласан. Мөн Турк, Япон, Израйль улсын цагдаагийн байгууллагын бүтэц зохион байгууллагын талаар танилцуулга мэдээллийг байгууллагын хаалттай группт байршуулж алба хаагчдад танилцуулж ажилласан.

"Нэг санаа нэг зорилго" аяны хүрээнд тус цагдаагийн газрын эмэгтэйчүүдийн зөвлөлөөс Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны код-917-г хэрэгжүүлж, алба хаагчдыг цагдаагийн дүрэмт хувцсыг дүрмийн дагуу цэвэр цэмцгэр үзэмжтэй өмсөж хэрэглэх журмын хэрэгжилтийг хангах ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор энэ оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 03 дугаар сарын 08-ны өдрийн хооронд "Дүрэмт хувцсаа дүрмийн дагуу өмсөж хэрэглэе" аяныг зохион байгууллаа. Тус аяны хүрээнд эмэгтэй алба хаагчид өдөр бүр дүрмийн зөрчил дутагдалтай хувцасласан алба хаагчдын зургийг авч баримтжуулан байгууллагын хаалттай групп болох "Бид нэг хамт олон" хуудсанд байршуулснаар алба хаагчдын зөрчил дутагдал арилж хувцсаа цэвэр цэмцгэр, үзэмжтэй өмсөх болсон

1.4. Алба хаагчдын нийгмийн асуудал, үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ:

Гамшгийн нөхцөл байдалд ажиллах алба хаагчдын аюулгүй байдлыг хангахад шаардлагатай 80 ширхэг 799,200 төгрөгийн үнэлгээтэй хамгаалах хувцас, нэг удаагийн амны хаалт/макс/ 7000 ширхэг, амны хаалт /N-95/ 150 ширхэг, нэг удаагийн малгай 200 ширхэг, гар ариутгагч цацлага 50 ширхэг, 1 литрийн гар ариутгагч 10 литр, автомакс 1 ширхэг, жавалин 3 ширхэгийг Цагдаагийн ерөнхий газраас хүлээн авсан.

Цагдаагийн газрын санхүүжилтээр нэг удаагийн бээлий 500 ширхэг, ариултгалын бодистой халуун хэмжигч 2 ширхгийг тус тус худалдан авч, ашиглаж байна.

Тус цагдаагийн газрын нийт 189 алба хаагч буюу 77,8 % хувийг коронавирусын эсрэг дархлаажуулалтын вакцинд хамруулсан бөгөөд дархлаажуулалтын вакцин хийлгэхэд эрүүл мэндийн харшлах шалтгааны улмаас эмчийн заавраар 12 алба хаагчид вакцин хийгээгүй байна. Коронавирусын PCR-ын шинжилгээнд 114 алба хаагч хамрагдсан байна.

1.5. Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар уламжлан шийдвэрлүүлсэн ажил, арга хэмжээний талаар:

2021 оны аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд цагдаагийн газарт тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авахад 80 сая төгрөг, Цогтцэций чиглэлийн автозамд хяналтын камер суурилуулахад 100 сая төгрөг, автомашины парк шинэчлэл хийхэд 114 сая төгрөг, Баяндалай чиглэлийн авто замд хяналтын пост байгуулахад 80 сая төгрөг тусгуулан 2021 оны 1-р улиралд аймгийн Худалдан авах ажиллагааны газраас тендерийг зарлаад байна. Мөн Даланзадгад сум хотыг хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөнд 1 автомашин шийдвэрлүүлэхээр 24 сая төгрөг тусгуулсан боловч цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хойшлуулаад байна.

1.6. Цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бусад төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, хугацаа, үр дүн:

Төсөл, хөтөлбөр байхгүй.

1.7. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 49 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэхээр, Алба хаагчдыг гэмт хэрэг, зөрчил, хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 18 заалттайгаар, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын авлигын эрсэг сүлжээнээс Монгол улсад өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 16 заалттай боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан цагдаагийн алба хаагчийн хориглох зүйлээр нийт алба хаагчдаас, авлигыг үл тэвчих ёс зүйтэй болон шударга ёсыг эрхэмлэн ажиллах баталгааг гэрээт цагдаагийн хэлтсийн алба хаагчдаас гаргуулан авсан.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 20 дугаар тогтоолын хавсралтад заагдсан Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудын 2019 оны ХОСХОМ-ийг <https://meduuleg.iaac.mn> цахим системд бүрэн оруулж баталгаажуулсан.

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллага, алба хаагч нартай холбоотой гомдол мэдээлэл, санал хүсэлтүүдийг тухай бүр хүлээн авч, мөн цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүй, авлига, хээл хахууль, хүнд суртал, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээллийг Цагдаагийн ерөнхий газрын 126 дугаарын тусгай утсаар 24 цагаар хүлээн авч буй талаар иргэд олон нийтэд мэдээлэл хийж, энэ талаарх зурагт хуудсыг цагдаагийн газрын иргэдийг хүлээн авах танхимд байршуулсан.

Тус цагдаагийн газрын Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн цагдаа, зохицуулагчаар ажиллаж байсан Т.Хашбат нь 2019 онд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон иргэнд давуу байдал олгож, 400 мянган төгрөгийн хахууль авсан үйлдэлд эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4.4, 25.5.1 дэх хэсэгт зааснаар нийтийн албанд томилогдох эрхийг 5 жилийн хугацаатай хасаж, 10 сая төгрөгийн торгууль ногдуулсан бодит нөхцөл байдлыг алба хаагчдад танилцуулан кэйс өгч, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөө, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын авлигын эрсэг сүлжээнээс Монгол улсад өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг 2021 оны эхний хагас жилийн байдлаар гарган Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

1.8. Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаар:

Тус Цагдаагийн газарт 2021 оны эхний хагас жилд цагдаагийн алба хаагчтай холбоотой 22 гомдол, мэдээллийг иргэд байгууллагаас ирүүлсэн ба нийт 38 алба хаагч холбогдсон байна. Гомдол мэдээллийг төрлөөр нь авч үзвэл Хууль ёс, хүний эрх, эрх чөлөө зөрчсөн 5, хэрэг материал дутуу шалгасан 3, бусдыг чирэгдүүлж танил тал харсан 2, ЦАХ-ын харилцааны соёл, ёс зүй зөрчсөн 7, архи дан согтуурсан 2, ЭХХШТХ болон бусад хууль, дүрэм зөрчсөн 3, бусад 3 байна. Тухайн гомдол мэдээлэл бүрийг хүлээн авч бүртгэлд оруулж, холбогдох албан тушаалтан албаны шалгалт явуулж хариуцлага тооцон хуулийн хугацаанд шийдвэрлэн гомдол гаргагчид хариуг 100 хувь бичгээр өгч ажилласан. ЦЕГ-ын 126 дугаарын утсанд 5 алба хаагчдад, иргэд аж ахуй нэгж байгууллагаас 7 алба хаагчдад гомдол мэдээлэл ирж албаны шалгалт явагдаж шийдвэрлэгдсэн. 2021 онд авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл, ирээгүй. Гомдол мэдээлэл бүрийг хүлээн авч бүртгэлд оруулж, холбогдох албан тушаалтан албаны шалгалт явуулж, 1 алба хаагчид “Сарын үндсэн цалинг бууруулах”, 1 алба хаагчид “Сануулах” сахилгын шийтгэл оногдуулж, 2 алба хаагчид хугацаатай үүрэг чиглэл өгч, 3 алба хаагчид холбогдох гомдол нотлогдоогүй үндэслэлээр тус тус хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагаатай холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдлыг 100 хувь хуулийн хугацаанд шалгаж, шийдвэрлэн хариуг өгсөн.

Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, тэдгээрийн шийдвэрлэлтийн мэдээг сар бүрийн 25-ны дотор ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

1.9. Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын, мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангах зорилгоор зохион байгуулагдаж байгаа Харилцаа хандлага аяны нээлтийн үйл ажиллагааг 2021 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр 12 цагт цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Тус аяны хүрээнд “Харилцаа-Хандлага” нөлөөллийн аян зохион байгуулах ажлын төлөвлөгөө, хөтөлбөр гарган тус төлөвлөгөөний хүрээнд дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд

➤ “Харилцаа-Хандлага” нөлөөллийн аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулах салбар төлөвлөгөөг боловсруулан цагдаагийн газрын даргаар батлуулан алба хаагчдад танилцуулж, алба хаагчдын санал хүсэлтийг сонсов.

➤ Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын судалгааг гарган 2020 оны мөн үетэй харьцуулсан мэдээллийн танилцуулга,

➤ “Харилцаа-Хандлага” нөлөөллийн аяны лого, таних тэмдэг, анонс, баннер бэлтгэх санхүүжилтийг шийдвэрлүүлэн эхийг боловсруулж үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн тухай,

➤ Сахилга ёс зүйн зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах, тэмдэглэх зорилгоор цагдаагийн газрын тасаг, сум дундын цагдаагийн хэлтэс, сум дахь тасаг, хэсгүүдээр аялах дэвтэр, дарцгийг бэлдэн Эрүүгийн цагдаагийн тасагт гардуулсан.

➤ “Харилцаа-Хандлага” нөлөөллийн аяныг сурталчилсан агуулга бүхий ширээний дарцгийг газар, тасгийн дарга нарт хүлээлгэн өгөв.

➤ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/129 дүгээр тушаалаар батлагдсан цагдаагийн алба хаагчийн “Сахилгын дүрэм, Ёс зүйн дүрэм”-ээр бэлтгэсэн энгэрийн дэвтрийг хэвлүүлж алба хаагчдад тараасан.

“Харилцаа-Хандлага” нөлөөллийн аяны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах танхим тохижуулж, индэр засан интернэт сүлжээний бэлтгэж ажлыг ханган нийт бие бүрэлдэхүүнд танилцуулав.

Цагдаагийн газрын хамт олон өөрсдийн сахилга, хариуцлагын байдлаа дүгнэн хэлэлцэх, алдаа дутагдлыг нөхөр ёсны шүүмжлэл, зөвлөмж, хүсэлтээр илэрхийлэн засах, амжилт ололттой зүйлээ хэлэлцэх, цаашид сахилга ёс зүйн зөрчил, дутагдалгүй эвсэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор 2021 оны нэгдүгээр улирлын сахилга, хариуцлагын зөвлөгөөнийг “Сахилга ёс зүйн зөвлөл”-өөс “Харилцаа-Хандлага” нөлөөллийн аянтай хамтатган цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Тус зөвлөгөөнийг 2021 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулж төвийн алба хаагчид болон сум дундын цагдаагийн хэлтэс, тасаг, Гэрээт цагдаагийн хэлтэс, хэсгийн төлөөлөгч, цагдаа нар бүрэн хамрагдсан.

Зөвлөгөөний хүрээнд Сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын судалгааг гарган 2020 оны мөн үетэй харьцуулсан мэдээллийг бие бүрэлдэхүүнд танилцуулж, сахилга ёс зүйн зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх ажил, шинэлэг арга хэмжээ зохион байгуулах, тэмдэглэх зорилгоор цагдаагийн газрын тасаг, сум дундын цагдаагийн хэлтэс, сум дахь тасаг, хэсгүүдээр аялах дэвтэр, дарцгийг бэлдэн Эрүүгийн цагдаагийн тасагт гардуулан аялах хуваарийг танилцуулав. Аялах дэвтэр, дарцаг Гурвантэс сум дахь цагдаагийн тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст аялан Мөрдөн байцаах тасагт хуваарийн дагуу шилжээд байна.

2021 оны эхний хагас жилд тус Шуурхай удирдлагын тасгаас дараах ажлуудыг шинээр санаачилж хийсэн нь сайшаалтай байна. Үүнд:

Аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн судалгааг 7 хоног бүр хийж гэмт хэрэг зөрчил олноор үйлдэгдсэн багийн хэсгийн байцаагчид 7 хоног тутам “Зөвлөмж” хүргүүлэх, эргүүлийн маршрутад өөрчлөлт оруулах, эрүүлжүүлэгдсэн иргэдийн эрүүлжүүлэхийн төлбөрийг бүрэн төлүүлэх, сангийн баяжилтад тогтмол хяналт тавих чиглэлээр доголдож байгаа цаашид анхаарах ажлын мэдээлэл хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Цагдаагийн газрын хэмжээнд алба хаагч нарыг ковид-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийг байгууллагад нэвтрэхэд нь алба хаагч нартай холилдуулахгүй өөр хаалгаар оруулж гаргах, өргөдөл гомдол авч ирсэн иргэдийг байгууллага дотор олон алба хаагчийн өрөөнд оруулахгүй зөвхөн мэдээлэл судалгааны мэргэжилтнүүд иргэдээс хайрцгаар хүлээн авч бүртгэн цохолт хийлгэсний дараа шалгах алба хаагчид хүлээлгэж өгөх, алба хаагч нарын 2 цаг тутам хоолой ам зайлах “Сода”-ын уусмал бэлтгэж байршуулах, жижүүрийн орчинд өдөр бүр жавилины уусмалаар ариутгал хийх, тасгийн алба хаагч нарыг витаминжуулсан байна.

1.10. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр:

Тус цагдаагийн газар нь 2021 оны эхний хагас жилийн байдлаар бараа үйлчилгээний зардалд 1.441.850,9 сая төгрөг, цалин хөлс нэмэгдэл урамшилд 1.248.693,2 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 55,4 сая төгрөг, ХХОАТатвар

105,7 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 47,4 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 85,3 сая төгрөг, норматив зардалд 17,3 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 12,7 сая төгрөг, дотоод томилолтын зардалд 2,6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 706,2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 821,1 мянган төгрөг, Гэрээт цагдаа, Олон нийтийн цагдаагийн санхүүжилтэд бараа үйлчилгээний зардалд 606,7 сая төгрөг, цалин хөлс нэмэгдэл урамшилд 507,1 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 37,1 сая төгрөг, ХХОАТатварт 40,9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 25,7 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 4,1 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 23,4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 621,1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1.550,1 сая төгрөг тус тус зардлуудыг тооцож зарцуулсан байна.

Торгууль, шийтгэлийн хуудас, галт зэвсгийн гэрчилгээний талаар: Хагас жилийн байдлаар 69 алба хаагч 625 ширхэг торгуулийн хуудас авч, 460 ширхэг торгуулийн хуудасны тооцоо хийн 725,5 сая төгрөгийг дансанд оруулсан. Алба хаагч нарын гар дээр 525 ширхэг торгууль шийтгэлийн хуудасны үлдэгдэлтэй байна. Хэв журмын тасгаас 53 иргэнд галт зэвсгийн гэрчилгээ олгон 519,4,0 мянган төгрөгийн төлбөрийн тооцоог хийн дуусгасан.

Автомашинны шатахууны тайлан тооцоо: Цагдаагийн газрын хэмжээнд аймаг болон сумдын хэлтэс, тасаг хэсгийн төлөөлөгч нар 40 гаруй автомашины дуудлага, мэдээлэл томилолтоор явахад нийт 67,2 сая төгрөгийн шатахууныг олголоо. Автомашин бүрд шатахууны картыг газар, хэлтэс, тасаг, сумдын хэсгийн төлөөлөгч нарт нэг бүрчлэн автомашины шатахууны нормыг сараар тооцон газрын даргаар батлуулж, автомашины картуудыг орон зайнаас үл хамааран цэнэглэж тухай бүр орлого зарлагыг хянаж байна. Үндсэн хөрөнгө, бараа материал, эд хөрөнгийн бүртгэл тооцоо: Алба хаагчид нийт 45,2 сая төгрөгийн бичиг хэрэг, шуудан холбоо, аж ахуйн, хэвлэл мэдээлэл, хичээл сургалт, урсгал засварын материалуудыг хүлээн авч зарцуулсан байна. Энэ улиралд нийт 68,4 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө орлого авч 62,5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж данс бүртгэл хөтөлсөн.

Автомашинны урсгал засварын талаар: Аймаг, сумдын хэлтэс, тасаг, хэсгийн төлөөлөгч нарын автомашинд нийт 12,3 сая төгрөгийн тос тосолгооны материал, сэлбэг хэрэгсэл, засвар хийлгэв. Албан ажилд явж байгаа автомашинд үйлчилгээ хийхэд автомашины картыг хэрхэн хөтөлснийг үндэслэх мөн техникийн комиссын дүгнэлт гарсан тохиолдолд үйлчилгээ хийх зардлыг шилжүүлэх ажлыг зохион байгуулж хэвшсэн.

Цалингийн талаар: Хагас жилийн байдлаар нийт 38 алба хаагчийн цалинг 2,4 сая төгрөгөөр хасаж, 106 алба хаагчийн цалинг 17,3 сая төгрөгөөр нэмж тус тус тооцож олгосон. Алба хаагчдын цалинг аль болох нээлттэй хэлбэрт шилжүүлж цалин олгох бүрд алба хаагч нарт цахимаар /мэйл хаягаар/ цалингийн мэдээлэл дэлгэрэнгүйгээр явуулдаг. Халагдсан алба хаагчдын хувцасны тооцооны талаар: Ажлаас халагдсан 10 алба хаагчийн хувцасны 6,3 сая гаруй төгрөгийн тооцоо байсныг төлбөр барагдуулах арга хэмжээ зохион байгуулж хаяг тодорхойгүй 5 алба хаагчийг Улсын бүртгэлийн хэлтсээс оршин суугаа лавлагааг гаргуулан аймаг болон Улаанбаатар хот дүүргүүдийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд өгч, бусад алба хаагч нартай төлбөр барагдуулах талаар удаа дараалан холбогдож 4 алба хаагчийн 956,1 мянга гаруй төгрөгийн хувцасны төлбөр барагдуулж, 1 алба хаагчийг 1,1 сая төгрөгийн төлбөрийг албадан гаргуулахаар шүүхэд хандаж захирамж гаргуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт материалыг бүрдүүлэн өгсөн.

Эрүүлжүүлэх баривчлах байрны төлбөр тооцоо: Эрүүлжүүлэгдсэн 408 иргэний 1,7 сая төгрөгийн шүүхээр баривчлагдсан 147 иргэний 7,6 сая төгрөгийн тооцоог тус тус эмч нартай хийсэн.

Байгууллагуудтай тооцоо нийлсэн байдал: Хагас жилийн байдлаар ЦЕГ-ын харьяа байгууллагуудаас 33,8 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө шилжүүлэн авч мөн халаалт дулаан, гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, бичиг хэрэг, аж ахуй материал, урсгал засвар, шуудан холбооны үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, НДШ, татвар гэх мэт харилцагч төрийн болон иргэн аж ахуй нэгжүүдтэй тооцоо нийлсэн.

Алба хаагчдад шөнийн ээлжийн хоол олгох талаар: Шөнийн ээлжид 24 цагаар ажиллаж байгаа хэлтэс, тасаг, тусгай салааны алба хаагч нарын судалгааг алба хаагчдын ажилласан хоногийн хуваариудыг нэг бүрчлэн нэгтгэн гаргуулан тооцоо хийн 27,6 сая төгрөгийн хоолны мөнгийг тооцож баримтжуулан олгосон.

Шилэн дансны талаар: Санхүүгийн тайлангийн холбогдох ажлуудыг цахим хэлбэрээр олон нийтэд тухай бүр 40 удаа, сар бүр 15 удаа, улирал бүр 1 удаа тус тус нийт 1,887.2 сая төгрөгийн орлого, 166,6 сая төгрөгийн зарлагын мэдээллийг цаг тухайд нь гарган мэдээлсэн.

1.11. Хүний нөөцийн чиглэлээр:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Орон нутгийн замын хяналтын хэлтсийн Гэрээт цагдаагийн хэлтэс /Гашуун сухайт/-ийг Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын харьяанд нийт 41 алба хаагчийг шилжүүлсэн байна. Тус Цагдаагийн газар нь удирдлага /офицер-4/, Эрүүгийн цагдаагийн тасаг /офицер-8, ахлагч-1, бүгд 9/, Мөрдөн байцаах тасаг /офицер-6/, Захиргааны удирдлагын тасаг /офицер-5, ахлагч-7, энгийн-2, бүгд-14/, Нийтийн хэв журам хамгаалах тасаг /офицер-12, ахлагч-12, бүгд-24/, Замын цагдаагийн тасаг /офицер-7, ахлагч-2, бүгд-9/, Тусгай салаа /офицер-5, ахлагч-9, нийт-14/, Шуурхай удирдлагын тасаг /офицер 7, ахлагч 3, бүгд 10/, Цогтцэцийн сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс /офицер-23, ахлагч-6 бүгд-29/, Ханбогд сум дахь цагдаагийн тасаг /офицер 17, ахлагч 9, бүгд 26/, Гурвантэс сум дахь цагдаагийн тасаг /офицер 8, ахлагч 2, бүгд-10/, Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа /офицер 13, ахлагч 11, бүгд 24/, Гэрээт цагдаагийн хэлтэс /Гашуун сухайт/ / офицер 35, ахлагч 6, бүгд 41/ буюу нийт 225 орон тоотойгоор ажиллаж байна.

Цагдаагийн газар нь үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, ил тод байлгах, оролцогч бүрийг ижил тэгш мэдээллээр хангах, асуудлыг шударгаар шийдвэрлэх зорилгоор цагдаагийн байгууллагад орж ажиллахаар хүсэлтээ гаргасан иргэдийг судлах, зэрэг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдолтой эрх зүйн актуудыг байгууллагын веб хуудсанд байршуулснаар иргэд хүссэн үедээ шаардлагатай мэдээллийг чөлөөтэй авах боломжтой боллоо. Цагдаагийн байгууллагад ажилд орохоор хүсэлт гаргасан 31 иргэнийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/” журам, “Хүний нөөцийн судлах, ажилд томилох /код 901/” журмын дагуу эрүүл мэнд, бие бялдар, мэдлэг боловсрол, мэргэжлийн түвшин, ахуй амьдрал, амьжиргааны түвшин, ял шийтгэлийн байдлыг тогтоох зорилгоор судалгааны ажлыг чанартай явуулахад анхаарч “Цагдаагийн албанд ажилд орох, суралцахыг хүссэн иргэний бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт”, “Цагдаагийн байгууллагад ажилд орохыг хүссэн иргэний тухай мэдээлэл”, “Эрүүл мэндийн үзлэг”, иргэний боловсролын түвшин, Сэтгэл зүйн түвшинг тогтоох сорил, дүгнэлт зэргийг гаргуулах ажлыг удирдан зохион байгуулан ажиллав.

Цагдаагийн газарт сул орон тоо гарсан даруйд Төрийн албаны тухай хуулийн дагуу одоо ажиллаж байгаа алба хаагчдаас ажлын үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон

шалгаруулж томилох, цагдаагийн байгууллагад ажиллах хүсэлтээ гарган журмын дагуу судлагдаж, нөөцөд бүртгэгдсэн иргэдийн хувийн хэрэг, материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлж Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаа дотоодын цэргийн албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”-ын дагуу шалгалтад оруулж тэнцсэн иргэдийг зөвшөөрлийн дагуу томилох зэргээр хүний нөөцийн нөхөн хангалтыг хийж байна. Энэ хугацаанд дээрх журмын дагуу судлагдсан 31 иргэнийг мэргэшлийн шалгалтад оруулахаар материалыг бүрдүүлж, шалгалтад 17 иргэн тэнсэн бөгөөд цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан тус цагдаагийн газарт сургалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагыг мэргэшсэн тогтвортой боловсон хүчнээр тасралтгүй хангах, алба хаагчдыг сургаж дадлагажуулах, ажиллах амьдрах нөхцөл бололцоог хангах зорилгоор тус Цагдаагийн газраас Хууль сахиулахын их сургуулийн эчнээ ангид жил бүр алба хаагчдыг элсүүлэн сургаж байгаа бөгөөд 2021 оны эхний хагас жилийн байдлаар байдлаар Дотоод хэргийн их сургуулийн эчнээ ангийг 1 алба хаагч суралцаж төгссөн ба магистрын ангид 1, удирдлагын сургуульд 1 алба хаагч тус тус суралцаж байна.

Тус Цагдаагийн газарт 2021 оны эхний хагас жилд шинээр цагдаагийн үндсэн албанд томилогдсон алба хаагч 13 байна. Цагдаагийн ерөнхий газрын Төрийн албаны салбар зөвлөлийн 2020 оны Б/11, 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Б/01 тогтоолоор Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд орох иргэдийн нөөцөд бүртгэгдсэн Ц.Ган-Эрдэнэ, Э.Бумбаяр нарыг Ханбогд сум дахь цагдаагийн тасгийн /гэрээт/ эргүүлийн цагдаагаар, О.Эрдэнэ-Очирыг тус тасгийн /гэрээт/ эргүүлийн цагдаагаар, Г.Буяндэлгэрийг тус тасгийн харуулын цагдаагаар, Б.Сармандахыг Цогт-Овоо сум дахь хэсгийн цагдаагаар, С.Эрдэнэ-Очирыг НХЖХТ-ийн эрүүлжүүлэх саатуулах байрны эмчээр, Б.Бэхтулгыг тус тасгийн хамгаалалтын цагдаагаар, Б.Алтангэрэлийг тус тасгийн харуулын цагдаагаар, А.Батсуурийг тус тасгийн Монгол банкны /гэрээт/ харуулаар, А.Найданхүүг Шуурхай удирдлагын тасгийн мэдээлэл хүлээн авагч, жижүүрийн цагдаагаар, Н.Мөнхбатыг Ханхонгор сум дахь хэсгийн цагдаагаар, У.Бат-Өлзийг Баян-Овоо сум дахь хэсгийн цагдаагаар тус тус томилогдсон. Дотоод хэргийн их сургуулийн “Цагдаа-ажил эрх зүй” ангийг төгссөн М.Цэцмагнай нь Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн хэсгийн төлөөлөгчөөр томилогдсон байна.

Цагдаагийн ахмад Т.Эрдэнэцэцэгийн хүүхэд асрах чөлөөг цуцалж Нийтийн хэв журам хамгаалах тасгийн хэсгийн байцаагчийн албан тушаалд, цагдаагийн дэслэгч С.Эрдэнэбулганы хүүхэд асрах чөлөөг цуцалж тус тасгийн эрүүлжүүлэх саатуулах байрны эмчээр томилсон.

Чиглэлийн ахлах, ахлах болон офицерын албан тушаалд дэвшин томилогдсон нийт 9 алба хаагч буюу офицер 3, ахлагч 6 байна. Үүнээс төрийн тусгай албанд ажиллаж байсан ахлагч бүрэлдэхүүнээс офицер албан тушаалд дэвшин томилогдсон 6 алба хаагч буюу хүний нөөцийн хэрэг хөтлөгч, цагдаагийн дэд ахлагч Э.Сувдаа тус цагдаагийн газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнээр, НХЖХТ-ийн харуулын цагдаа, цагдаагийн дэд ахлагч Н.Самданцоодолыг тус тасгийн хэсгийн байцаагчаар, С.Эрдэнэ-Очирыг НХЖХТ-ийн эрүүлжүүлэх саатуулах байрны эмчээр, Шуурхай удирдлагын тасгийн мэдээлэл хүлээн авагч жижүүрийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Д.Алтанхүү, Гэрээт цагдаагийн хэлтэс /Гашуун сухайт/-ийн цагдаа зохицуулагч, цагдаагийн дэд ахлагч Э.Уртнасан тус цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн зохицуулагчаар, Гэрээт цагдаагийн хэлтэс /Гашуун сухайт/-ийн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч Б.Дашцэнд тус хэлтсийн зохицуулагчаар, Тээврийн цагдаагийн албаны Хяналт шалгалтын тасгийн дарга, цагдаагийн хурандаа Л.Эрдэнэбулган нь Гэрээт цагдаагийн

хэлтсийн даргаар, тэс хэлтсийн ахлах зохицуулагч Э.Нэмэхбаяр нь тус хэлтсийн чиглэлийн ахлах зохицуулагчаар, Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Б.Диваажигмэд нь тус хэлтсийн эрүүгийн цагдаагийн хэсгийн даргаар тус тус томилогдсон. Мөн 2 алба хаагч буюу Баяндалай сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч П.Эрхэмбаатар нь Замын цагдаагийн зохицуулагчаар, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Т.Батцэцэг нь тус тасгийн хэсгийн байцаагчаар урьд эрхэлж байсан албан тушаалд томилогдсон.

Мөн төрийн болон төрийн тусгай албанд ажиллаж байсан буюу бусад байгууллагаас шилжин ирж ажилласан 1 алба хаагч буюу Автобаазын цагдаа жолооч, цагдаагийн дэд ахлагч Э.Баярмөнх, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын Нийслэлийн замын хөдөлгөөн зохицуулах хэлтсийн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Т.Төмөрчөдөр нар нь Гэрээт цагдаагийн хэлтэс /Гашуун сухайт/-ийн цагдаа зохицуулагчаар, Улаанбаатар хотын 068-р цэргийн ангийн хуулийн офицер Д.Буянбазар нь Цогтцэций сум дахь цагдаагийн хэлтсийн хэсгийн байцаагчаар томилогдсон байна.

2021 оны эхний хагас жилд урьд эрхэлж байсан албан тушаалд томилогдсон, шинээр албан тушаалд томилогдсон хугацааны болон албан тушаалд дэвшин томилогдсон нийт 41 алба хаагчдад буюу цагдаагийн дэд ахлагч цол 11 /О.Эрдэнэ-Очир, Ц.Ган-Эрдэнэ, Б.Сармандах, Б.Бэхтулга, Б.Алтангэрэл, Б.Буяндэлгэр, А.Найданхүү, Н.Мөнхбат, У.Бат-Өлзий, А.Батсуурь, Э.Бумбаяр/, цагдаагийн ахлагч цолоор 4 /Б.Дөлгөөн, Г.Сүхболд, Э.Тэргүүн, М.Түмэндэлгэр/, цагдаагийн дэслэгч цол 12 /Н.Самданцоодол, С.Эрдэнэ-Очир, Э.Сувдаа, Д.Алтанхүү, Э.Уртнасан, Э.Хосбаяр, Ж.Сүрэнжаргал, Э.Сувданчимэг, П.Эрхэмбаатар, Б.Дашцэнд, Т.Батцэцэг, М.Цэцмагнай/, цагдаагийн ахлах дэслэгч цол 2 /Б.Ганболд, Х.Еркин/, цагдаагийн ахмад цол 3 /Д.Буянбазар, П.Нанчинбат, Г.Жавхлан/ цагдаагийн хошууч цол 9 /Т.Түмэнжаргал, Б.Түвшинтөр, У.Ууганбаяр, Ц.Энхманлай, Б.Билгүүн, Г.Өнөрбаяр, Ж.Буянтогтох, Э.Нэмэхбаяр, Б.Батзаяа/ алба хаагчид олгогдсон байна.

Шагнагдсан алба хаагчдын талаар: 2021 оны эхний хагас жилд Цагдаагийн ерөнхий газрын шагналаар 3, Төрийн одон, медалиар 3, Биеийн тамир спортын улсын хорооны шагналаар 1 алба хаагч шагнагдсан тус тус байна.

Цагдаагийн байгууллагад тогтвор суурьшилтай, олон жил идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй ажиллаж байгаа тус цагдаагийн газрын нярав Н.Чулуунцэцэг, Эрүүгийн цагдаагийн тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Г.Өнөрбаяр нар “Цагдаагийн гавьяа” тэмдгээр, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн харуулын цагдаа, цагдаагийн ахлагч М.Ширнэн нь “Спортын алдар” тэмдгээр, Гэрээт цагдаагийн хэлтэс /Гашуун сухайт/-ийн дарга, цагдаагийн хурандаа С.Сүхбаатар “Цэргийн гавьяаны одон”-оор, тус цагдаагийн газрын ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Г.Батбилэг, Шуурхай удирдлагын тасгийн жижүүрийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Д.Гантулга “Цэргийн хүндэт медаль”-аар, Замын цагдаагийн тасгийн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч М.Түмэндэлгэр “Монгол улсын спортын мастер” цолоор тус тус шагнагдсан байна.

Тэтгэмж олгогдсон алба хаагч нарын талаар: Тус цагдаагийн газрын Гэрээт цагдаагийн хэлтэс /Гашуун сухайт/-ийн дарга цагдаагийн хурандаа С.Батсүх нь цэргийн байнгын тэтгэвэрт гарч 36 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгуулсан. Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа Гурвантэс сум дахь цагдаагийн тасгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Ц.Мөнхдэлгэрт 30 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний

мөнгөн урамшил олгуулах саналыг холбогдох материалын хамт Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.

Албанаас дутагдлаар халагдсан болон чөлөөлөгдсөн алба хаагчдын хөдөлгөөний талаар: 2021 оны эхний хагас жилийн байдлаар Ханхонгор сум дахь цагдаагийн хэсгийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Д.Эрхэмбаяр, Ханбогд сум дахь цагдаагийн тасгийн хамгаалалтын цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Н.Нарангэрэл нар албанаас дутагдлаар халагдсан.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

2.1. Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:

Энэ оны эхний 6 сард 204 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 4.2 хувиар, илрүүлэлт 45.2 байгаа нь 4.2 тус тус буурсан. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, Хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргүүд 16.2-20 хувиар өссөн. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн илрүүлэлт буурсан байгаатай холбогдуулж ажиллагаанд байгаа хэрэг бүртгэлтийн хэргүүдийг илрүүлэх, шийдвэрлэх, эрэн сурвалжлагдаж байгаа оргодол этгээдүүдийг олж тогтоох, илрүүлэлтийн хувийг ахиулах зорилгоор мөрдөн байцаах тасагтай хамтран 2021 оны 03 сард “Шийдвэрлэлт”, 2021 оны 06 сард эрүүгийн цагдаагийн тасгаас “Илрүүлэлт” хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулж алба хаагч нарыг албан томилолтоор Улаанбаатар хот болон бусад аймаг орон нутагт ажиллуулж үр дүнг тооцон ажиллаж байна.

Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчид нь 2021 оны эхний хагас жилд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс гэмт хэргийн шинжтэй 265 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч, 121 өргөдөл, гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 117 өргөдөл, гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэг нээхээс татгалзаж, 10 өргөдөл, гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, 18 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Хэрэг бүртгэлтийн 366 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 83 хэргийг Мөрдөн байцаах тасагт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татах саналтайгаар шилжүүлж, 56 хэргийг хааж, 27 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж одоо 187 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байна. Бусад газарт 10 гэмт хэргийг илрүүлж шилжүүлсэн.

2021 оны эхний 06 дугаар сарын байдлаар иргэд, аж ахуй нэгж байгууллагаас хулгайлах гэмт хэргийн шинжтэй нийт 62 гомдол, мэдээлэл хүлээн авсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 11 хувиар буурсан байна. Үүнээс 27 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 35 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 22 нэгжээр буюу 39 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ онд үйлдэгдсэн хулгайлах төрлийн нийт 35 гэмт хэргээс 13 гэмт хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон илрүүлж харьяаллын дагуу мөрдөн байцаах тасагт яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай шилжүүлсэн бөгөөд илрүүлэлт 32,5% байна. Хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах, хэрэг бүртгэлтийн хэргийг шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн прокурорын газартай хамтарсан зөвлөгөөнийг сар бүр зохион байгуулж шийдвэрлэх хэргийн график төлөвлөгөөг боловсруулан батлуулж биелэлтийг тооцон ажиллаж байна. Тус аймаг дахь Цагдаагийн газраас хулгайлах гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх, таслан зогсоох илрүүлэх зорилгоор “Судалгаа” хэсэгчилсэн арга хэмжээ 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хугацаанд зохион байгуулан ажиллаж байна. Өмнөговь аймгийн хэмжээнд барьцаалан зээлдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 13 аж ахуй нэгж бүртгэлтэй байгаагаас идэвхтэй байнгын үйл ажиллагаа явуулдаг “68” зээлийн төв, “Өсөх намсрай” ХХК, “Аз” ХХК, “Уранбиндэр” ХХК, “Ундралилч” ХХК “Өргөлийн ач” ХХК нийт 6 аж ахуй нэгжид тус цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн Цагдаагийн хошууч Г.Цолмон хамтаар хяналт шалгалтыг зохион байгуулан “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ” /MNS 5274:2017/ заавал дагаж мөрдөх стандартын 8.14, 8.15-д заасны дагуу үйл ажиллагаа явуулж байгаа барьцаалан зээлдүүлэх газруудад “Үүлэн технологи” ХХК-ийн procreditor.mn нэгдсэн сүлжээнд хамруулах чиглэлээр шаардлагыг тавьж /68 зээлийн/, Өсөх намсрай ХХК/ тус сүлжээнд хамруулан бусад аж ахуй нэгжид шаардлагыг албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна..

Тус аймаг дахь Цагдаагийн газраас байгалийн гамшигт үзэгдлийн улмаас Дундговь аймгийн нутаг дэвсгэрээс шуурганд уруудан алга болсон малыг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулах 12 заалт бүхий төлөвлөгөө боловсруулж дахин гамшигт үзэгдлээс үүдэн мал алдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн “Говь НД”, “Алтанговь”, “Говийн наран” телевизороор 3 удаагийн ярилцлага хийж, 3 постор бэлтгэж, нийт 500 ширхэг тараах материалыг бэлтгэн, эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулан ажилласан. Тус аймгийн иргэд, малчдаас “Малчин лавлах-109” тусгай дугаарын утсанд 2021 оны 03 дугаар сарын байдлаар алдсан, олдсон малын зар өгөөгүй байна. “Малчин лавлах-109” дугаарын утсыг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэд, малчдад сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Урин дулааны цаг ирж малчид өвөлжөөнөөсөө нүүхдээ үнэт эдэл, мөнгөн аяга, хурганы арьс, мөнгөн эмээл, бэлэн мөнгө, борц, ноолуур зэрэг үнэд хүрч зарагдах эд зүйлээ орхиж явдаг болон отор нүүдлээр бусад хил залгаа зэргэлдээ аймгаас ирсэн малчид болон туслах малчдыг дагаад мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүд ирж болзошгүй тул тус аймгийн Цагдаагийн газраас “Судалгаа”, “Хулгайч” хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулахаар аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлгийн 24.5, 24.6 дугаар зүйлд заасан хууль бусаар ан агнах, мод бэлтгэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, хэргийн шийдвэрлэлтийг ахиулах, нэгдсэн судалгааны баяжилт хийх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албанаас Монгол Улсын хэмжээнд зохион байгуулсан “**Эко-2021**” нэгдсэн арга хэмжээг тус цагдаагийн газраас хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгууллаа.

Нэгдсэн арга хэмжээг зохион явуулах ерөнхий удирдамжийн дагуу 36 заалт бүхий салбар төлөвлөгөөг боловсруулж, цагдаагийн газрын даргаар батлуулан хариуцсан нутаг дэвсгэрийн 14 сумдын хэлтэс, тасаг, хэсгүүдэд албан бичгээр хүргүүлсэн. Мөн нэгдсэн арга хэмжээтэй давхцуулан 26 заалт бүхий “**Судалгаа**” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж тухай бүр үр дүнг тооцож ажилласан.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийн шинжтэй 13 үйлдэл, Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасан зөрчлийн шинжтэй 16 үйлдлийг илрүүлэн цагдаагийн газрын нэгдсэн тоо бүртгэлд оруулан мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан мэргэжлийн байгууллагуудтай хамтран нутаг дэвсгэрийн хэмжээнд давхардсан тоогоор 31 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.

Шүүхээс цагдаагийн байгууллагад эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулахаар даалгасан этгээдүүдийг олж тогтоох, эрэн сурвалжлах ажлын үр дүнг сайжруулах, зөрчил, дутагдлыг арилгуулах, эрэн сурвалжлах ажилд тавих хяналтыг сайжруулах, шүүхээс даалгасан этгээдүүдийн ASAP санд эзлэх тоог бууруулах зорилгоор Эрүүгийн цагдаагийн албанаас 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хооронд зохион байгуулсан “Шүүхээс даалгасан бусад хүн 2021” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд салбар төлөвлөгөө боловсруулж, биелэлт үр дүнг тооцон ажилласан.

Уг хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд эрэн сурвалжлах мэдээллийн ASAP санд гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр эрэн сурвалжлагдаж байсан 8 хүн, эд зүйл 11, тээврийн хэрэгсэл 3, шүүхээс даалгасан хүн 6, Оршин суугаа газраасаа сураггүй алга болсон 2 хүнийг тус тус олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож ажилласан.

Тус цагдаагийн газраас “Судалгаа ” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулаан ажиллаж байгаа бөгөөд хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд тус аймгийн хэмжээнд мал, мах болон түүхий эдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мах боловсруулах 1 үйлдвэр, мал нядалгааны газар 2, малын гаралтай түүхий эд авдаг 12 цэг, Мал мах худалдан борлуулдаг 31 дэлгүүр, ченж нарын дэлгэрэнгүй судалгааг гаргаж Цагдаагийн байгууллагын судалгаа хяналтын “Patrol.police.gov” санд 35 иргэнийг мэдээллийг шивж оруулсан гүйцэтгэл 80 хувьтай байна

Тус аймгийг Монгол Улсын засгийн газраас “Ногоон бүс” болгон зарласантай холбогдуулан “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Улаанбаатар хотоос хулгайн тээврээр хүн тээвэрлэж буй хууль бус үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох, хариуцлага тооцох зорилгоор “Хулгайн тээвэр”, Аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/1468 дугаартай захирамжийг зөрчиж спиртийн өндөр агууламж бүхий согтууруулах ундааг хууль бусаар худалдан борлуулж буй үйлдлийг таслан зогсоож, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Шар” хэсэгчилсэн арга хэмжээг хариуцсан орон нутгийн хэмжээнд 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хүртэлх зохион байгуулж, биелэлт үр дүн тооцон ажилласан.

“Хулгайн тээвэр” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд коронавирусын халдвар илэрсэн орон нутгаас маршрутын бус замаар хууль бусаар хүн тээвэрлэсэн 34 хүнд холбогдох 11 зөрчлийн илрүүлэн Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар зөрчлийн хэрэг нээн шалгасан. Мөн “Шар” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд хууль бусаар гар дээрээс архи согтууруулах худалдан борлуулж болзошгүй 16 иргэн, 9 аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж хяналт тавьж, 11 иргэнд холбогдох 11 зөрчлийг илрүүлж, хууль бусаар гар дээрээс худалдан борлуулж байсан 117

шил архи, 198 сав лааз бүхий пиво, 3 шил вискиг холбогдох хууль тогтоомжийн дагуу хурааж авч устгалд оруулахаар мэргэжлийн байгууллагуудад хүргүүлсэн байна.

Өмнөговь аймаг дахь цагдаагийн газраас эрэн сурвалжлах “Asap” санд 2021 оны хагас жилийн байдлаар иргэний хариуцагчийг эрэн сурвалжлах чиглэлээр шүүхээс даалгасан бусад хүн төлөвт 34, оргодол 9, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд төлөвт 41, тээврийн хэрэгсэл төлөвт 4, эд зүйл 17, мал амьтан 11, цогцос 2, оршин сууж байгаа газраасаа сураггүй алга болсон 9, зөрчил үйлдсэн этгээд 2 нийт 129 мэдээллийг төвлөрсөн тоо бүртгэлд оруулан эрэн сурвалжилж ажилласан байна.

Одоогийн байдлаар цагдаагийн газраас эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP” санд өмнөх онуудад эрэн сурвалжлалт зарласан нийт оршин суугаа газраасаа сураггүй алга болсон хүн 2, Гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 14, цогцос 1, Галт зэвсэг 4, Тээврийн хэрэгсэл 4, Түүх соёлын дурсгалт зүйл 2, шүүхээс даалгасан хүн 18, эд зүйл 43 үлдэгдэлтэй эрэн сурвалжлах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулан ажиллаж байна.

Тус Цагдаагийн газар нь 2021 оны эхний эхний хагас жилийн байдлаар иргэн, аж ахуйн нэгжээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 2088 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас зөрчлийн шинжтэй 1609 гомдол мэдээлэл, 479 гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авч эрх бүхий алба хаагчид хуулийн хугацаанд мөрдөн шалгах ажиллагаа явуулж хэрэг бүртгэлтийн 44 хэрэг бүртгэлтийн хэрэгт холбогдуулж гэмт хэрэг үйлдсэн нь хангалттай нотлох баримтаар тогтоогдсон 44 иргэнийг эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP” санд гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд төлөвөөр зарлаж 35 этгээдийг олж тогтоон, Оргодлоор 9 этгээдийг эрэн сурвалжлан 9 этгээдийг олж тогтоон сангийн ашиглалт бүрдүүлэлтийг хангаж ажилласан.

2.2. Мөрдөн байцаах албаны чиглэлээр:

2021 оны хагас жилийн байдлаар иргэн аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн нийт 241 гомдол мэдээллийг хүлээн авч материалжуулан шалгаж 36 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 126 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 67 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, харьяаллаар 1 гомдол мэдээлэл шилжүүлэн шийдвэрлэсэн ба одоо 11 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Мөрдөн байцаах тасаг нь 2021 оны эхний хагас жилийн байдлаар хэрэг бүртгэлтийн 253 хэрэгт хэрэг бүртгэх ажиллагаа явуулж, 120 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 105 хэргийг хаах саналтай, 3 хэргийг харьяаллын дагуу холбогдох газарт тус тус шилжүүлж, одоо 25 хэргийг үлдэгдэлтэй ба хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан нийт хэргийн 228 хэрэг буюу 90.1 хувийг шийдвэрлэсэн байна.

Мөн энэ хугацаанд мөрдөн байцаалтын 179 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, 160 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 3 хэргийг нэгтгэж, 3 хэргийг хэрэгсэхгүй болгож, 4 хэргийг харьяаллын дагуу тус тус шилжүүлж, одоо 9 хэргийн үлдэгдэлтэй ба нийт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нийт 170 хэрэг буюу 95 хувийг шийдвэрлэсэн.

Урд оны хэрэг бүртгэлтийн 40 хэргийн үлдэгдэлтэй байснаас 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 24 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 15 хэргийг хаах саналтай тус тус шилжүүлж, одоо 1 хэргийг үлдэгдэлтэй ба нийт 39 хэрэг буюу 97.5 хувийг шийдвэрлэсэн байна.

Урд оны мөрдөн байцаалтын 4 хэргийн үлдэгдэлтэй байснаас 2021 оны 1 дүгээр улиралд багтаан 4 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 100 хувь шийдвэрлэж ажилласан.

Мөн хагас жилийн байдлаар мөрдөн байцаалтын шатанд гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 140,676,600 төгрөгийн хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 113,973,200 төгрөгийн хохирол буюу нийт хохирлын 81,1 хувийг нөхөн төлүүлж ажилласан байна.

Хариуцсан нутагт үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, эрүү, хэв журмын нөхцөл байдлыг сум, багаар нь тогтоож, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах зорилгоор гэмт хэрэг гаргах болсон шалтгааны нөхцөлийг нарийн судалж, Криминалоги судалгааны багт гарган өгч, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад албан мэдэгдэл бичиж, хариуг авч ажиллаж байгаа ба мэдэгдлийн мөрөөр хийсэн ажлыг шалгах, мөрдөгчийн бичиж байгаа албан мэдэгдлийг чанаржуулах зорилгоор “Мэдэгдэл” хэсэгчилсэн арга хэмжээг 1 удаа зохион байгуулж ажилласан. Арга хэмжээний хүрээнд мөрдөгч нарт үүрэг, ажлын чиглэл өгч, үр дүнг тооцон ажилласан. Тус тасаг нь 2021 оны эхний хагас жилийн байдлаар Шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн 160 хэрэгт гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах, дахин гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 100 хувь мөрдөгчийн мэдэгдэл бичсэн байна.

Мөрдөгч нарын шалгаж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг бүрийг гомдол мэдээллийн шатанд нь уншиж, амаар зааварчилгаа өгч, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нь хэргүүдтэй уншиж танилцан, 2021 оны эхний хагас жилийн байдлаар шалгасан хэргийн 45 хувьд бичгээр болон цахимаар зааварчилгаа өгч, биелэлт, үр дүнг тооцон ажилласан.

Мөрдөн байцаах тасаг нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, ард иргэдийг чирэгдүүлэхгүй байхад онцгой анхаарч, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг түргэн шуурхай, гологдолгүй явуулах, өдөр тутмын хяналтыг сайжруулах зорилгоор аймгийн Прокурорын байгууллагатай хамтарсан зөвлөгөөнийг сар бүрийн эхний долоо хоногт зохион байгуулж, өнгөрсөн сард шалгаж шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн талаар болон хүндрэл, бэрхшээл, алдаа, дутагдал, ололт амжилтын талаар зөвлөлдөж, алба хаагчдын ажлын үр дүнг дүгнэж, тухайн сард шийдвэрлэх хэргийн графикийг гарган ажиллаж хэвшсэн ба 2021 оны эхний хагас жилийн байдлаар 4 удаа хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулж ажилласан байна.

Алба хаагчдад шинэчлэгдэн батлагдсан хууль, эрх зүйн мэдлэг олгох, албанд нь түргэн шуурхай дадлагажуулах, ажил үйлчилгээг тасралтгүй, шуурхай явуулах зорилгоор оны эхэнд сургалтын төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөний дагуу албаны сургалтыг мөрдөгч нараар бэлтгүүлэн танхимын сургалт орж, сургалтын дэвтэрт бичиж тэмдэглүүлдэг ба алба хаагч нарыг алдаа дутагдал гаргахгүй, мөрдөн шалгах ажиллагааны үр дүн, мөрдөгч нарын мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх зорилгоор сургалтын төлөвлөгөөнд заасны дагуу тасагтаа 7 хоног бүрийн “Пүрэв” гаригт мөрдөгч нараар өөрсдөөр нь сургалт бэлтгүүлэн албаны сургалтыг зохион явуулж байгаа бөгөөд сургалтын төлөвлөгөөний дагуу “Мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн хэлбэрийн загвар”, “АТГ-ийн даргаас ирүүлсэн 04 дугаартай Мэдэгдэлд дурдсан зөрчлийн талаар анхаарах асуудал”, “Цагдаагийн алба хаагчийн хориглох зүйл” сэдэвт сургалтуудыг “Trueconf” программ ашиглан мөрдөгч нартай цахимаар холбогдон явуулсан. Мөн 2021

оны 01, 03 дугаар саруудад авсан цахим шалгалтад мөрдөгч нарыг бүрэн хамруулж, мөрдөгч нар 70-95 хувьтай үнэлэгдсэн.

Түүнчлэн Мөрдөн байцаах албан сургалтын төлөвлөгөөний дагуу 2021 оны 01, 02 дугаар саруудад алба хаагчийг мэргэшүүлэх зорилгоор 23 сургалтыг байгууллагын удирдлагын цогц систем /eoffice.police.gov/ хаягийн олон нийтийн цэсэнд байрлуулсныг долоо хоног бүрийн “Лхагва” гаригт тасагтаа сургалтын цаг гарган алба хаагч нараар судлуулан, сургалтын дэвтэрт тэмдэглэл хөтлүүлж сурган мэргэшүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байгаа бөгөөд тус албанаас ирүүлсэн албан бичгийн дагуу 23 сургалтаас судлаагүй үлдсэн байсан 15 сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд мөрдөгч нараар нөхөж судлуулан сургалтын дэвтэрт тэмдэглэл хөтлүүлэн ажилласан.

Мөн мөрдөгч нарын мөрдөн шалгах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх зорилгоор тус Цагдаагийн газарт дэд дарга, Мөрдөн байцаах тасгийн даргаар ажиллаж байсан бэлтгэл цагдаагийн хурандаа С.Батчулууныг Олон нийтийн цагдаагаар томилуулж, мөрдөгч цагдаагийн ахмад Т.Төгөлдөр, цагдаагийн ахмад Ц.Мөнхдэлгэр, мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Баярбат, мөрдөгч, цагдаагийн ахмад М.Саранчимэг нартай ганцаарчлан уулзуулж, шалгаж байгаа хэргүүдтэй болон өрөө сейфийн эмх цэгц, аюулгүй байдал нууцлал, бүртгэл судалгаатай танилцуулж тус бүрд нь зааварчилга, зөвлөмж өгүүлж биелэлт үр дүнг тооцон ажилласан.

Хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн онц ноцтой, хүнд гэмт хэргийн талаарх мэдээ, мэдээллийг ЦГ, МБА-ны дарга болон ХГХМШХ-ийн дарга нарт шуурхай танилцуулж, удирдлагыг бодит мэдээллээр хангаж, чиг үүргийн хэлтсүүдтэй харилцан мэдээлэл солилцож, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх боломжийг бүрдүүлэн, аймгийн төвийн 4 мөрдөгчийн дунд 1, тасгийн даргад 1, Цогтцэций сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн 2 мөрдөгчид 2, Гурвантэс сум, Ханбогд сум, Ханбогд сумын Хайрхан багийн “Цагаанхад” хариуцсан мөрдөгч нарт тус бүр 1, нийт 7 ширхэг “Samsung Cover” маркийн гар утсыг Цагдаагийн газраас шийдвэрлүүлэн олгуулж, “True conf” программыг суулгаж, ХГХМШХ-т танилцуулан “IP” хаяг авч, хөдөлгөөнт төхөөрөмжийг хэргийн газрын үзлэг, цогцост хийх шинжилгээ болон шаардлагатай мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах ажлыг тогтмолжуулах талаар мөрдөгч нарт үүрэг, ажлын чиглэлийг өгч, программыг ашигласан талаарх “Бүртгэлийн дэвтэр”-ийг шинээр нээж, бүртгэлжүүлэн ажиллаж байна. Сумдын болон аймгийн төвийн ахлах мөрдөгч, мөрдөгч нарт хүний амь нас хохирсон, олны анхаарал татсан, ээдрээ төвөгтэй хэргийн газрын үзлэг, цогцост задлан шинжилгээ хийх болон бусад төрлийн ажиллагаа явуулахдаа “True conf” программыг ашиглаж, мэдээ мэдээллээр хангаж, зөвлөмж авч хэвших талаар ажлын чиглэл хүргүүлж, үүрэг, ажлын чиглэлийн хэрэгжилтийг сар, улирал бүрийн тайланд тусгаж, дүгнүүлж байхаар зохион байгуулалтыг хийн ажиллаж байна.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хоёр дох үе шатны төлөвлөгөө” болон Мөрдөн байцаах албанаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор “авлига хээл хахууль авахгүй, албаны нэрийг өндөрт өргөж, бусдын нөлөөнд автахгүй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах” талаар

мөрдөгч нараас 3 төрлийн баталгааг улирал бүр гаргуулан авч, хяналт тавин ажилласнаар алба хаагчдаас энэ төрлийн зөрчил, дутагдал гараагүй байна.

2.4. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүнийг “Говь Ц-111” дохиогоор 4 удаа нэгтгэн цуглуулж, утас, станцаар 9 удаа алба хаагчдын албаны болон хувийн бэлэн байдлыг шалгаж, жагсаалын нэгдсэн үзлэгийг 3 удаа, хэсэгчилсэн үзлэгийг 3 удаа хийж, 82 алба хаагч, 21 олон нийтийн цагдаа хамрагдаж 22 зөрчлийг илрүүлэн зөрчлийг газар дээр нь арилгуулав.

Мөн албанаас тавьж олгосон техник, тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлийн ашиглалтын байдалд 2 удаа, тээврийн хэрэгслийн ашиглалтын байдалд 3 удаа үзлэг шалгалт хийж, дүнг Цагдаагийн газрын даргад танилцуулав.

Нийт бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсэн ЦЕГ-ын дарга болон Цагдаагийн газрын даргын тушаалыг тухай бүр танилцуулж, алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга, ёс зүйг дээшлүүлэх, албаны бэлэн байдлыг хангах чиглэлээр дотоодын хяналт шалгалтыг эрчимжүүлж, Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйг зөрчсөн, ажлын хариуцлага алдсан Ханхонгор сумын хэсгийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Д.Эрхэмбаярыг Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.5 дахь заалт, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн 12 дугаар зүйлийн 12.14 дүгээр заалтад заасныг зөрчсөн тул Цагдаагийн газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн Б/26 дугаар тушаалаар цагдаагийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах сахилгын шийтгэл ногдуулсан. мөн Хүрмэн сумын хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч З.Батсайханыг “Сануулах” сахилгын шийтгэл, МБ-ны харуулын цагдаа, цагдаагийн ахлагч М.Ширнэнд “Сануулах” сахилгын шийтгэл тус тус оногдуулж цагдаагийн газрын зөвлөлийн хурлаас шийдвэрлэсэн.

Албаны болон өндөржүүлсэн бэлэн байдал, онцгой нөхцөл байдлын ажиллах ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр гамшгийн үед үүрэг гүйцэтгэх, арга тактик хүрээнд 2 удаагийн албаны сургалт дадлага, 1 удаагийн хамтарсан дадлага сургуулилалтыг зохион байгуулав. Мөн цагдаагийн алба хаагчдын галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч, мэх хэрэглэх арга зүйн сургалт, дадлагыг 7-р сард зохион байгуулахаар төлөвлөж байна.

Тасгийн алба хаагч нарын ажлын хариуцлага, сахилга ёс зүй, харьцааны соёлыг дээшлүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар алба хаагч тус бүрээр 2 удаа баталгаа бичгээр авч нэгтгэв.

Цаашид алба хаагчдаас алдаа дутагдлыг гаргахгүй байх талаар бичгээр баталгаа авч, 7 хоног бүрийн 5 дахь өдөр сахилга хариуцлагатай холбоотой асуудлаар тасгийн хурлыг тогтмол хийж, ажиллаж байна.

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Цагдаагийн байгууллагын нэгдсэн систем /system.police.gov/, цагдаагийн байгууллагын мэдээллийн систем /dbservice.police.gov/-д хамгаалалт, эргүүл удирдлагын систем /rmanage.police.gov/-д өдөр тутмын эргүүлийн томилгоог хийж хяналт тавин ажиллав. Давхардсан тоогоор 210 офицер, 622 цагдаа, 168 олон нийтийн цагдаа, хяналт шалгалтын үүргийг 8 суурин станц, автомашины 31 станц, алба хаагч бүр гар станц, агсамж, 74 автомашинтайгаар эргүүл/пост/-д үүрэг гүйцэтгэж, 346 цэгт хяналт тавин гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 2136 удаагийн дуудлага мэдээллийг хүлээн авч, хэргийн газрын хамгаалалтад 38 удаа үүрэг гүйцэтгэж, 1655 зөрчил илрүүлж, зөрчил үйлдсэн 12207 этгээдэд 733.915.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, согтууруулах ундаа хэтрүүлэн

хэрэглэсэн 132 этгээдийг ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, 411 этгээдийг эрүүлжүүлэх байранд хүлээлгэн өгч, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 48 жолоочийг илрүүлж, 22452 тээврийн хэрэгслийг шалгаж, зөрчилтэй явсан 510 тээврийн хэрэгслийг саатуулж, 609 аж ахуйн нэгжийг шалгаж, 201 литр архи, 267 литр пиво согтууруулах ундаа зүйлсийг хурааж, 802 хайрцаг тамхи, хууль бус орлого 8370.000 төгрөг хурааж, холбогдох зөрчилд шалгах ажиллагааг явуулав.

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 127 цэгт хяналтын 24 цагийн пост хааж хорио цээрийн дэглэмийг сахиулж, цагдаагийн газраас давхардсан тоогоор 832 ажилтан, алба хаагч, бусад байгууллагаас 650 ажилтан, 122 тээврийн хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж ажилласан бөгөөд Онцгой нөхцөл байдлын үед ажиллах төлөвлөгөө, схем, зураглалд тодотгол хийж, “Гамшгийн үед ажиллах төлөвлөгөө”, “Бүсчлэн хаах төлөвлөгөө”-г шинэчлэн батлуулж, нийт алба хаагч нарт танилцуулан үүрэг ажлын чиглэл өгч, алба хаагч бүрээр сахилга ёс зүй, харьцааны алдаа дутагдал гаргахгүй ажиллах талаар бичгээр баталгаа гаргуулав. Өмнөговь аймгийн хэмжээнд онцгой нөхцөл үүссэн үед зэвсэгт хүчин, хил хамгаалах, тагнуул, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын харилцан ажиллах төлөвлөгөөнд тодотгол хийж, ЦЕГ-ын МДШШУА-нд албан бичгээр хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын 2021 оны “Терроризмоос сэргийлэх ажлын төлөвлөгөө”-г танилцаж, салбар төлөвлөгөөг боловсруулан цагдаагийн газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус цагдаагийн газрын даргын тушаалаар цагдаагийн газрын “Шуурхай штабын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай”, “Орон тооны бус тусгай бүлгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай” тушаалуудыг гаргаж, алба хаагчдыг томилгоожуулан аймаг орон нутгийн нөхцөл байдалд тулгуурлан гарсан шийдвэрүүдийг цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлого шийдвэрийг тухай бүр штабын бүрэлдэхүүнийг цуглуулж хэлэлцэж, 24 цагаар үүрэг гүйцэтгүүлэн хяналт тавин ажиллав.

Автомашинд шаардагдах шатах, тослох материал, нөөцийг урьдчилан бэлтгэж, хамгаалалтад ашиглагдаж байгаа 6 тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийж 11-02 ӨМҮ, 11-78 ӨМҮ улсын дугаартай тээврийн хэрэгслүүд шаардлага хангахгүй болсон тул шаардлагатай засварын зардлыг аймгийн Онцгой комисст танилцуулж шийдвэрлүүлсэн.

Тайлант хугацаанд төрийн дээд зочид төлөөлөгчид аймгийн нутаг дэвсгэрт 5 удаа айлчилж төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай танилцсан бөгөөд цагдаагийн газраас тухай бүр Төрийн тусгай албатай хамтран хамгаалалтыг өндөр хэмжээнд зохион байгуулж, 5 удаа айлчлах үед 93 алба хаагч, 21 тээврийн хэрэгслээр хамгаалалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулсан.

Тус цагдаагийн газраас Цагдаагийн Ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021 оны А/124 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг, дэд хэсгээс бэлтгэн боловсруулж, батлуулсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалт зохион байгуулах бэлтгэл ажлын нэгдсэн төлөвлөгөөтэй танилцаж, тус цагдаагийн газрын даргын 2021 оны 04-р сарын 09-ний өдрийн А/36 дугаартай тушаалаар “Ажлын хэсэг” томилж, тушаалын хавсралтаар 71 заалт бүхий сонгуулийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалт зохион байгуулах бэлтгэл ажлын салбар төлөвлөгөөг боловсруулж, бэлтгэл ажлыг ханган энэ оны 06 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд сонгуулийн хамгаалалтыг зохион байгуулж ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн хамгаалалтад 61 хэсгийн хороо, эргүүл, хамгаалалтаар нийт 193 алба хаагч үүрэг гүйцэтгэж, сонгуулийн

үеийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалт зохицуулалтыг Цагдаагийн газрын даргын батлагдсан төлөвлөгөө, зураглалын дагуу зохион байгуулж, хамгаалалт зохицуулалтын үед алба хаагчид сахилга, ёс зүй, зөрчил дутагдалгүй, үүрэг гүйцэтгэж ажилласан.

Коронавирус /ковид-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан албан газар аж ахуйн нэгжийг 23 удаа эргүүл, жижүүрт хуваарилж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх халдвар хамгаалалтын дэглэм сахих чиглэлээр мэдээ мэдээлэл хүргэх, санамж сэрэмжлүүлэг, гарын авлага, материал тараах, оролцогчдын аюулгүй байдлыг хангах хамгаалалт, эргүүл, шалгалтыг хамтран гүйцэтгэв.

Аймгийн онцгой комиссоос Монгол Улсын Эрүүл мэндийн яаманд Гашуун сухайт хилийн боомтод ажиллаж байгаа боомтын ажилчид болон нүүрс тээврийн жолооч 10.000 хүнд, Мөн Шивээхүрэн хилийн боомтод ажиллаж байгаа боомтын ажилчид болон нүүрс тээврийн жолооч 1981 хүнд, аймгийн Эрүүл мэнд, Цагдаа, Тагнуул, Мэргэжилийн хяналт, Онцгой байдлын байгууллагын 1019 хүнийг дархлаажуулахаар БНХАУ-д үйлдвэрлэсэн 13.000 Веро-целл вакциныг захиалан хүлээн авч 2021 оны 03 дугаар 18-ны өдрөөс дархлаажуулалтын ажлыг эхлүүлсэнтэй холбогдуулан Онцгой байдлын газар, Бүсийн Оношилгоо Эрчимт эмчилгээний төв, Мэргэжлийн хяналтын газар болон холбогдох тусгайлсан чиг үүргийн байгууллагуудтай хамтран хорио цээрийн дэглэм сахиулах, Коронавируст халдвар /ковид-19/-ийн дархлаажуулах вакциныг хүлээн авах, түгээх, хадгалах, дархлаажуулах үйл ажиллагааны үед хамгаалалтыг 22 цэгт 41 алба хаагчдыг томилон ажиллаж үүрэг гүйцэтгүүлсэн.

Өнгөрсөн саруудад коронавируст халдварт өвчний ойрын болон дам хавьталтай иргэдийг Улаанбаатар хотруу тээвэрлэх ХӨСҮТ хүргэх ажлаар 26 удаагийн тээвэрлэх үеийн хамгаалалт зохицуулалтыг зохион байгуулсан.

Улаанбаатар хотын ХӨСҮТ-ийн лаборотороос дархлаажуулалтын вакцин татан авах хамгаалалтыг 5 удаа, вакциныг сумдад хүргэх, түгээх тээвэрлэлтийн хамгаалалтыг 18 удаа зохион байгуулж ямар нэг зөрчил дутагдалгүй ажилласан.

Тайлангийн хугацаанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 2136 зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол, дуудлага мэдээллийг хүлээн авч, хуулийн анхны хугацаанд зөрчил шалгах ажиллагаа явуулан 371 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 297 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, харьяаллын дагуу 13 материалыг шилжүүлж, 977 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдэж, ажиллагаанд 14 зөрчлийн материал ажиллагаанд байна. Гомдол, мэдээлэл, шийдвэрлэлтийг цаг хугацаанд нь цахим санд оруулж, бүртгэлээр болон сангаар хяналт тавив.

Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагааны талаар

Эрүүлжүүлэх саатуулах байрны эмч 3, ЭСБ-ны жижүүрийн цагдаа 3 алба хаагчид үүрэг гүйцэтгэдэг бөгөөд гэмт хэрэг, зөрчил үйлдсэний улмаас хүргэгдэж ирсэн 411 этгээдийг хөдлөнгийн гэрч, хүргэж ирсэн алба хаагчийг байлцуулан биед нь эрүүл мэндийн үзлэг хийж, эд зүйлийг түр хураан авч тэмдэглэл хөтлөн эрүүлжүүлснээс 385 эрэгтэй, 22 эмэгтэй эрүүлжүүлэх байранд орсон ба төлбөр болох 1.680.750 төгрөгийг төрийн сангийн дансанд тушаасан байна.

Мөн баривчлах байранд Шүүхээс 7-30 хоногийн хугацаатай баривчлах шийтгэл оногдуулсан 184 этгээдийг шүүгчийн захирамжаар хүлээн авч, үүнээс 7 эмэгтэй, 177 эрэгтэйг 7 хоногт 1 удаа усанд оруулж, халдвар хамгаалалтын дэглэм сахиулж, баривчлагдсан 172 этгээдийн биед нь өдөр бүр үзлэг хийж, халууныг хэмжиж хувийн хэрэгт тэмдэглэл хөтлөн зардал болох 7.774.370 төгрөгийг төрийн сангийн нэгдсэн санд төвлөрүүлсэн бөгөөд 11 хүн нь баривчлах шийтгэл эдэлж, халдварт өвчнөөс урьдчилан

сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, гарын авлага тараан, ЭСБ-ны халдваргүйжүүлэх цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, ариутган ажиллав.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлын хангах хэсгийн үйл ажиллагааны талаар

Аймгийн Шүүхийн тамгын газартай 2021 онд хамтран ажиллах төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, үр дүнг сар бүр тооцон ажиллав. Шүүхийн удирдлага, ажилтнуудтай цахимаар болон биелэн 7 удаагийн уулзалт зөвлөгөөнийг хийж, хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар санал солилцон ажиллав. Шүүхийн харуул, хамгаалалтын алба хаагчид баталсан томилгооны дагуу эрүүгийн хэргийн шүүх хуралд 269 удаа, иргэний хэргийн шүүх хуралд 192 удаа, захиргааны хэргийн шүүх хуралд 93 удаа, зөрчлийн шүүх хурал 76 нийт 630 удаагийн шүүх хурлын хамгаалалтад үүрэг гүйцэтгэж, 2846 иргэнийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлж ажилласан.

“Яллагдагчийг хуяглан хүргэх, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаа явуулах” журмын дагуу Шүүхийн байранд 21, цагдан хорих байранд 42 удаа, нийт 63 удаагийн хуяглан хүргэх ажиллагааг ямар нэг зөрчилгүй зохион байгуулж шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэв.

Аймгийн хэмжээнд шүүхээс даалгасан бусад 36 хүнийг эрэн сурвалжилж, шүүхээс эрэн сурвалжлагдаж байгаа 16 этгээдийн хаяг байршлыг тогтоож, Шүүхийн тамгын газарт болон нэхэмжлэл гаргагчид албан бичгээр мэдэгдэж, албадан ирүүлэх захирамжтай 9 этгээдийг олж тогтоон, Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах мэдээллийн нэгдсэн санд тус цагдаагийн газраас эрэн сурвалжлах санд 15 хүний үлдэгдэлтэй байна.

2.4. Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр:

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр Замын цагдаагийн тасгаас 18 Гэрээт цагдаагийн тасаг /Гашуун сухайт/-аас 43 алба хаагч, хот хоорондын хяналтын 2 цэгт болон нүүрс тээвэрлэлтийн автозамуудад 7 автомашин, 16 шалгах багаж, 6 согтуурал шалгах багаж, 4 согтуурал тандагч, 3 хурд хэмжигчтэйгээр үүрэг гүйцэтгэж, тасгийн дарга, ахлах зохицуулагчаас алба хаагчдын ажлын цаг ашиглалт, эргүүл хяналтын цэгийн хуваарьт тогтмол хяналт тавин ажилласан.

Хариуцсан нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Авто тээврийн төвтэй хамтран зохион явуулж Даланзадгад сумын төвд 4 алба хаагч аймгийн төвөөс Улаанбаатар хот руу чиглэсэн улсын чанартай автозамын 2.5 дахь км-т, Цогтцэций сумын цагдаагийн хэлтсээс 5 алба хаагч сумын төв рүү орох, гарах автозамд болон уурхай орчимд, Ханбогд сумын цагдаагийн тасагт 2 алба хаагч сумын төвөөс орох, гарах автозамд, нүүрс тээвэрлэлтийн автозам болон хил орчимд, Гэрээт цагдаагийн тасгаас 27 алба хаагч нүүрс тээвэрлэлтийн 239 км автозамыг хариуцан шалган нэвтрүүлэх цэг 1, 2, 4 дүгээр пост, Ухаа худаг уурхайгаас Гашуун Сухайт хилийн боомт хүртэлх автозамын 133 дахь км-т /Сүлжээ гэх газар/, Оюутолгой ХХК-ий автозамын уулзвар, цэгүүдэд замын хяналт, шалгалтыг тогтмол зохион явуулж хоногт илрүүлсэн зөрчил, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээг өдөр бүр Замын цагдаагийн тасагт нэгтгэн Тээврийн цагдаагийн албаны Жижүүрийн шуурхай албанд 21:00 цагт өгч ажиллалаа.

Эрүүгийн хэргийн шалгалт шийдвэрлэлтийн талаар

Хариуцсан нутаг дэвсгэрт энэ оны эхний хагас жилд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол 146 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үе /115/-оос 31 нэгжээр буюу 21.3 хувиар өссөн, нас баралт 11 байгаа нь өмнөх оны мөн үе /12/-оос 1 нэгжээр буюу 8.4 хувиар буурсан, гэмтсэн хүн 19 байгаа нь өмнөх оны мөн үе /12/-оос 7 нэгжээр буюу 36.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэн прокурорын байгууллагад хянуулсан.

Зам тээврийн осол, хэргийн шалтгаан нөхцөлийг авч үзвэл хурд хэтрүүлж, зогсоох арга хэмжээ аваагүй, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, эсрэг урсгал сөрсөн, эгнээ хоорондын зайг тохируулж хурдаа сонгож яваагүй, мотоцикл жолоодож онхолдсон зэрэг шалтгаантай байна.

Захиргааны зөрчлийн шалгалт, шийдвэрлэлтийн талаар

Тайлангийн хугацаанд алба хаагчид гудамж замын хяналт шалгалтаар 48430 тээврийн хэрэгсэл шалгаснаас 13184 зөрчил илрүүлж, 12046 хүнийг 570.705.000 төгрөгөөр торгосон нь урьд оны мөн үе /8214/-өөс 4970 нэгжээр буюу 37.7 хувиар өссөн.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 591 зөрчил илрүүлж, 501 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 200.400.000 төгрөгөөр торгон 90 иргэнийг Сум дундын шүүхээр баривчлуулан албадан сургалтад хамруулан ажиллав.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний сахилга, соёлыг дээшлүүлэхэд анхаарч, гарч буй хэрэг, ослын шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор аж ахуй нэгж байгууллагад 32 мэдэгдэл, шаардлага хүргүүлэн биелэлт, үр дүнг тооцон, хариуг авч ажилласан.

Нэгдсэн болон хэсэгчилсэн хяналт шалгалтыг 69 удаа, Авто тээврийн төвтэй хамтарсан хяналт шалгалтыг 37 удаа зохион явуулж Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс болон Тээврийн цагдаагийн албанаас цахим орчинд байршуулсан мэдээлэл, гарын авлага, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлгээс 8000 ширхгийг хэвлүүлэн жолооч нарт тарааж ажилласан.

1. Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран зохион явуулж байгаа “Би хариуцлагатай” аяны хүрээнд хэвлүүлсэн зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн 10 төрлийн санамж сэрэмжлүүлгийг Даланзадгад-Улаанбаатар чиглэлийн автозамд хөдөлгөөнд оролцож байгаа иргэд, жолооч нарт болон нүүрс тээврийн автозам /цагаан хад/-д хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарт нийт 4000 ширхгийг тараасан.

2. Коронавирусын халдварт өвчинтэй холбогдуулан нийслэлээс орон нутаг, аймгаас аймгийн хооронд маршрутын бус замаар хүн тээвэрлэн хөдөлгөөнд оролцож байгаа зөрчлийг илрүүлэх таслан зогсоох зорилгоор Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, Ханбогд, Гурвантэс сум дахь цагдаагийн тасгууд болон Эрүүгийн цагдаагийн тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Дундговь, Дорноговь, Өвөрхангай аймаг дахь замын цагдаагийн тасагтай хамтран “Хулгайн тээвэр” хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, маршрутын бус замаар зөвшөөрөлгүй зорчигч тээвэрлэсэн 23 зөрчил илрүүлж, маршрутын бус замаар хөдөлгөөнд оролцохын хор уршиг, холбогдох хууль тогтоомжоор 2 төрлийн гарын авлага, санамж, сэрэмжлүүлэг бэлтгэн Цогт-Овоо сумын хяналтын постод байрлуулан 750 иргэд, жолоочид тараан ажилласан.

3. Цагдаагийн газрын даргын баталсан төлөвлөгөөний дагуу 02 дугаар сарын 04-ний өдрийн 02 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд сар шинэ-2021” хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион явуулж, эргүүл, хяналт шалгалтаар ажиллах алба хаагчдын хуваарийг гарган бусад албадын алба хаагчдыг давхардуулахгүйгээр өдөрт 5 цагаар төвийн автозамуудад ажиллуулж, гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг зохион явуулсан. Хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд нийт 1156 зөрчил илрүүлснээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 96 иргэнийг илрүүлэн 87 иргэний тээврийн хэрэгсэл

жолоодох эрхийг хасаж 34.800.000 төгрөгөөр торгож 9 иргэнийг сум дундын шүүхэд шилжүүлэн 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж, гарч болзошгүй 96 зам тээврийн ослоос урьдчилан сэргийлсэн байна.

Сар шинийн баярын шинийн 1, 3-ны өдрүүдэд аймгаас зүүн урагшаа байрлах Хан-Уул, баруун зүгт байрлах Хийморийн овооны чиглэлд нар харах иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлаж, Нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчидтай хамтран хамгаалалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулсан. “Сар шинэ 2021” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд аймгийн төвийн автозамын хяналт шалгалтыг эрчимжүүлснээр зам тээврийн осол бүртгэгдээгүй байна.

4. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжоор байгууллагын ажилтан, албан хаагчдад сургалт зохион явуулах тухай 04, 05 дугаартай албан мэдэгдлүүдийг Хилийн 0131-р цэргийн ангид хүргүүлсэн.

5. “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Март-8” хэсэгчилсэн арга хэмжээг Ханбогд сумын нутагт зохион явуулж хөдөлгөөнд соёлтой, дүрмээрээ оролцсон 50 эмэгтэй жолоочид Монгол улсын Замын хөдөлгөөний дүрмийн заалтаар хийсэн хөзрийг сарнай цэцгийн хамт тараасан.

6. Тээврийн цагдаагийн албанаас ирүүлсэн 21 аймгийн зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн видео шторкийг Өмнөговь Цагдаагийн газар Facebook хаяг, Өмнөговь аймгийн зарын 10 групп, томоохон сумд болох Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумдын болон Таван толгой цагаан хадны жолооч нарын, Өмнөговь аймгийн Автомашины нэгдсэн зар харьяа Цагдаагийн хэлтэс, тасаг хэсгүүдийн 400.000 гаруй дагагчтай 24 групп хуудсанд байршуулан иргэд, олон нийтэд хүргэж байна.

7. “Ээлтэй Өмнөговь” хөтөлбөрийн хөтөлбөрийн хүрээнд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Зүрх зогсохгүй” нөлөөллийн аяныг энэ оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион явуулж байна.

Нөлөөллийн аяны хүрээнд энэ сард зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх 5 постер, 2 видео шторк хийлгэн орон нутгийн “Алтанговь”, “Говь HD”, “Говийн наран” телевизүүд болон Өмнөговь цагдаагийн газар фэйсбүүк цахим орчноор иргэд, олон нийтэд хүргэсэн.

8. “Мотоцикл, улсын дугаар, зорчигч тээвэр” хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн.

Тээврийн цагдаагийн албаны даргын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 14/776 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээлэл, ажлын чиглэлийн дагуу аймгийн 15 сум 59 багийн иргэд, малчдын хэрэглэж байгаа болон эвдэрсэн мотоцикл, хамгаалах малгайны судалгааг сум, багийн засаг дарга, хэсгийн төлөөлөгч нартай хамтран гаргаж, улсын бүртгэлийн дугааргүй 4987 тээврийн хэрэгслүүдэд дугаар олгох, эвдрэлтэй хөдөлгөөнд оролцдоггүй 227 мотоциклыг улсын бүртгэлээс хасуулах ажлыг Автотээврийн төвтэй хамтран зохион байгуулж байна.

Мотоциклтой холбоотой ослын улмаас иргэдийн ам, нас эрүүл мэнд хохирхоос урьдчилан сэргийлэх, учирч болох эрсдлийг бууруулах зорилгоор мотоциклтой иргэдэд 200 хамгаалах малгайг үнэ төлбөргүй тараах ажлыг зохион байгуулж аймгийн Засаг даргын тамгын газраас 5.000.000 төгрөг шийдвэрлүүлэхээр захирамж гаргуулан ажиллаж байна.

Арга хэмжээний хүрээнд Ханбогд сум дахь цагдаагийн тасгаас “Иж” сонирхогчдын клубийн гишүүдтэй хамтран 30 ширхэг хамгаалах малгайг сумын мотоцикл сонирхогч

иргэдэд 30 ширхэг хамгаалах малгайг Замын хөдөлгөөний дүрмээр бэлтгэсэн хөзрийн хамт тараасан.

Хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд алба хаагчид гудамж замын хяналт шалгалтыг эрчимжүүлж Даланзадгад сумын төвд 6 алба хаагч аймгийн төвөөс Улаанбаатар хот руу чиглэсэн улсын чанартай автозамын 2.5 дахь км-т, Цогтцэций сумын цагдаагийн хэлтсээс 5 алба хаагч сумын төв рүү орох, гарах автозамд болон нүүрс тээвэрлэлтийн автозамын 6 дахь км-т, Ханбогд сумын цагдаагийн тасагт 2 алба хаагч сумын төвөөс орох, гарах автозамд, Гурвантэс сумын цагдаагийн тасагт 1 алба хаагч сумын төв рүү орох гарах автозам, нүүрс тээвэрлэлтийн автозам болон хил орчимд, Гэрээт цагдаагийн хэлтсээс 27 алба хаагч нүүрс тээвэрлэлтийн 239 км хатуу хучилттай автозам, Ханбогд сумын Хайрхан баг /Цагаан хад/ орчимд замын хяналт, шалгалтыг тогтмол зохион явуулж нийт 4836 зөрчил илрүүлснээс мотоциклтой хөдөлгөөнд оролцож зөрчил гаргасан 68 үүнээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ мотоцикл жолоодсон 6 иргэнийг сум дундын шүүхэд шилжүүлэн 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж, хамгаалах малгай хэрэглээгүй мотоцикл жолоодсон 24 зөрчил илрүүлж Зөрчлийн хуулийн дагуу хариуцлага тооцсон байна.

Мотоциклтой холбоотой зам тээврийн ослын хор уршгийг иргэд, олон нийтэд ойлгуулах, хамгаалах малгай хэрэглэж хөдөлгөөнд оролцохгүй байх, гаргасан зөрчилд хариуцлага тооцох утгатай санамж, сэрэмжлүүлэг 1000 ширхгийг хэвлүүлэн иргэдэд тарааж, мотоциклын банканд нааж өгсөн.

9. Тээврийн цагдаагийн албаны даргын 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 15/579 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээлэл, зөвлөмжийн дагуу бага насны хүүхдийг зам тээврийн осол хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс үр хүүхдэдээ тавих хараа хяналтыг сайжруулах тухай санамж, сэрэмжлүүлэг хүргэх ажлыг зохион байгуулж, “Таны автомашины дэргэд бяцхан хүүхэд тоглож байж мэднэ”, /Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн 10.1. Жолооч хөдөлгөөн эхлэхийн өмнө зам, орчны байдлыг биеэр шалгаж хөдөлгөөн эхлэх, зогсохдоо аюул, осол үүсгэхгүй бүх нөхцөлийг хангах ёстой/. “Жолооч таны хайхрамжгүй хандсан ганцхан үйлдэл “Бяцхан зүрх”-ийг зогсоож мэднэ”, “Авто машинаа тойрч шалгахад ердөө хэдхэн хором “Бяцхан зүрх” бүхний төлөө жолооч “Та хичээгээрэй”, “Авто машинаа зогсоох аюулгүй хэсгийг бэлд” “Эхлээд хар, тойрч шалга, дараа нь хөдөл” гэх утга бүхий зөвлөмж, зурагт хуудсыг 8000 ширхгийг хэвлүүлэн Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст 2000, Гурвантэс, Ханбогд сумдын цагдаагийн тасагт тус бүр 1500 ширхгийг хүргүүлэн айл өрх, хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн жолооч нарт тараах ажлыг зохион байгуулсан.

Алба хаагчид эцэг эх, асран хамгаалагчид санамж, зөвлөмж хүргэх ажлын хүрээнд Даланзадгад сумын нутаг дэвсгэрт хашаа байшинд амьдардаг 1400 айл өрхөд, Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хашаа байшинд амьдардаг 900 айл өрхөд, Гурвантэс сумын нутаг дэвсгэрт хашаа байшинд амьдардаг 396 айл өрхөд, Ханбогд сумын нутаг дэвсгэрт хашаа байшинд амьдардаг 410 айл өрхөөр явж бэлтгэсэн санамж, зөвлөмжийг тараасан.

10. Энэ оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион явуулсан “Хүүхдэд ээлтэй жолооч” нэгдсэн арга хэмжээний хүрээнд бага насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах ажлыг хийж хэрэгжүүллээ. Үүнд:

-Аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран төлөвлөгөөний хавсралтаар ирүүлсэн сэрэмжлүүлэг бүхий /хавсралт 1/ зурагт хуудас, “Бага насны хүүхдийн автомашинд аюулгүй тээвэрлэх зөвлөгөө”, “Жолооч та автомашинаа хөдөлгөхөөсөө өмнө

шалга”, “Гарцаар гарах хүүхдэд зам тавьж өгөөрэй”, “Хамгаалах бүс, хамгаалах суудал” хэрэглэх /Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 20, 38 дахь хэсгийг тайлбарласан санамж, сэрэмжлүүлэг тус бүр 3000 ширхгийг хэвлүүлэн хөдөлгөөнд оролцож байгаа жолооч, эцэг эхчүүдэд тараасан.

Тээврийн цагдаагийн албаны даргын 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 14/799 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хавсралтаар ирүүлсэн автомашиныг аюулгүй зогсоох зааврыг 5000 ширхэг хэвлүүлэн хатуу хучилттай автозам дагуу, төв суурин газрын ойролцоо амьдардаг малчин өрхүүдэд тараасан.

Гэрээт цагдаагийн хэлтсээс Ханбогд сум Хайрхан багийн нутаг дэвсгэрт байрлах Тайван авто зогсоол цогцолборын дотор болон гадна зогсоолын талбайд байрлуулсан авто машин эзэмшигч жолооч, зорчигч, эцэг эхчүүдэд хүүхдийг зам тээврийн хэрэг ослоос урьдчилан сэргийлэх үүднээс 2965 зөвлөмж тараасан.

-Нийтийн хэв журам хамгаалах тасагтай хамтран тус аймгийн төвд хатуу хучилттай автозамтай ойр байрлах айл өрхүүд болох Баруун сайханы 1-р баг, Дунд сайханы 4-р баг, Зүүн сайханы 5-р баг, Нанзад 8-р багуудад 6 чиглэлд 12 алба хаагчийг өдөр бүр 12:00 цагаас 20:00 цагийн хооронд эргүүл, хяналт шалгалтаар ажиллуулж, хараа хяналтгүй, харгалзах хүнгүй замын хөдөлгөөнд оролцсон, автозамын ойр орчимд тоглосон 96 хүүхдийг эцэг, эх асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, дахин хүүхдээ хараа хяналтгүй тоглуулахгүй байх баталгаа бичүүлэн, судалгаанд авч, бэлтгэсэн санамж, сэрэмжлүүлгүүдээс тарааж өгсөн.

“Цагаан хад суурьшлын” бүс нутагт амьдарч байгаа 128 өрхийн 61 хүүхдийн судалгааг гаргаж хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, хүүхдэд тавих хараа хяналтаа сайжруулах үүднээс жолооч эцэг, эхчүүд хөдөлгөөн эхлэхдээ зам орчны байдлыг биеэр шалгаж хөдөлгөөн эхлэх талаар ухуулга яриаг хийсэн.

-Төлөвлөгөөний хавсралтаар ирүүлсэн баннер /хавсралт-2/-ыг аймгийн төвд 4, Гэрээт цагдаагийн хэлтэс, сум дундын Цагдаагийн хэлтэс, тасгууд тус бүр 2 ширхгийг хэвлүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газар, Даланзадгад сумын засаг даргын тамгын газар, Хөгжимт жүжгийн театр, Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит компани, Даланзадгад сумын Захирагчийн ажлын алба, жолооч бэлтгэх сургалтын үйл ажиллагаа явуулдаг “Арвижих говь”, “Дэгжих говь”, “Задлин” авто сургуулиудаар аялуулан 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүй замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, учирч болох хор уршгийг таниулж, нийт 423 ажилтан, албан хаагчдад ухуулга яриа хийсэн.

-Даланзадгад сумын төвд Ерөнхий боловсролын 5 сургууль байгаагаас автозамтай ойр байрлах 3 сургуулийн судалгааг гарган төлөвлөгөөний хавсралтаар ирүүлсэн танилцуулга /хавсралт-3./-ын хамт аймгийн засаг даргын тамгын газар, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлсэн. Энэ оны нэгдүгээр улиралд зохион байгуулагдсан “Би хариуцлагатай жолооч” аяны хүрээнд аймгийн төвийн 5 авто сургуулийн явган хүний гарцад гэрэлтүүлэг хийхээр төлөвлөсөн ажил 60 хувьтай хийгдэж байна.

-Замын цагдаагийн тасгаас Цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ахлах мэргэжилтэн нар болон аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, гэр бүл, хүүхэд залуучуудын газартай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд насны ангиллаар “Хүүхдэд ээлтэй жолооч” сэдэвт гар зургийн уралдааныг зохион явуулж, уралдаанд оролцсон 48 хүүхдийн бүтээлээс 22 хүүхдийн бүтээлийг сонгон “Өмнөговь цагдаагийн газар” Facebook цахим хуудсанд байршуулсан.

- Нэгдсэн арга хэмжээний хүрээнд Орон нутгийн “Алтанговь”, “Говь HD” телевизүүдтэй хамтран замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

О.Чинзориг, ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Т.Түмэнжаргал, хүүхдийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч У.Ууганбаяр нар тус бүр 2 удаа Цагдаагийн байгууллагаас хийж хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаар болон эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, зам тээврийн ослын хор уршгийг таниулах, хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл өгсөн.

-Тээврийн цагдаагийн албанаас бэлтгэсэн “Хүүхдэд ээлтэй жолооч” Фейсбүүкийн прэйм /хүрээ/-ээр алба хаагчдын фейсбүүкийн хүрээг солих ажлыг зохион байгуулж 164 алба хаагч Фейсбүүкийн прэймээ сольж иргэд, олон нийтийг уриалсан.

-Замын хөдөлгөөний дүрмийн 23.8, 23.9 дэх заалтын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Даланзадгад сумын төвд 5 алба хаагч аймгийн төвөөс Улаанбаатар хот руу чиглэсэн улсын чанартай автозамын 2.5 дахь км-т, Цогтцэций сумын цагдаагийн хэлтсээс 4 алба хаагч сумын төв рүү орох, гарах автозамд болон нүүрс тээвэрлэлтийн автозамын 6 дахь км-т, Ханбогд сумын цагдаагийн тасагт 2 алба хаагч сумын төвөөс орох, гарах автозамд, Гурвантэс сумын цагдаагийн тасагт 1 алба хаагч сумын төв рүү орох гарах автозам, нүүрс тээвэрлэлтийн автозам болон хил орчимд, Гэрээт цагдаагийн хэлтсээс 15 алба хаагч нүүрс тээвэрлэлтийн 239 км хатуу хүчилттай автозам, Ханбогд сумын Хайрхан баг /Цагаан хад/ орчимд замын хяналт, шалгалтыг тогтмол зохион явуулж суудлын болон ачааны автомашины бүхээгт 10 хүртэлх насны хүүхдийг тээвэрлэхдээ биеийн жин, өсөлтөд нь тохирсон зориулалтын нэмэгдэл суудал, хамгаалах хэрэгсэл ашиглаагүй, хамгаалах бүсийг хэрэглээгүй зориулалтын бус хэсэг болон бусад зорчигчийн өвөр дээр, суудлын тооноос олон зорчигч тээвэрлэсэн зөрчилд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлэн нийт 6855 тээврийн хэрэгсэл шалгаснаас дээрх төрлийн 493 зөрчил илрүүлж, 208 иргэний зөрчлийг газар дээр нь арилуулан Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 20 дахь хэсэгт зааснаар 214 иргэн, 21 дэх хэсэгт зааснаар 46 иргэн, 45 дахь хэсэгт зааснаар 25 иргэнд хариуцлага тооцож, Аймаг сумаас гарах хяналтын цэгүүдэд ажиллаж байгаа алба хаагчид Улаанбаатар хот болон хот хоорондын чиглэлд хөдөлгөөнд оролцож байгаа 967 тээврийн хэрэгслийн зорчигч бүрийн хамгаалах бүсийг зүүлгэж, хурдаа тохируулж хөдөлгөөнд оролцох, ядрах, нойрмоглох үедээ тээврийн хэрэгслээ зогсоож амрах, автомашинаас бууж нойроо сэргээх, биеийнхээ чилээг гаргах зэрэг анхааруулга сэрэмжлүүлгийг амаараа өгч хөдөлгөөнийг эхлүүлэн ажилласан байна.

Аймгийн төвд бага насны хүүхдийг зориулалтын нэмэгдэл суудалд тээвэрлээгүй хөдөлгөөнд оролцсон 361 жолооч, эцэг эхчүүдэд зөрчлийн хор уршгийг тайлбарлан ойлгуулж, дахин зөрчил гаргахгүй байх талаар баталгаа авч ажилласан.

-Даланзадгад сумын 3 дугаар багийн нутагт байрлах 18 дугаар байр, Гандирс хорооллын дунд байрлах хүүхдийн тоглоомын талбай нь автозам, зогсоолтой ойр байрлаж байгаа нь хүүхэд зам тээврийн осолд өртөж хохирох эрсдэлтэй байх тул уг тоглоомын талбайнуудыг хашаатай болгох тухай 18 дугаартай албан мэдэгдлийг судалгааны хамт Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

-Нэгдсэн арга хэмжээний хүрээнд орон нутгийн “Алтанговь”, “Говь HD” телевизүүдтэй тус бүр 1 удаа хамтран Даланзадгад-Улаанбаатар чиглэлийн улсын чанартай автозамд хяналт шалгалтаар ажиллаж жолооч нарын гаргадаг нийтлэг зөрчил, хүүхдийг зориулалтын бус суудалд тээвэрлэх, хамгаалах бүс, хамгаалах малгай хэрэглэхгүй байхын хор уршгийн талаар 10 минутын 2 сэрэмжлүүлэг нэвтрүүлэг бэлтгэн долоо хоногт 5 удаагийн давтамжтай иргэд, олон нийтэд хүргэсэн.

11. Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Улс, аймгийн Онцгой комиссоос гаргасан шийдвэр, Цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээ, мэдээллийг аймгийн

Говь HD, Говийн наран телевизүүдэд тус бүр 3 удаа өгч, Өмнөговь Цагдаагийн газар Facebook хаяг болон пэйж хуудсаар сурталчлан, иргэдэд хүргэх ажлыг зохион явуулахын зэрэгцээ Өмнөговь аймгийн зарын 10 групп, томоохон сумд болох Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумдын болон Таван толгой цагаан хадны жолооч нарын, Өмнөговь аймгийн Автомашины нэгдсэн зар харьяа Цагдаагийн хэлтэс, тасаг хэсгүүдийн 400.000 гаруй дагагчтай 24 групп хуудсанд байршуулан иргэд олон нийтэд сурталчилсан.

Замын зохион байгуулалтын чиглэлээр:

Замын зохион байгуулалтын чиглэлээр хийгдсэн дараах ажил, арга хэмжээнүүдэд хяналт тавин ажиллав.

-Мандалговь-Даланзадгад чиглэлийн улсын чанартай хатуу хучилттай автозамын Шар тээгийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км автозамаар зорчих тээврийн хэрэгслийн нэг тэнхлэг дээрх болон бүх жингийн стандартаар тогтоосон зөвшөөрөгдөх дээд хэмжээг мөрдүүлж хяналт тавих ажлын хүрээнд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 40 ширхэг тэмдэг, уг замаас гарсан, орсон 44 гарцад хаалт хийж, өндрийн хязгаарлалт 6 ширхгийг байрлуулсан.

-Даланзадгад сумын төвийн автозамын зохицуулдаг 9 уулзвараас 7 уулзварын 28 гэрлэн дохионуудад засвар үйлчилгээ хийх, шаардлагатай гэрлэн дохиог шинэчлэх, хэвийн ажиллагааг тогтмол хангах тухай 06 дугаартай албан мэдэгдлийг Даланзадгад сумын захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.

-Аймгийн хэмжээнд 2021 он 03 дугаар сарын 04-ний өдрөөс 05-нд шилжих шөнө цас ихээр орж, автозамын зорчих хэсэгт халтиргаа гулгаа үүссэн тул автозамын цасыг хусах, давс, элс цацаж хайлуулах ажлыг нэн дариу зохион байгуулах тухай 07 дугаартай албан мэдэгдлийг Даланзадгад сумын Захирагчийн ажлын албанд хүргүүлэн гарч болзошгүй зам тээврийн ослоос урьдчилан сэргийлсэн.

-Энэ оны 03-р сарын 14-ний өдөр Говийн бүсийн нутгаар хүчтэй шороон шуурга шуурсаны улмаас аймгийн төвийн автозам дагуу байрлуулсан тэмдгүүд эргэж өөр зүгт харсан, мурийж эвдэрсэн, бүдгэрч үзэгдэх байдал нь муудсан байсан тул тэмдгүүдийг зөв байрлуулан, засварлуулах, угааж цэвэрлэх тухай 08 дугаартай албан мэдэгдлийг Даланзадгад сумын Захирагчийн ажлын албанд хүргүүлэн аймгийн төвийн автозам дагуу байрлуулсан 823 тэмдгийг угааж үзэгдэх орчныг сайжруулан, 21 тэмдгийг засварлуулсан байна.

-Ханбогд сум Хайрхан багын нутаг дэвсгэр Цагаан суурьшлын бүс худалдаа үйлчилгээний төв болон жишиг хороололд орох, гарах нэг чигийн хөдөлгөөний зохицуулалт бүхий өндрийн хаалтыг Гашуун сухайт авто зам ХХК-н ажилтантай хамтран будаж сэргээн өндрийн хязгаар 2.13 тэмдэг 2 ширхэг, орох хориотой 2.1 тэмдэг 2 ширхэг тус тус байрлуулсан.

-Автозам засварын “Таны зам” ХХК-ийн 2020 онд байрлуулсан тэмдгүүд салхинд эргэж, өөр тийш харсан тул тэмдгүүдийн доор чагт хийж бетон зутгаж, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллах тухай №09 дугаартай мэдэгдлийг 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “Таны зам” ХХК-д хүргүүлсэн.

-Ханбогд сумын Иргэдийн төлөөлөгчид, Засаг даргын Тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Залуучууд хөгжлийн төв, Засаг даргын дэргэдэх залуучуудын салбар зөвлөл, "Galba motors mongolia" клубийн ажилтан, албан хаагчидтай хамтран сумын төвийн автозам дагуу эргэсэн, хазайсан, хандалт буруу, өнгө нь арилсан гэх мэт 42 ширхэг тэмдэг, 23 ширхэг гарцыг шинэчлэн засварласан. Мөн будаг нь арилж, үзэгдэх байдал нь муудсан 3 хурд сааруулагчийг будаж, өнгийг сэргээсэн.

-Автозам засварын “Таны зам” ХХК аймгийн Засаг даргын Тамгын газартай ӨМЗЗА-2020/01 дугаартай гэрээ байгуулан аймгийн төвийн автозамын засвар арчлалтыг хариуцан ажиллаж байна. 06 дугаар сард “Таны зам” ХХК аймгийн төвийн автозам дагуу 65 м3 хоолой усны шуудууг цэвэрлэж, өөр зүгт харсан 90 тэмдгийн чиглэлийг зөв байрлуулан суурь бетон цутгаж, хуучирч муудсан 108 ширхэг тэмдгийг засварлаж Замын цагдаагийн тасагт тайлангаа ирүүлсэн байна.

-Жолооч орон нутгийн замд ядарсан үедээ автомашин жолоодож яваад зүүрмэглэх, унтах зэрэг үйлдлийн улмаас хяналтаа алдаж осол гарах шалтгаан болдог тул Даланзадгад Мандалговь чиглэлийн 154 километр улсын чанартай /А0202/ автозамыг хариуцсан АЗЗА “Дашзам” ХХК-тай хамтран өнгөрсөн онд 50 километр тутамд 6 аюулгүйн зогсоол шинээр хийсэн. Энэ онд дээрх 6 зогсоолоос 4 зогсоолыг тохижуулах /*зогсоолын гэрэлтүүлэг, автозамаас тусгаарласан түмбэ, 00, хогийн сав байрлуулах*/, жолооч нарын анхаарал болгоомжийг дээшлүүлэх чиглэлээр 5 байршилд гэрэлтүүлэгтэй анхааруулах самбар, 17 байршилд цэнхэр улаан гэрэл 24 цагаар анивчиж асах нарны гэрлээр ажилладаг спичкэн гэрэл байрлуулах ажлыг “Хас вишн” ХХК хийж байна. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

-Орон нутгийн 79.591.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус аймгийн Даланзадгад Баяндалай чиглэлийн улсын чанартай /А33/ автозамын 6 дахь километр цагдаагийн байнгын хяналтын цэг /пост/-ийн 10м X 8м хэмжээтэй байр барих ажлыг “Нүүдэлчин санаа тур” ХХК энэ оны 06 дугаар сарын 08-ны өдөр эхэлсэн. Өнөөдрийн байдлаар барилгын ажил 70%-ийн гүйцэтгэлтэй байна. Замын цагдаагийн тасгаас барилгын ажлын явц, байдалд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Техник, замын хяналтын чиглэлээр:

Тээврийн хэрэгслийн техникийн эвдрэл гэмтэлтэй, улсын бүртгэл, техникийн хяналтын үзлэгт ороогүй зөрчлийг арилгуулах, тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгслийн бүрэн бүтэн байдалд тавих хяналт шалгалтыг сайжруулах ажлын хүрээнд:

1. А-0202 кодтой “Даланзадгад-Улаанбаатар” чиглэлийн замд 6 удаа хяналт шалгалтыг зохион байгуулсан.

2. Тус аймгийн Цогт-Овоо, Даланзадгад, Цогтцэций сумдын байнгын хяналтын постуудыг 24 цагаар ажиллуулан хяналтын цэгээр дамжин өнгөрсөн тээврийн хэрэгсэл, иргэн бүрийг бүртгэн, Дундговь, төв аймаг дахь цагдаагийн газартай мэдээлэл солилцон, харилцан уялдаа холбоотой ажиллаж, Цогт-Овоо, Даланзадгад сумдын байнгын хяналтын постод байрлуулсан тээврийн хэрэгслийн дундаж хурдыг тодорхойлох хяналтын камераар хурд хэтрүүлсэн 56, техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамруулаагүй тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон 69 зөрчил илрүүлэн хариуцлага тооцож ажилласан.

Дээрх хяналтын төхөөрөмжийн Цогт-Овоо сумын нутагт байрлуулсан төхөөрөмжийг 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр А.Лундаажанцан нь Хово маркийн ачааны автомашинд ачиж явсан экскаватороор шүргэж унагасан зам тээврийн ослын улмаас камер ажиллахгүй болсон, зөрчил гаргасан жолоочоор хяналтын камерын хөлийг засварлуулж угсруулж, хяналтын камерыг хэвийн ажиллагаанд оруулах хүсэлтийг “Оргил делта трейд” ХХК-д хүргүүлсэн боловч Коронавирусын халдварт өвчинтэй холбогдуулан “Оргил делта трейд” ХХК-ийн зүгээс ажилчид ирж хяналтын камерыг суурилуулаагүй байна.

3. Тээврийн цагдаагийн албаны даргын баталсан “2021 онд төв, орон нутгийн хэмжээнд зам, тээврийн хяналт зохицуулалтын чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын календарчилсан төлөвлөгөө”-ний дагуу Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа

“Тээврийн хэрэгслийн яндангаас гарах утаа, дуу чимээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрхий их тээврийн хэрэгслүүдэд тавих хяналтыг эрчимжүүлэх” хяналт шалгалтын дагуу Өмнөговь аймгийн Авто тээврийн төв болон Авто тээврийн төвийн Цогтцэций салбартай хамтран ажиллаж, алба хаагчид ажлын тормозын систем, жолооны механизм ажиллахгүй бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй замын хөдөлгөөнд оролцсон 2404 зөрчил илрүүлэн 48.230.000 төгрөгөөр, хурд хэтрүүлсэн 125 зөрчил илрүүлж 6.250.000 төгрөгөөр, үзлэг оношилгоонд оруулаагүй 303 зөрчил илрүүлж 303 жолоочийг 15.150.000 төгрөгөөр, тэмдэг, тэмдэглэгээ зөрчиж маршрутын бус замаар хөдөлгөөнд оролцсон 234 зөрчил илрүүлж 35.100.000 төгрөгөөр, тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл хэрэглэх журам зөрчсөн 227 зөрчил илрүүлж 4.540.000 төгрөгөөр тус тус торгож ажилласан.

4. Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, ачаа тээвэрлэлт, гадна талын гэрэлтүүлэх хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ачааны авто машины ар талд овор хэмжээг тодотгох, үзэгдэлтийг сайжруулах зорилгоор гэрэл ойлгох шинж чанар бүхий туузан наалт байрлуулсан эсэхэд хяналт тавих, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох зорилгоор “Ачааны автомашин-Ачаа тээвэрлэлт” нэгдсэн хяналт шалгалтыг зохион явуулсан. Хяналт шалгалтаар Замын хөдөлгөөний дүрмийн 4 дүгээр хавсралт “Тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглох эвдрэл, гэмтэл техникийн зөрчлийн жагсаалт”, “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS:4598 стандартад нийцэж байгаа эсэх, ачааг тээвэрлэхдээ Замын хөдөлгөөний дүрмийн 24 дүгээр бүлэг “Ачаа тээвэрлэх” журамд заасан шаардлагыг хангасан эсэх, ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй хүн, хуулийн этгээд нь Замын хөдөлгөөний дүрмийн 27 дугаар бүлэг “Замын хөдөлгөөнд оролцогчоос бусад иргэн, хуулийн этгээдийн үүрэг”-ийг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавьж арга хэмжээний хүрээнд нийт 6236 тээврийн хэрэгсэл шалгаснаас бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй замын хөдөлгөөнд оролцсон 891 зөрчил илрүүлж, 891 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 14.7 дугаар зүйлийн 14, 15 дахь хэсэгт заасны дагуу 17.840.000 төгрөгөөр торгосон. Үүнээс Замын хөдөлгөөний дүрмийн 3 дугаар хавсралтын 4-т заасан ачааны автомашины ар талд түүний овор хэмжээг тодотгох, үзэгдэлтийг сайжруулах зорилгоор гэрэл ойлгох шинж чанар бүхий туузан наалт эсхүл улаан өнгийн гэрэл ойлгуурыг нэмж байрлуулаагүй 62 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулсан.

Мөн дүрмийн 4-р хавсралтын 5.1, 5.3, 6.15, 6.6 дахь хэсэгт заасан зөрчлүүдэд тавих хяналтыг эрчимжүүлж гадна талын гэрэл, гэрэлтүүлэх хэрэгсэл бүрэн бус 86 жолоочийг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 41 дэх хэсэгт заасны дагуу хариуцлага тооцсон. Гэрлийн бүрхүүл бохирдсон, хагарч цөмөрсөн, байхгүй болсон буюу бүрхүүл дээр өнгөт хальс наасан, гэрэл нь асахгүй, бүдэг асдаг болсон 21, бүхээгийн шилэн дээр хөшиг татсан, цацаг унжуулсан, салхины шил их хэмжээгээр цуурсан 12, ачааны автомашины эмийн сан, гал унтраагуур, ослын зогсолтын тэмдэг, хол, ойрын болон оврын гэрлийн нөөц чийдэн байхгүй 35, тээврийн хэрэгслийн бүхээг, урд буфер, нүүр копуд дээр нэмэлтээр туузан, лед, өндөр хүчин чадал бүхий тусгалтай, ангийн болон аяллын зориулалтаар суурилуулсан гэрэлтүүлэгтэй 23 зөрчил илрүүлэн зөрчлийг арилгуулж, хариуцлага тооцсон.

5. Тус аймгийн Даланзадгад сумын төвд байрлах Зэвсэгт хүчний 167 дугаар цэргийн ангийн 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 108 дугаартай албан бичгийн дагуу Монгол улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор тэмцээнд оролцох бүрэлдэхүүнийг тээвэрлэх тээврийн хэрэгслүүд, Хилийн 0131-р цэргийн ангийн 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 180 дугаартай албан бичгүүдээр ирүүлсэн хүсэлтийн дагуу орон нутагт цэрэг

тээвэрлэх тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдалд урьдчилсан үзлэг, шалгалт явуулж, илэрсэн зөрчлийг арилгуулан, жолооч нарт зааварчилгаа өгсөн.

6. Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргаас өгсөн үүргийн дагуу алба хаагчдыг эргүүл шалгалтаар ажиллах үед нь бэлэн бусаар оногдуулсан торгууль нөхөн төлүүлэх чиглэл, зааварчилгааг өгч, тайлангийн хугацаанд бэлэн бус хэлбэрээр оногдуулсан 142 тээврийн хэрэгслийн 8.387.000 төгрөгийн торгуулийг нөхөн төлүүлсэн байна.

Хамгаалалт зохицуулалтын талаар

1. Энэ оны 05 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, 05 дугаар сарын 23, 24, 06 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Тавантолгой-Зүүнбаян-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай танилцах үеийн хамгаалалт зохицуулалтын зураглал, хүн хүч, техник хэрэгслийн тооцоог тухай бүр гаргаж Цагдаагийн газрын даргаар батлуулан, Хамгаалалтыг Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/МН/169, МН/70 тоот хамтарсан тушаалаар баталсан “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай Цагдаагийн байгууллага харилцан ажиллах журам”, “Төрийн болон гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үед хамгаалалт зохион байгуулах” /код-506/-д заасны дагуу зохион байгуулж, давхардсан тоогоор 9 алба хаагч 77 цаг үүрэг гүйцэтгэсэн.

2. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч У.Хүрэлсүх, Д.Энхбат нар энэ оны 05 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд тус аймагт ажиллах болсонтой холбогдуулан Замын цагдаагийн тасгаас сонгуульд нэр дэвшигчид замын хөдөлгөөнд оролцох үеийн аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол аваар гарахаас урьдчилан сэргийлэн Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/МН/169, МН/70 тоот хамтарсан тушаалаар баталсан “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагатай Цагдаагийн байгууллага харилцан ажиллах журам”, “Төрийн болон гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үед хамгаалалт зохион байгуулах” /код-506/-д заасны дагуу хамгаалалт, зохицуулалтыг зөрчил дутагдалгүй зохион байгуулсан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд ашиглах саналын хуудас, санал тоолох төхөөрөмж, төхөөрөмжийн дагалдах хэрэгсэл, камер, камерын иж бүрдлийг авахаар хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Н.Самданцоодол, Тагнуулын байгууллагын ажилтантай хамт 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 25-51 ӨМА улсын дугаартай Ford Transt маркийн автомашинаар Улаанбаатар хот явах үед тээврийн хэрэгслийг Авто тээврийн төвд оношилгоонд оруулан техникийн дүгнэлт гаргуулж, саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг Улаанбаатар хотоос тээвэрлэж ирэх үеийн хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан.

Аймгийн төвөөс 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр саналын хуудас болон санал тоолох төхөөрөмжийг 15 сумын 61 хэсгийн хороодод хүргэх ажлыг зохион байгуулж, замын цагдаагийн тасгаас саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг дагалдах хэрэгслийн хамт тээвэрлэх 15 тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг шалгуулсан оношилгооны дүгнэлтэд үндэслэн үзлэг хийж, техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулан, жолооч нарт зааварчилгаа, зөвлөмж өгч, Замын хөдөлгөөний дүрмийг баримтлан хөдөлгөөнд оролцох тухай баталгаа авч, гарын үсэг зуруулсан.

Тус аймагт Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн санал авах 61 хэсгийн хороо байгуулагдаж, Замын цагдаагийн тасгаас 9 алба хаагч сонгуулийн санал авах хэсгийн байрны хамгаалалт зохицуулалтад 7 хоногийн хугацаатай томилогдон үүрэг гүйцэтгэсэн. Замын цагдаагийн тасгаас Эрүүгийн цагдаагийн тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасагтай хамтран 06 дугаар сарын 08-ны өдөр битүүмжилсэн зөөврийн

хайрцгаар санал хураах, 09-ний өдөр сонгуулийн санал авах үйл ажиллагааны хамгаалалт зохицуулалтыг ямар нэгэн зөрчил дутагдалгүй зохион байгуулж, нөхцөл байдлын мэдээг 2 цаг тутамд Тээврийн цагдаагийн албаны Орон нутгийн замын хяналтын хэлтэст мэдэгдэж ажилласан.

3. Коронавирусын халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн 112 иргэнийг Ханбогд, Цогтцэций, Даланзадгад, Гурвантэс сумдаас Улаанбаатар хотын чиглэлд тээвэрлэх үеийн аюулгүй байдлыг хангаж, Замын цагдаагийн тасаг болон Гэрээт цагдаагийн хэлтсээс давхардсан тоогоор 29 алба хаагч 16 удаа хамгаалалт зохицуулалтаар явж, иргэдийг Улаанбаатар хотод зөрчил дутагдалгүй хүргэсэн.

2.5. Шуурхай удирдлагын албаны чиглэлээр:

2021 оны эхний хагас жилд Цагдаагийн газрын 7053102 дугаарын утсанд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн нийт 2053 дуудлага мэдээлэл бүртгэснээс гэмт хэргийн шинжтэй 442, зөрчлийн шинжтэй 1611 үүнээс сураггүй алга болсон, олдсон хүний талаарх мэдээлэл 2, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой нийт 94, зам тээврийн ослын нийт 813 мэдээлэл, хүний биед халдах 91, хулгайлах 14, АСТТХууль зөрчих 47, хүүхдийн эрх зөрчих 10, танхайрах 7, бусад зөрчил 487 бүртгэгдсэн байна.

Үүнээс гадаадын иргэнтэй холбоотой бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн өргөдөл, гомдлын мэдээлэл байхгүй, цагдаагийн алба хаагчтай холбоотой болон бусад төрлийн мэдээлэл бүртгэгдээгүй байна.

Гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл хүлээн авсан даруйд 617 хэргийн газрыг хамгаалалтад авч, жижүүрийн бүрэлдэхүүнийг цаг алдалгүй явуулж, хойшлуулшгүй ажиллагааг хийж, гэмт хэргийн талаар Цагдаагийн газрын дарга болон хариуцсан тасгийн дарга нарт тухай бүрт нь танилцуулан, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ болон орон нутгийн нөхцөл байдал мөн хоногийн хугацаанд хийсэн ажлын талаар дүн мэдээ, хүн хүчний болон шинэ төрлийн короновирусын дэгдэлтээс хамгаалах хөл хорио тогтоосон, шалган нэвтрүүлсэн, хамгаалалт, тусгаарлалт хийсэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үеийн мэдээллүүдийг нэгтгэн Цагдаагийн Ерөнхий Газрын Шуурхай Удирдлагын Штабын Төв жижүүрт болон Мэдээлэл Шуурхай Удирдлагын Төвийн жижүүрт хоног тутамд өгч ажиллалаа.

Цагдаагийн газрын даргаас өгсөн үүргийн дагуу жижүүрийн офицерууд эргүүлд гарч байгаа алба хаагчдад хутганаас хамгаалах хантааз, бээлийг тогтмол өмсгөж албаны бэлэн байдлыг шалган өөрийнхөө болон хамтрагчийнхаа аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллахыг үүрэгжүүлэн, эрүүлжүүлэх саатуулах байрны жижүүр, цэвэр усны харуул болон Монгол банк, шүүхийн харуулуудыг өдөр бүр биечлэн шалгаж аюулгүй байдлаа бүрэн хангаж сонор сэрэмжтэй үүрэг гүйцэтгэх талаар үүрэг чиглэл өгч тэмдэглэл хөтлөн 24 цагаар хяналт тавин ажиллаж байна.

Тус Цагдаагийн газарт 2021 оны эхний хагас жилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, алба хаагчдаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 522, зөрчлийн шинжтэй 1733 нийт 2255 гомдол, мэдээллийг Цагдаагийн газрын нэгдсэн бүртгэлд оруулж аймгийн болон Ханбогд сумын прокурорын газрын тоо бүртгэлийн ажилтанд өдөр бүр цахимаар хүргүүлэн тулгалт хийж ажилласан болно.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 413 өргөдөл, гомдол, мэдээллийг биечлэн хүлээн авч удирдах албан тушаалтанд танилцуулж, шалгах эрх бүхий алба

хаагчид хүлээлгэн өгч, мэдээллийн нэгдсэн санд үнэн зөв, даруй оруулахад тогтмол хяналт тавьж ажилласан.

Мэдээллийн нэгдсэн санд шивэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын товч танилцуулгыг 7 хоног бүрийн мягмар, пүрэв гариг бүр нэгтгэн гаргаж нийт алба хаагч нарт танилцуулж, мэдээллийн нэгдсэн санд шивэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн 8474 ширхэг маягтыг үг үсэг, утга найруулгын алдаагүй, хуулийн зүйл заалтыг зөв сонгосон эсэхэд тасгийн дарга, мэдээлэл судалгааны ажилтнууд өдөр бүр хяналт тавьж алдаатай шивэгдсэн 326 маягтыг шаардлага хангаагүй төлөвт буцааж хариуцсан алба хаагчдаар тухай бүр засуулж ЦБҮАЖ-ын хэрэгжилтийг хангуулан ажиллав.

Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудсаар ирүүлсэн 57, ААНБ-аас албан бичгээр ирүүлсэн 411, нийт 468 иргэний мэдээллийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасны дагуу шалгаж холбогдох алба хаагч, байгууллагад хүргүүлээд байна.

ЦБҮАЖЖурмын код 202, 701, 702, 706-г байгууллагын хэмжээнд бүрэн хэрэгжүүлэх алба хаагч нарын чадварыг дээшлүүлэх зорилгоор алба хаагч нарт цахимаар 326 зааварчилгаа бичиж, 109 алба хаагчид ганцаарчилсан сургалт зохион байгуулж ажилласны дээр тухайн сард тогтмол гаргадаг 12 судалгаа, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан гаргасан судалгаа 55, танилцуулга 21-ийг тус тус боловсруулан холбогдох алба хаагч нарт өгч бүртгэл хөтлөн тасгийн даргаар 7 хоног бүр хянуулж ажилласан байна.

Аймгийн хэмжээний эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын танилцуулга, сумдад үйлдэгдсэн гэмт хэргийн харьцуулсан судалгааг сар бүр 6 удаа гаргаж Цагдаагийн газрын удирдлага, төрөл мэргэжлийн албад, аймгийн Засаг дарга, Хууль эрх зүйн хэлтэс, Сумдын засаг дарга, Статистикийн хэлтэс, Аймаг болон Даланзадгад сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга зэрэг хамтран ажилладаг байгууллагуудад хүргүүлэн мэдээллээр хангаж ажилласан байна.

Тус Цагдаагийн газарт нийт 111 компьютер дагалдах хэрэгслийн хамт, 49 хөдөлгөөнт тоног төхөөрөмж албаны хэрэгцээнд ашиглагдаж байгаад үзлэг засвар үйлчилгээ хийж хэвийн ажиллагааг хангуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд үйлдлийн систем хэрэглээний программ хангамж, байгууллагын дотоод программ суулгах тохируулах хэвийн ажиллагааг үйлчилгээг 78 удаа хийж, 126 удаа хортой код арилгаж, 492 алба хаагчид холбоо, мэдээллийн техник хэрэгсэлтэй ажиллах чиглэлээр ганцаарчилсан заавар, зөвлөмж сургалт өгч ажилласан.

Мөн 31 алба хаагчийн хандах эрхийн хүсэлтийг МТХТ-д явуулан хариуг авч холбогдох алба хаагч нарт зөвлөгөө өгсөн, нийт 262 удаа холбоо мэдээллийн техник хэрэгсэлд засвар үйлчилгээ хийж, теле хяналтын 50 гэмтэл саатал засварлаж, Холбоо зохион байгуулалт 2 удаа хийж, МТХТ-рүү 2 төхөөрөмжийг засварлуулахаар хүргүүлж засварлуулсан ба цагдаагийн алба хаагчийн нийтлэг үүргийн хүрээнд 212 цагийн эргүүл, хамгаалалтын үүрэг гүйцэтгэж ажилласан байна.

Цагдаагийн газрын хэмжээнд зохион байгуулагдсан нийт 114 удаагийн цахим хурал, сургалтын техникийн бэлэн байдлыг хангаж 899 алба хаагчийг хамруулан бүртгэл хөтөлж ямар нэг сааталгүй явуулсны дээр аймгийн шүүхийн шүүх хурлын танхимтай шууд холбогдон зөрчилд холбогдсон 15 иргэний шүүх хурлыг цахимаар явуулж ажиллаа.

Цогт-Овоо сумын нутагт хэт богино долгионы дахин дамжуулах станц суурилуулан, суманд ажиллаж буй алба хаагчдыг богино долгионы станцаар түргэн шуурхай мэдээ

мэдээллийг солилцох боломжийг бүрдүүлсний дээр Даланзадгад сумтай богино долгионы станцаар шууд холбогдох боломжийг бүрдүүлэн ажилласан байна.

2.6. Улсын онц чухал объектын хамгаалалтын талаар:

Улсын онц чухал объектын хамгаалалт болох Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэрийн байгууламжийг гаднын гэмт халдлага, хорлон сүйтгэх ажиллагаанаас хамгаалж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл бололцоогоор ханган, үндсэн чиг үүргээ зохих ёсоор гүйцэтгэж ажиллалаа. 2020 оны 1, 2, 3, 4, 5, 6 дугаар сар, 1, 2 дугаар улирлын хүснэгтэн мэдээ, 7 хоног бүрийн ажлын тайлан, Дотоодын цэргийн тусгай салаанаас 2021 онд зохион байгуулах “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-нд тусгуулах саналыг, “Албан тушаал дэвшүүлэх /код 909/ журам”-д заасан болзол, шаардлага хангасан, офицерын нөөцөд бүртгүүлэх алба хаагчдын холбогдох материалыг, Дотоодын цэргийн тусгай салаанаас 2021 оны эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгах саналыг, Дотоодын цэргийн тусгай салаанаас Коронавируст /Covid-19/ цар тахлын эсрэг вакцинаар нэн тэргүүнд вакцинжуулах шаардлагатай алба хаагчдын судалгааг, Дотоодын цэргийн тусгай салааны алба хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийн баталгааны маягт Хамгаалуулагч байгууллагатай 2020 онд байгуулсан гэрээг дүгнэж нотломжийг Хамгаалуулагч байгууллагатай 2021 оны хамгаалалтын гэрээ “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөлд тусгах саналыг, Дотоодын цэргийн алба-ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, Дотоодын цэргийн тусгай салааны алба хаагчдыг “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх ашгийг хамгаалах” фейсбүүк хаалттай группд байршуулсан ээлжийн амралтын талаарх санал асуулгад хамруулсан судалгааг, ЦЕГ-ын ХНХ-ын бага болон дунд бүрэлдэхүүний судалгаа, Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан 2021 оны 07 дугаар сард дурсгалын “Мөнгөн бөгж”, “Албаны төлөө-I,II,III” зэргийн тэмдгээр шагнуулах болзол шаардлага хангасан алба хаагчдын судалгааг, Дотоодын цэргийн тусгай салааны 2021 оны 3 дугаар сарын бичмэл тайлан, 1 дүгээр улирлын хүснэгтэн мэдээ, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоол “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний холбогдох заалтын биелэлт, “Эрдэнэс таван толгой” ХК-ийг Дотоодын цэргийн хамгаалалтад авах ажлын хүрээнд хийсэн ажлын танилцуулгыг Дотоодын цэргийн тусгай салааны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Дотоодын цэргийн штабаас зохион байгуулсан “Хувь хүн ба хариуцлага” аяны биелэлт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үеийн аюулгүй байдлыг хангах бэлтгэл ажлын нэгдсэн төлөвлөгөөний 5.5 дахь хэсэгт заасны дагуу алба хаагчдад аль нэг нам эвсэл, нэр дэвшигчийн үйл ажиллагааг дэмжих, эсэргүүцэх зэрэг идэвхтэй хэлбэрээр оролцохгүй байх талаарх баталгаа, Му тах цахим тэмцээнд оролцож буй алба хаагчдын нэрс, тус салаанаас 2021 онд хэрэгжилтийг хангах хяналт шинжилгээ үнэлгээ хийж биелэл үр дүнг тооцох бичиг баримтыг жагсаалтад заасан баримт бичгийн хэрэгжилт Дотоодын цэргийн анги, байгууллагын эрсдэлийн менежментийн 2021 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлт, харуулын дарга, ахмад С.Амгаланжаргал ангилал, зэрэглэлээс дээгүүр хошууч цол олгуулах санал, харуулчин, дэд ахлагч Б.Бат-Эрдэнэ нь хугацааны ахлагч цол олгуулах холбогдох материал, 2021 оны 04, 05, 06 дугаар сар, 1, 2 дугаар улирал, эхний хагас жилийн хүснэгтэн мэдээ биелэлт үр дүнг тооцох албан бичгийн хариуг гаргаж тус тус Дотоодын цэргийн штабт хүргүүлэв.

Улсын онц чухал объектын хамгаалалтад гарах харуулын дарга, харуулчдын томилгоог өдөр бүр Цагдаагийн газрын томилгоонд оруулан ажиллаж байна.

Аюулгүй ажиллагааны зааварчилгааг сараар болон өдөр бүр танилцуулж, алба хаагч нэг бүрээр гарын үсэг зуруулан баталгаажуулан ажиллаж байна. Тусгай салааны алба хаагчдын албаны бэлэн байдлыг сайжруулж, сахилга дэг журмыг чангатгах зорилгоор салааны бэлэн байдлыг 8 удаа шалгаж зөрчил дутагдлыг арилгуулав.

Коронавирусийн халдвараас сэргийлэх зөвлөмжийг алба хаагчдад танилцуулан алба хаагчдын хувийн ариун цэвэрт анхаарч урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Улсын онц чухал объектод нэвтэрч буй байгууллагын ажилчдын халууныг хэмжих, гарыг ариутган нэвтрүүлж байна. Үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын сонор сэрэмжийг дээшлүүлэн, объектод газар орны үзлэгийг чанартай зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр нь засуулан хяналтын бүртгэлд тэмдэглүүлж, үйл ажиллагаандаа дотоод хяналт шалгалтыг эрчимжүүлэн ажиллаж байна. Эрсдэлтэй цагийн байдлыг тодорхойлж, урьдчилан сэргийлэх, илрүүлэх таслан зогсоох, албаны бэлэн байдлыг бүрэн ханган ажиллаж байна.

2021 оны эхний хагас жилд ажлаараа манлайлсан 6 харуулын даргын үндсэн цалинг 10-20 хувь, 14 харуулчин ахлагчийг 5-20 хувь нэмэгдүүлж, 1 харуулчин ахлагчийг 3 сар 20 хувь хасаж сайшаал шийтгэлийг хослуулж ажиллалаа.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код: 118 /сургалтын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх/, код: 239 /ажлын байрны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх/, код:951 /алба хаагчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах/, ЦЕГ-ын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2021 оны “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” А/02 дугаар тушаал, Дотоодын цэргийн штабын даргын 2020 оны “Албаны сургалт, бэлтгэлийн хөтөлбөрийг батлах тухай” А/03 дугаар тушаалыг тус тус удирдлага болгон Дотоодын цэргийн штаб, анги, тусгай салбар, салааны алба хаагчдад 2021 онд сургалт, бэлтгэлийг зохион байгуулж ажиллалаа.

“Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай, “Дотоодын цэргийн тухай хууль”, Алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах, журам / шаардлага тавих, хүний бичиг баримт шалгах, түр саатуулах, хуулийн этгээдийн баримт бичиг шалгах, орон байр бусад газарт нэвтрэн орох, үзлэг хийх, эд зүйл бичиг баримт түр хураан авах, тээврийн хэрэгслийг зогсоож шалгах дадал чадвар эзэмшүүлэх, Дотоодын цэргийн алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх, үндэслэл журам сургалт, дадлага, Хууль зүй, Дотоод хэргийн сайдын 2018 оны А/57 дугаар тушаал баталсан “Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг тусгай зориулалтын техникийг хэрэглэх заавар”, Албаны сургалтын төлөвлөгөөний дагуу танхимаар Дотоодын цэргийн алба хаагчийн эрх, үүрэг, эрхийн хязгаарлалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигаар батлагдсан “Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд, Дотоодын цэргийн командлагчийн 2018 оны 12 дугаар сарын04-ний А/16 дугаар тушаал батлагдсан “Дотоодын цэргийн ёс зүйн дүрэм”, ЦБҮАЖ-ын код 921 /Албан үүрэг гүйцэтгэх үед алба хаагч иргэнтэй харьцах, биеэ авч явах байдал/, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал анхаарах асуудал, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн ойлголт, үзэл баримтлал, анхаарах асуудал, Эрүүгийн хууль /Эрүүгийн хуулийн зүйчлэл, анхаарах асуудал/, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ойлголт анхаарах асуудал, Зөрчлийн тухай хуулийн ойлголт анхаарах асуудал, Гэрч хохирогчийг хамгаалах, тухай хуулийн тухай ойлголт, үзэл баримтлал, анхаарах асуудал, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /Цагдаагийн байгууллагын эрх, үүрэг/, Мансууруулах бодис сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай ойлголт, энэ төрлийн бодис

хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, таних арга/, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм”-ийн шинэчилсэн найруулга, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын түүхэн замнал, Дотоодын цэргийн алба ажиллагаа”, Гадаад улс орны цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хөгжлийн чиг хандлагын талаар, Биеийн харилцааны хэлний тухай ойлголт зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.

Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэрийн Объектын харуулд 24 цагаар аюулгүй байдлыг хангаж хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд гүний 1, 2, 3, 4, 5 дугаар худаг, цэвэр усны нөөцийн санг 2 цаг тутамд явганаар болон машинт эргүүлийн журмаар хянаж алба хаагчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа тогтмол өгч, баталгаа гаргуулан гарын үсэг зуруулан ажиллаж байна.

2021 оны эхний хагас жилийн байдлаар объектын 1, 2 дугаар цэгээр байнгын үнэмлэхтэй 554 хүн, түр үнэмлэхээр 189 хүн шалган нэвтрүүлж ажилласан бөгөөд 597 тээврийн хэрэгсэл зохих дүрэм зааврын дагуу шалган нэвтрүүлж хяналтад 2652 хөдөлгөөн авч нийт 3992 хөдөлгөөнийг бүртгэн ажилласан байна.

Харуулчдын сонор сэрэмж, албан үүрэг гүйцэтгэлтийг Цагдаагийн газрын ёс журмын эргүүл, салааны захирагч нар өдөр тутам тогтмол шалгаж нэмэлт үүрэг чиглэлээр хангаж ажиллалаа.

2.7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Өмнөговь аймгийн хэмжээнд Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомж, Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 28 дугаар тогтоолоор “Архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, архинаас татгалзсан иргэдийг ажлын байраар хангах бодлого”, 2020 онд бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийн судалгаа, нөхцөл байдлыг аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах дэд зөвлөлд танилцуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор гэмт хэрэг зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Ээлтэй Өмнөговь” хөтөлбөрийг батлуулсан.

Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээлэл, танилцуулгыг аймгийн Засаг дарга, ГХУСАЗСЗ-д танилцуулан зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2021 онд улсын болон орон нутгийн төсөвт 792.000.000 /долоон зуун ерэн хоёр сая/-ыг урьдчилан сэргийлэх ажлын зардалд тусгуулсан.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2021 оны нэгдүгээр хуралд 2020 оны ажлыг тайлагнаж, гэмт хэргийн криминологи судалгааг гаргаж дийлэнх бүртгэгдсэн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Залилах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, өмчийн эсрэг гэмт хэрэг, архи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийг бууруулах чиглэлээр саналыг оруулж хэлэлцэж 2021 оны төлөвлөгөөнд 13 ажил арга хэмжээг санаачлан хүргүүлж батлуулсан.

Өмнөговь аймгийг 2021 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд тусгагдсан Цогтцэций-Шар тээгийн уулзварын 59.6 км авто замд улсын дугаар таних, тээврийн хэрэгслийн дундаж хурдыг тодорхойлох хяналтын камер суурилуулах. /100.000.000 төгрөг батлагдсан/. Ажлын техникийн нөхцөлийг аймгийн засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 27 дугаар тогтоолоор “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал”-ын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан сар шинийн баяр, амралтын өдрүүдээр аймгаас сумд, сумдаас аймаг руу орох тээврийн хэрэгсэл, иргэдийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/159 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган аймгийн хэмжээнд төрийн бусад байгууллагын ажилтан, албан хаагчдын бүрэлдэхүүнтэй 15 хяналтын цэгийг 2021 оны 02 дугаар сарын 12-ны өглөөний 06:00 цагаас 15-ны өглөөний 06:00 цаг хүртэлх хугацаатай ажиллуулж, Цагдаагийн газраас хяналт тавин, биелэлт, үр дүнг тооцон ажилласан.

Цагдаагийн Ерөнхий Газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Би.....байна”, Экологийн цагдаагийн албанаас зохион байгуулсан хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Эко-2021”, “Байгалиа хамгаалъя” Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 “Бэлгийн мөлжлөг”, 12.6 дугаар зүйл “Биеэ үнэлэхийг зохион байгуулах” гэмт хэрэгт өртөж хохирсон охид, эмэгтэйчүүдийг олж тогтоох, тэдний хууль ёсны эрх ашгийг хангах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тухай гэмт хэргийн хор уршгийг олон нийтэд таниулах зорилгоор “Мөрөөдлийн шүхэр”, “Хүүхэд хамгаалал” зэрэг нэгдсэн арга хэмжээний хүрээнд алба хаагчдыг мэргэжил арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан.

Эко-2021 нэгдсэн арга хэмжээний хүрээнд: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлгийн 24.5, 24.6 дугаар зүйлд заасан хууль бусаар ан агнах, мод бэлтгэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, хэргийн шийдвэрлэлтийг ахиулах, нэгдсэн судалгааны баяжилт хийх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албанаас Монгол Улсын хэмжээнд зохион байгуулсан “Эко-2021” нэгдсэн арга хэмжээг тус цагдаагийн газраас хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ оны 02 дугаар сарын 01 ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгууллаа. Нэгдсэн арга хэмжээг зохион явуулах ерөнхий удирдамжийн дагуу 36 заалт бүхий салбар төлөвлөгөөг боловсруулж, цагдаагийн газрын даргаар батлуулан хариуцсан нутаг дэвсгэрийн 14 сумдын хэлтэс, тасаг, хэсгүүдэд албан бичгээр хүргүүлсэн. Мөн нэгдсэн арга хэмжээтэй давхцуулан 26 заалт бүхий “Судалгаа” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж тухай бүр үр дүнг тооцож ажилласан. Дээрх 2 арга хэмжээг идэвхжүүлэх, сумдын хэсгийн төлөөлөгч, экологийн асуудал хариуцсан байцаагч нарын үйл ажиллагааг эрчимжүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангах зорилгоор дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн даргын зүгээс 01 дугаартай хугацаатай зааварчилгааг хэлтэс, тасаг, хэсгүүдэд хүргүүлж заагдсан хугацаанд тухай бүр үр дүнг тооцож ажилласан. Мөн хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй Баяндалай, Сэврэй, Гурвантэс, Манлай, Мандал-Овоо, Номгон, Ханхонгор, Хүрмэн зэрэг сумдын хэсгийн төлөөлөгч, экологийн асуудал хариуцсан байцаагч нарт үүрэг чиглэл, ажлын зааварчилгааг тогтмол өгч удирдлагаар хангаж ажилласан. Нэгдсэн арга хэмжээний салбар төлөвлөгөөний дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газар, сум дундын ойн анги, Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд хамтарсан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах удирдамж боловсруулан давхардсан тоогоор нийт 31 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран Оюутолгой ХХК-ны биологийн төрөл зүйлийг хамгаалах төслийн хүрээнд Оюутолгой уурхайн нөлөөллийн бүст багтдаг

Манлай, Ханбогд, Баян-Овоо зэрэг сумдын зэрлэг ан амьтдыг хамгаалах зорилгоор “Эко-2021” нэгдсэн арга хэмжээтэй уялдуулан тухайн сумдад хяналт шалгалтын ажлыг сард 2 удаа зохион байгуулах, сумд уруу орох гарах хөдөлгөөнд хяналт тавьж пост гаргах зэрэг ажил арга хэмжээний зардал болох 9 сая төгрөгийг шийдвэрлүүлж ажилласан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлэгт заасан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасан байгаль орчин, амьтан ургамлыг хамгаалах, журмын эсрэг зөрчлийн талаарх мэдээ мэдээлэл авах зорилгоор 98900016 дугаарын утсыг ашиглалтад оруулан олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.

Тус аймгийн Сэврэй сумын Засаг даргын тамгын газраас эрхлэн гаргадаг Хатан Сэврэй мэдээ мэдээлэл нэртэй өдрийн сонинд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл авах 98900016 дугаарын утас болон тухайн дугаараар өгсөн мэдээллийн урамшуулал, нууцлалын талаарх танилцуулгыг байршуулж олон нийтэл хүргэсэн. Мөн уг сонинд хууль бус хулгайн ангийн хор уршиг, ховор амьтдын экологи эдийн засгийн үнэлгээ агнасан тохиолдолд оногдуулах эрүүгийн хариуцлага зэргийг зурагт танилцуулгын хамтаар эх бэлтгэлийг хүргүүлж олон нийтэд танилцуулсан. Арга хэмжээний хүрээнд “Заг модоо хамгаалцгаая” постерыг тус цагдаагийн газрын фэйсбүүк цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэсэн. Мөн аймгийн хэмжээнд хамгийн их дагагчтай зарын групп, харъяа 14 сумдын цахим хуудсанд байрлуулж олон нийтэд хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг зөрчлийг таниулах ажлыг зохион байгуулсан. Арга хэмжээ эхэлсэнтэй холбоотойгоор цагдаагийн газраас Эко-2021 арга хэмжээний талаарх 1 минут 03 секундын видео шторкыг бэлтгэн “Өмнөговь цагдаагийн газар” фэйсбүүк хуудсанд байрлуулж олон нийтэд сурталчилсан. Мөн Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албанаас бэлтгэн гаргасан видео шторкыг “Өмнөговь цагдаагийн газар” фэйсбүүк хуудас болон сумдын хэлтэс, тасаг, хэсгийн фэйсбүүк хуудас, алба хаагчдын фэйсбүүк хуудас, олон дагагчтай фэйсбүүк группэд байршуулж олон нийтэд сурталчилж ажилласан. Арга хэмжээний хүрээнд тус цагдаагийн газраас Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлэгт заасан гэмт хэргийн шинжтэй 13 үйлдэл, Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасан зөрчлийн шинжтэй 16 үйлдлийг тус бүр илрүүлэн, шийдвэрлэх чиглэлээр энэ оны 03 дугаар сарын 10-ны өдөр тус цагдаагийн газрын эрүүгийн цагдаагийн тасаг, мөрдөн байцаах тасгийн алба хаагчид аймгийн прокурорын газрын хяналтын прокуроруудтай хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулсан. Мөн тус цагдаагийн газрын Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, Гэрээт цагдаагийн хэлтэс, Ханбогд сум дахь цагдаагийн тасаг, Баян-Овоо, Манлай сумдын хэсгийн алба хаагчид Ханбогд сум дахь сум дундын прокурорын газартай хамтарсан зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулж шийдвэрлэх хэргийн график төлөвлөгөөг гарган үр дүнг тооцож ажилласан.

Би... байна нэгдсэн арга хэмжээний хүрээнд: Цагдаагийн байгууллагад ирж буй Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, гомдол мэдээлэл бүрийг хүлээн авч шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тогтмол хяналт тавьж тухайн гэмт хэрэг зөрчлийн хохирогчид аюулын зэргийн үнэлгээг хийж шаардлагатай тохиолдолд хамтран ажиллагч байгууллагад холбон зуучилж, түр хамгаалах байранд байрлуулан ажиллаж байна. Би ... Байна урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний хугацаанд Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 3 дуудлага мэдээллийг хүлээн авч зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж зөрчлийн холбогдогчийг цагдаагийн байгууллагын нэгдсэн системийн “Судалгаа хяналтын бүртгэл, судалгаа” цэсийн субъектийн бүртгэлийн “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн бүртгэл”-д бүртгэн ажилласан. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг зөв зохистой тэмдэглэн өнгөрүүлэх, эмэгтэйчүүдийн эрхийг

хамгаалах талаар иргэдэд хандсан сурвалжилга мэдээлэл бэлдэн Өмнөговь нутгийнхаа манлайлагч эмэгтэйчүүдийн төлөөллөөр уриалга хэлүүлж олон нийтэд түгээсэн. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний хүрээнд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Архи ба амьдрал, өөрийгөө танихуй” зэрэг цахим сургалтын материал бэлдэж Даланзадгад сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус 30 байгууллагад DVD хэлбэрээр хүргүүлэн 854 ажилтан, алба хаагчдыг сургалтад хамруулсан бүртгэл болон сургалт хийгдэж буй нотломжийн хамт хүлээн аваад байна. Би... байна арга хэмжээний хүрээнд хийгдсэн фрэйм, ковероор цагдаагийн газрын нийт алба хаагчдын Facebook хуудасны нүүр зургийн хүрээ, коверыг солиулсан. Мөн Жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг бүгд нэгдэцгээе уриан дор “Би эмэгтэйчүүдийн нийгмийн амьдралд оруулж байгаа хувь нэмрийг үгүйсгэхийн эсрэг байна” challenge-ийг эхлүүлэн төрийн байгууллагын ажилтан алба хаагч нутгийн иргэдийг нэгтгэн уриалж арга хэмжээг сурталчлан ажилласан. Цагдаагийн Ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэн пеж хуудсандаа байршуулсан 2 төрлийн шторк, 10 постер, 9 бичлэг болон өөрийн цагдаагийн газраас бэлтгэн гаргасан 2 төрлийн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх шторкийг “Өмнөговь Цагдаагийн Газар” facebook хаяг болон пеж хуудсанд байрлуулж алба хаагчдаар Өмнөговь аймгийн олон хандагч бүхий группүүдэд түгээлгэн ажилласан.

“Мөрөөдлийн шүхэр” нэгдсэн арга хэмжээний хүрээнд:

Тус аймгийн хэмжээнд 46 караоке, баар, 18 халуун ус үүнээс саун 4, 63 буудал тус бүр үйл ажиллагаа явуулж байна. Ердийн жижиг буудал 60.000-80.000 мянган төгрөг, Хан уул, Говь сэндэс, Модерн номадс гэх буудлууд 120.000-750.000 төгрөгийн үнэтэй, караоке баар цаг нь 20.000-80.000 төгрөг, саун цаг нь 40.000-80.000 мянган төгрөгийн ханштай үйл ажиллагаа явуулж байна. Тус Цагдаагийн газраас зохион байгуулсан. “Шөнийн эргүүл”, “Хяналт шалгалт хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд дээрх аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийхэд энэ төрлийн гэмт хэрэгтэй холбоотой ямар нэг зөрчил дутагдал илрээгүй. Тус аймгийн Ханбогд сумын Цагаанхад, Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулж байгаа энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй 2 зочид буудлыг судалгаанд авч хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын “АСАП” санд эрэн сурвалжлагдаж байгаа өсвөр насны охид, эмэгтэйчүүдийг олж тогтоох чиглэлээр “АСАП” санд байгаа /90 эмэгтэй үүнээс 11 охид/ охид, эмэгтэйчүүдийн мэдээлэлтэй алба хаагч бүрийн танилцуулж, эргүүл хяналт, шалгалтаар явахдаа тухай орон нутагтаа эрэн сурвалжилж ажиллаж байна. Аймгийн хэмжээнд орон сураггүй алга болсон охид, эмэгтэйчүүд байхгүй болно.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аймгийн онцгой комиссын шийдвэрээр саун, буудлын үйл ажиллагааг хязгаарласантай холбоотойгоор тухай байгууллагуудын үйл ажиллагаанд Цагдаагийн байгууллагаас тогтмол хяналт шалгалтыг зохион байгуулж, гудамж, талбай, олон нийтийн газар байршуулсан зар тавигдаж байгаа эсэхэд баг хариуцсан хэсгийн байцаагч, олон нийтийн цагдаа нар тогтмол хяналт тавьж байна.

Энэ оны байдлаар Бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан, орон байр бусад эд зүйлсээр хангасан этгээдүүдийн талаарх мэдээ, мэдээллийн байхгүй байна. Цагдаагийн байгууллагаас энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол хяналт шалгалтыг эрчимжүүлэн ажиллалаа.

Гашуун сухайт хилийн боомт, Ханбогд сумын Хайрхан багийн нутаг Цагаан хад гэх иргэдийн суурьшил бөөгнөрөл үүссэн газарт 2500 гаруй иргэд суурьшин ажиллаж амьдарч байна. Мөн нүүрсний ачиж буулгах талбай болон тээврийн кампаниудын талбай нийт 40 орчим байх ба түүнд ажиллаж амьдарч байгаа иргэд одоогоор 6000 гаруй байна гэсэн албан бус тооцоо гардаг. Тус газар ажиллаж байгаа жолооч нарын дунд “Цагаан хад

жолооч нарын групп”, “Цагаан хад дахь жолооч нарын зарын групп” зэрэг facebook группүүд байдаг бөгөөд түүнд биеэ үнэлэх утга бүхий зарууд нэлээд олноор тавигдаж байна. Уг заруудыг шалгахад “Урьдчилгаа мөнгө авна” гэж залилах байдалтай зарууд байгаа нь тогтоогдсон.

Тус аяны хүрээнд Цагдаагийн газрын алба хаагчдын хаалттай “Бид нэг хамт олон” группэд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны код журмын 242-т заасан “Хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах”, 921-д “Албан үүрэг гүйцэтгэх үед алба хаагч иргэнтэй харилцах, биеэ авч явах байдал” зэргээр Цахим сургалтыг байршуулж алба хаагчдаар судлуулсан.

Цагдаагийн газрын нийт 89 алба хаагчаар аяны фрэймээр солиулж, Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 22 сургуулиудаас өрх толгойлсон, хараа хяналтгүй, хялбар аргаар мөнгө олох сонирхолтой /охид/, гэр бүл, бэлгийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдийн талаарх судалгааг авч, тус аянд нэгдэх чиглэлээр албан мэдэгдэл хүргүүлсэн. Цахим орчинд иргэдийг нэгтгэх чиглэлээр олон нийтийн группэд мэдээ, мэдээллийг байршуулж, Даланзадгад сумын ерөнхий боловсролын 4 дүгээр дунд сургуулийн “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн ахлагчтай хамтран хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Бид сэргийлж чадна” нэртэйгээр сэрэмжлүүлэг, посторыг хийлгэж тус сумын хүүхдүүдэд хүргэж ажилласан.

Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэн пейж хуудсандаа байршуулсан 8 төрлийн шторк, 11 постер болон өөрийн цагдаагийн газраас бэлтгэн гаргасан 5 төрлийн хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх посторыг “Өмнөговь Цагдаагийн Газар” facebook хаяг болон пейж хуудсанд байрлуулж алба хаагчдаар Өмнөговь аймгийн олон хандагч бүхий группүүдэд түгээлгэн ажилласан.

“Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд: Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албанаас зохион байгуулсан “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрийн хүрээнд энэ оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Арга хэмжээний ерөнхий удирдамжийн дагуу 10 заалт бүхий салбар төлөвлөгөө боловсруулж цагдаагийн газрын даргаар батлуулан аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Сум дундын ойн анги болон холбогдох төрийн бус байгууллага аж ахуй нэгжтэй хамтарч ажилласан. Цагдаагийн ерөнхий газрын экологийн цагдаагийн албанаас арга хэмжээний хүрээнд бэлтгэн гаргасан мэдээллүүдийг цагдаагийн газрын “ӨМНӨГОВЬ ЦАГДААГИЙН ГАЗАР” фейсбүүк хаягт байршуулж олон нийтэд хүргэсэн. Мөн цагдаагийн газрын дотоод фейсбүүк групп, хариуцсан сумдын фейсбүүк групп, олон хүний хандалттай зарын нэгдсэн группүүдэд байршуулж алба хаагчдыг олон нийтэд түгээх ажил арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд хийгдсэн “Ногоон дуу хоолой” преммыг цагдаагийн газрын дотоод фейсбүүк группэд байршуулж алба хаагчдын фейсбүүк хүрээг өөрчлөх ажил арга хэмжээг зохион байгуулсан. Үүний дагуу тус цагдаагийн газрын нийт бие бүрэлдэхүүн өөрсдийн фейсбүүк хаягны хүрээг “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний “Ногоон дуу хоолой” преммээр өөрчилж арга

хэмжээнд нэгдсэн. Мөн хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд уул уурхайн нүүрс олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа “Хүрэн толгой майнинг” ХХК “Мак” ХХК, “Өсөх зоос” ХХК зэрэг аж ахуй нэгжүүдэд арга хэмжээний хүрээнд уурхайн ажилчдыг нэгтгэж тодорхой төрлийн ажил арга хэмжээ зохион байгуулах албан мэдэгдэл хүргүүлж хариу авч ажилласан. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн хор уршгийг олон нийтэд таниулж, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор цуврал “PODCAST” нэвтрүүлэг бэлтгэсэн бөгөөд зочноор Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны хяналтын улсын байцаагч В.Өсөхбаяр оролцсон. “PODCAST” нэвтрүүлэгт Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа, хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг зөрчлийн тоон үзүүлэлт, цагдаагийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа ажил арга хэмжээний талаар дэлгэрэнгүй ярилцсан. Нийт 06 минут 03 секундын нэвтрүүлэг болсон бөгөөд тус “PODCAST” нэвтрүүлгийг Цагдаагийн газар, Говь гурвансайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа болон олон хүний хандалттай фейсбүүк хаягт байршуулж олон нийтэд хүргэж ажилласан. Цуврал “PODCAST” нэвтрүүлгийн дараагийн зочноор аймгийн Сум дундын ойн ангийн дарга Б.Бурмааг урьж оролцуулсан бөгөөд энэ удаагийн дугаарт Сум дундын ойн ангийн үйл ажиллагаа болон зохион байгуулж байгаа ажил арга хэмжээ, заг модны ач холбогдол хуулийн хариуцлага, цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулж байгаа нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний талаар мэдээлэл хүргэсэн. Нийт 06 минут 26 секундын нэвтрүүлэг болсон бөгөөд тус “PODCAST” нэвтрүүлгийг Цагдаагийн газар, Сум дундын ойн анги болон олон хүний хандалттай фейсбүүк хаягт байршуулж олон нийтэд хүргэж ажилласан. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Заг модоо хамгаалъя” “Дэлхий таны гарт багтдаг” зэрэг постер уриалгыг гаргасан. Мөн Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.6 дугаар зүйл, 24.5 дугаар зүйлд заасан гэмт хэргийн заалтыг олон нийтэд таниулах зорилгоор постер бэлтгэж цагдаагийн газрын “ӨМНӨГОВЬ ЦАГДААГИЙН ГАЗАР” фейсбүүк хуудсанд байршуулсан. Сумдын хэсгийн төлөөлөгч цагдаа нар дээрх постер мэдээллийг хариуцсан сумдын фейсбүүк рүүгдэд байршуулж олон нийтэд хүргэх ажил арга хэмжээг хариуцсан сумдын нутаг дэвсгэрт зохион байгуулж ажилласан. Цаашид хууль бус ашигт малтмал олборлох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр постер бэлтгэн олон нийтэд хүргэхээр төлөвлөж байна. “Байгалиа хамгаалъя нэгдсэн арга хэмжээ нь хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн ухуулга, нөлөөлөл, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулж, энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулахын төлөө улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаагаараа ихээхэн онцлогтой. Учир нь байгаль орчны эсрэг гэмт хэрэг сүүлийн 2 жилд өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд төрлийн энэ гэмт хэргийн тоон үзүүлэлтийг бууруулж, урьдчилан сэргийлэхийн төлөө дан ганц төрийн байгууллагын хийх ажил биш харин иргэн бүрийн үүрэг гэдгийг ухамсарлаж, иргэд маань хандлагаа өөрчилж, өөрчлөлтийг өөрсдөөсөө эхлүүлэхийг уриалж байна. “Байгалиа

хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний Ногоон дуу хоолойд Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар нэгдэж байна.” гэсэн уриалгыг гаргаж олон нийтийн цахим сүлжээнд байршуулсан. “Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Өмнөговь аймгийн 90 жилийн ой, орчин цагийн Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтан “90+10” мод тарих арга хэмжээг тус цагдаагийн газраас энэ оны 05 дугаар сарын 01 ны өдөр зохион байгуулсан. Уг арга хэмжээг Сум дундын ойн ангитай хамтран 100 ширхэг бүйлс, хайлаас зэрэг модны суулгацыг цагдаагийн газрын төв талбайд нийт бие бүрэлдэхүүн суулгаж идэвх санаачилгатай оролцсон. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд ӨМНӨГОВЬ ШУУРХАЙ ЗАР /15 СУМ/ фейсбүүк зарын нэгдсэн г рүптэй хамтарч ажилласан бөгөөд арга хэмжээний хүрээнд хийгдсэн мэдээллийг тухай бүр зарын нэгдсэн г рүппэд байршуулж олон нийтэд түгээж ажилласан. Мөн ногоон дуу хоолой постерыг тус г рүппийн үндсэн пропайлд байрлуулсан. Тус шуурхай зарын г рүпэд Өмнөговь аймгийн 15 сумдын иргэд зарлан мэдээлэл байршуулдаг ба аймгийн хэмжээнд хандалт ихтэй зарын г рүпп юм. Цаашид бусад зарын нэгдсэн г рүптэй хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөж байна. Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/110 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар тус аймгийн Сэврэй сумын Бүйлсэн багийн нутаг Зөөлөнгийн нуруу гэх алтны илэрцтэй газрыг энэ оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 90 хоногийн хугацаанд хамгаалалтад авах зорилгоор түр ажиллагаатай хяналтын цэг /пост/-ыг байгуулсан. Хяналтын цэг /пост/-д тус цагдаагийн газар, Говь гурван сайхан байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газрын алба хаагчид 15 хоногийн хугацаатай 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр үүрэг гүйцэтгэж байна. үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид Сэврэй сумын Хоолт багийн нутаг Нурууны ар, Эрээний нуруу, Бүйлсэн багийн нутаг Зөөлөнгийн нуруу Баяндалай сумын Дөхөм багийн нутаг Хувьын гол Баян цагааны нуруу зэрэг газруудад хөдөлгөөнт хяналт шалгалт хийн ажиллаж байна. Хамгаалалтад авсан алтны илэрцтэй газруудад иргэдийн бүлэг бөөгнөрөл үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Говь гурван сайханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны хуулийн хэрэгжилт хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн В.Өсөхбаяртай хамтран видео нэтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

“Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээний хүрээнд: Хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, гэр бүлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эрсдэлт нөхцөлд байгаа, хараа хяналтгүй, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн мэдээллийг судалгаа хяналтын санд бүртгэх, нэг бүрчилсэн хяналт тавих, хүүхдийн эсрэг аливаа хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж байгаатай холбоотойгоор аймгийн хэмжээнд “Бүхнийг хүүхдийн төлөө” аяны зохион байгуулахаар 6 бүлэг 19 заалт төлөвлөгөөг боловсруулж цагдаагийн газрын даргаар батлуулан, аймгийн ГХУСАЗСЗ болон Хууль эрх зүйн хэлтсээс 3.500.000 төгрөгийг шийдвэрлүүлэн ажиллаж байна. Үзлэг шалгалт арга хэмжээний хүрээнд аймгийн ГБХЗХГ-тай хамтран хараа хяналтгүй хүүхдүүдийг орогнуулдаг байж болзошгүй интернэт, цахим тоглоомын 3, дэн буудал 15, авто угаалгын

газар 7, хүүхэд орогнож болзошгүй дулааны шугам, нүх, траншейн 50 худгийн судалгааг холбогдох байгууллагуудаас авч үзлэг, хяналт шалгалтыг хийхэд Ковидтой холбоотойгоор цахим тоглоомын газар, буудал зэрэг газрууд ажиллахгүй, авто угаалга дээр насанд хүрээгүй хүүхэд ажиллуулсан зөрчил илрээгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг илрүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гэрийн хаягаар явж шалгах ажлыг хамтарсан багтай зохион байгуулж 4 хүүхдийг илрүүлэн судалгаа хяналтын санд бүртгэж, холбон зуучлах бусад үйлчилгээг үзүүлэх хариу арга хэмжээг авч ажилласан. Нийт арга хэмжээний хүрээнд 10 хүүхдийг бүртгэл судалгаанд хамруулсан. Хөлсөөр мал малладаг болон удаан хугацааны туршид айлд амьдарч байгаа хүүхдийг илрүүлж, шалтгаан нөхцөлийг тодруулах холбогдох байгууллагад холбон зуучлах сумдын засаг дарга, багийн дарга нарт албан тоот хүргүүлэн холбогдох судалгааг авч илрүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. ГБХЗХГ, ОБГ хамтран нийтийн эзэмшлийн талбайд сургууль, цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбай, орон сууц, гэр хорооллын газарт хүүхдэд учирч болзошгүй орчны эрсдэлийн үнэлгээг холбогдох байгууллагуудтай хамтран үзлэг хяналт шалгалтыг Даланзадгад сумын хүүхдийн тоглоомын талбайн орчны аюулгүй байдал, тоглоомын аюулгүй байдлыг MNS6751:2019 стандартын дагуу үнэлж зөрчлийг арилгуулах зорилгоор 2021 оны 04 дүгээр сарын 1-ний өдөр зохион байгуулан ажиллаж шаардлага хангаагүй хүүхдийн амь нас эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй эрсдэл бүхий тоглоомын талбай судалгааг гаргаж холбогдох зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажилласан. Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЕБС-ийн “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм” “School police” эргүүлийн үйл ажиллагаанд болон асрамж халамжийн төвүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, сургалт, соён гэгээрүүлэх ажлыг Ковид цар тахалтай холбоотойгоор цахимаар тогтмол зохион байгуулан ажилласан. Гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон, холбогдсон, хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй хүүхдийг хяналтад авч, цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангийн “Хүүхдийн нэгдсэн бүртгэл”-д эцэг эхийн хараа хяналт сул, хүүхдийг үл хайхарсан, гэр орондоо байнга архидан согтуурдаг зэрэг шалтгаанаар нийт 4 иргэнийг санд бүртгэлд оруулж, хяналт тавьж, тухай бүр баяжилт хийж ажиллаж байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн, үйлдэж болзошгүй этгээдэд нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг хүн нэг бүрийн онцлогт тохируулан хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Арга хэмжээний хугацаанд хүчирхийлэлд өртсөн, хараа хяналтгүй хүүхдийн талаарх 102, 107, 108 дугаарын утсанд ирсэн дуудлага, мэдээлэл 1 бүртгэгдэж гомдол мэдээллийг бүртгэн журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн. Өмнөговь аймгийн хэмжээнд шүүхийн шийдвэрээр эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан болон хасуулсан иргэдийн мэдээлэл байхгүй байгаа ба энэ талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Цагдаагийн газраас зохион байгуулсан хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд:

Аймгийн хэмжээнд нийт “Мэдэгдэл”, “Шаг”, “Хулгайн тээвэр”, “Судалгаа”, “Сар шинэ-2021”, “Гэрчилгээ”, “Тусгай гэрэл дохио”, “Би хариуцлагатай”, “Согтуу”, “Бүхнийг хүүхдийн төлөө”, “Зүрх зогсохгүй”, “Хүчирхийлэлгүй нийгмийг бүтээхэд иргэдийн оролцоо” “Нууц” зэрэг нийт **13 хэсэгчилсэн** арга хэмжээний төлөвлөгөө, удирдамжийг боловсруулан газар, хэлтсийн даргаар батлуулж, үр дүнг тооцон ажиллалаа.

Цагдаагийн газраас санаачлан зохион байгуулсан ажил, арга хэмжээ: “Архины эсрэг хамтдаа” аяныг архидан согтуурах, мансуурах бодистой тэмцэх, архинаас татгалзсан иргэдийг нийгэмшүүлэх ажлын байраар хангах бодлогыг

хэрэгжүүлэх, архидан согтуурснаас үүдэлтэй гэмт хэргийг бууруулах, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, согтууруулах ундааны уршиг, мөн чанарыг олон нийтэд таниулж, албан байгууллага хамт олноороо архидан согтуурдаг байдлыг таслан зогсоох, хойч үе, үр хүүхдэдээ үлгэрлэн дуурайх замаар архидан согтуурах явдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргаар удирдамж боловсруулж 8.900.000 төгрөг, аймгийн Засаг даргаар “Архидан согтуурах, мансуурах бодистой тэмцэх, архинаас татгалзсан иргэдийг нийгэмшүүлэх ажлын байраар хангах бодлого”-ын хүрээнд 20.000.000 төгрөгийн төсвийг тус тус шийдвэрлүүлж, “Архины эсрэг хамтдаа” аяны удирдамжийг батлуулж, төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, сумдад аяныг дэмжиж идэвхтэй оролцох талаар Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг даргын нэр дээр үүрэг ажлын чиглэл хүргүүлж ажилласан.

2. Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газруудтай хамтран ар гэртээ архидан согтуурдаг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч иргэдийг 1.980.000 төгрөгийн “Сайн дур”-ын эмчилгээнд эрэгтэй 8, эмэгтэй 3 нийт 13 иргэнд архины хордлого тайлах, архины дур буулгах, өвөрмөц эмчилгээ болох архины харшил урвал үүсгэх тосон тараа хийж, сэтгэл заслын эмчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө ганцаарчилсан зөвлөгөөг тус тус өгч ажилласан. Мөн хамтран оролцож буй байгууллагуудыг оролцуулж эмчилгээнд хамрагдсан нийт 13 иргэдтэй чөлөөт ярилцлага зохион байгуулж, батламж, итгэлцлийн гэрээ байгуулахаар төлөвлөж байна.

3. Аяны хүрээнд “Говийн наран” АА бүлгэмийг үүсгэн байгуулагч Т.Дашцэрэнг оролцуулан архинаас болж алдаж яваа олон залуучуудад сургамж, зөвлөмж, бүлгэмийг орон нутагтаа сурталчилж “Мэлмий” сайтаар “Лонхонд гээгдсэн амьдрал” нэртэй нэвтрүүлгийг хийлгэж олон нийтэд сурталчилж ажилласан. Мөн “Сайн дур”-ын эмчилгээнд хамруулсан 11 иргэнийг тус бүлгэмийн сэтгэл заслын үйлчилгээнд хамруулж байна. Архинаас татгалзаж дээрх эмчилгээнд хамрагдсан ажилгүй 4 иргэнийг Оюу толгойн гэрээт Саппорт сервисес монголиа ХХК-нд ажилд жуулчилж ажилласан.

4. Хэсгийн байцаагч нараас хариуцсан багт амьдардаг, архидан согтуурч гэр бүлдээ айдас түгшүүр төрүүлдэг, хүчирхийлэл үйлддэг иргэдийн судалгааг гаргуулж, судалгаанд үндэслэн тухай багт байрлах архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг аж ахуй нэгжүүд архидан согтуурдаг иргэдийг хариуцуулж архинаас татгалзах ажлыг даалгаж, Даланзадгад сумын 8 багийн дунд “Архины эсрэг хамтдаа” чөлленжийг зарлан тухай багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийг нийгмийн хариуцлагын хүрээнд татан оролцуулж байна.

5. Өмнөговь аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд “Архигүй хамт олон” чөлленж зарлаж, дарцаг, тайлангийн дэвтэр аялуулж “Архи ба амьдрал”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Архинд донтох өвчний үе шатууд” зэрэг цахим сургалтын материал бэлдэж Даланзадгад сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус 30 байгууллагад DVD хэлбэрээр хүргүүлэн өнөөдрийн байдлаар 26 байгууллагын 854 ажилтан, алба хаагчдыг сургалтад хамруулсан бүртгэл болон сургалт хийгдэж буй нотломжийн хамт хүлээн аваад байна. Мөн баривчлах байранд шүүгчийн шийтгэврээр баривчлагдсан нийт 71 иргэн түүнээс согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 56, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 13, өмчлөх эрхийн эсрэг зөрчил үйлдсэн 2 иргэн тус бүрт зан үйлд нөлөөлөх бүлгийн ярилцлага болон баривчлагдсан этгээдийн өөрсдийн оролцоотойгоор багт хувааж сонирхолтой хэлбэрээр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Зам тээврийн ослын шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх нь” “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт” сэдвээр сургалтуудыг орж ажилласан.

6. Сogтyуpyулax yндaа yйлдвэрлэх, худалдаалах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, аймгийн засаг даргын захирамжтай холбоотойгоор албан мэдэгдэл хүргүүлж ажилласан.

7. “Түмэн итгэлт”, “Ти Жи Эм Си” ХХК-уудтай гэрээ байгуулан, 4 видео шторк, 2 уриалга, 10 ширхэг зурагт постор, фрэйм, ковор, логоны санааг гаргаж тухай компаниудаар хийлгэж, 10 төрлийн 10.000 ширхэг санамж, сэрэмжлүүлгийг хэвлүүлж, тараасан, уриалгыг 984 группэд, шторкуудыг 1157 группэд шэйрлэн түгээгдсэн байх бөгөөд 945.892 хүний хандалт авсан байна.

“Би хариуцлагатай” аяны хүрээнд: “Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих нэгдсэн хөтөлбөр 2018-2021”-ийн хүрээнд зам тээврийн аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “#Би хариуцлагатай жолооч” нөлөөллийн аяныг тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, журмын хэрэгжилтийг хангах, зам тээврийн осол, гэмтлийг бууруулах зорилгоор 2020 оны 11 дүгээр сараас 01 дүгээр сарын 25-ны 02 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл зохион байгуулсан. Тухай хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Аймгийн “Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд, залуучуудын эрүүл мэндийг дэмжих нэгдсэн хөтөлбөр”-ийн хүрээнд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр удирдамж, 8.365.000 төгрөгийн төсөв боловсруулж аймгийн Засаг даргаар шийдвэрлүүлсэн.

2. Зам тээврийн осол хэргээс иргэд жолооч нарыг урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох гарын авлага 3000, санамж сэрэмжлүүлэг 10000 ширхэг тус тус хэвлүүлж тарааж олон нийтэд хүргэсэн.

3. Зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх 10 төрлийн видео шторк хийж цахим орчинд олон нийтэд хүргэх зорилгоор Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газрын facebook, page-д байршуулж олон дагагчтай зарын группүүдэд байршуулсан.

4. Түр пост байгуулах, хөдөлгөөнт эргүүл ажиллуулан давхардсан тоогоор 30 алба хаагчид ажиллаж 3960 тээврийн хэрэгсэл шалган нэвтрүүлж, эдгээр иргэдэд санамж сэрэмжлүүлэг, тарааж, 37 зөрчлийг илүүлж ажилласан байна.

5. Жолооч нарт зориулж Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм болон зурган хөзрийн эх бэлтгэл зохион, Улаанбаатар хотын “Интерперсс” ХХК-аар 3000 ширхгийг хэвлүүлэн ирүүлж, Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Цагаанхад чиглэлийн нүүрс тээврийн жолооч нарт тарааж ажилласан. Мөн Улаанбаатар хотын олон нийтийн сайтууд болох Цахиур.mn, UBN.mn, Монцамэ мэдээллийг өгч ажилласан.

6. Тухайн аяныг орон нутгийн Алтанговь, Говь HD, Говийн наран телевизүүдээр сурталчилж 3 удаа яриа таниулга хийж, иргэд жолооч нарт зөвлөмж, зөвлөгөө өгсөн.

Хяналт шалгалтын чиглэлээр: Өмнөговь аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 1-138 дугаартай албан бичгийн дагуу Мандалговь-Даланзадгад чиглэлийн улсын чанартай хатуу хучилттай автозамын Шартээгийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км автозамаар зорчих тээврийн хэрэгслийн нэг тэнхлэг дээрх болон бүх жингийн стандартаар тогтоосон зөвшөөрөгдөх дээд хэмжээг мөрдүүлж хяналт тавьж хамтран ажиллах тухай албан бичгийн дагуу Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн алба хаагчид Орон нутгийн таван толгой ХХК-ийн ажилчидтай хамтран хөдөлгөөнт хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж байна.

Коронавирусын халдварт өвчинтэй холбогдуулан нийслэлээс орон нутаг, аймгаас аймгийн хооронд маршрутын бус замаар хүн тээвэрлэн хөдөлгөөнд оролцож байгаа зөрчлийг илрүүлэх таслан зогсоох зорилгоор Цогтцэций сум дахь сум дундын цагдаагийн хэлтэс, Ханбогд, Гурвантэс сум дахь цагдаагийн тасгууд болон Эрүүгийн цагдаагийн

тасаг, Нийтийн хэв журам хамгаалах тасаг, Дундговь, Дорноговь, Өвөрхангай аймаг дахь замын цагдаагийн тасагтай хамтран “Хулгайн тээвэр-2” хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, маршрутын бус замаар зөвшөөрөлгүй зорчигч тээвэрлэсэн 4 зөрчил илрүүлэн шалгалтын ажиллагааг хийж байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр Замын цагдаагийн тасгаас 13, Гэрээт цагдаагийн тасаг /Гашуун сухайт/-аас 27 алба хаагч, хот хоорондын хяналтын 2 цэгт болон нүүрс тээвэрлэлтийн автозамуудад 7 автомашин, 16 шалгах багаж, 6 согтуурал шалгах багаж, 4 согтуурал тандагч, 3 хурд хэмжигчтэйгээр үүрэг гүйцэтгэж, тасгийн дарга, ахлах зохицуулагчаас алба хаагчдын ажлын цаг ашиглалт, эргүүл хяналтын цэгийн хуваарьт тогтмол хяналт тавин ажилласан.

Хариуцсан нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Авто тээврийн төвтэй хамтран зохион явуулж Даланзадгад сумын төвд 4 алба хаагч аймгийн төвөөс Улаанбаатар хот руу чиглэсэн улсын чанартай автозамын 2.5 дахь км-т, Цогтцэций сумын цагдаагийн хэлтсээс 5 алба хаагч сумын төв рүү орох, гарах автозамд болон уурхай орчимд, Ханбогд сумын цагдаагийн тасагт 2 алба хаагч сумын төвөөс орох, гарах автозамд, нүүрс тээвэрлэлтийн автозам болон хил орчимд, Гэрээт цагдаагийн тасгаас 20 алба хаагч нүүрс тээвэрлэлтийн 239 км автозамыг хариуцан шалган нэвтрүүлэх цэг 1, 2, 4 дүгээр пост, Ухаа худаг уурхайгаас Гашуун Сухайт хилийн боомт хүртэлх автозамын 133 дахь км-т /Сүлжээ гэх газар/, Оюутолгой ХХК-ий автозамын уулзвар, цэгүүдэд замын хяналт, шалгалтыг тогтмол зохион явуулж хоногт илрүүлсэн зөрчил, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээг өдөр бүр өгч ажилладаг.

Тэсэрч дэлбэрэх бодисын агуулах үйлдвэр, арилжааны банкны салбарууд, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний цэг салбар, ШТС-ын гэрээт харуул хамгаалалт, онц чухал объектуудын аюулгүй байдлыг хангах, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр тухай байгууллагын удирдлага, ажилтнуудад зөвлөмж өгч, хэрэгжилтэд нь хяналт тавин хамтран ажиллалаа. Тус суманд үйл ажиллагаа явуулж буй “Мера”, “Эрхэт түнш”, “Талст Бласт Консалтинг”, “СМС”, “Бласт” ХХК-ийн “Таван толгой салбар”-ын тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэр, агуулахын удирдлага, тухай компаниудын гэрээт харуул хамгаалалтын байгууллагын удирдлага ажилтнуудтай уулзалт хийж, харилцан санал бодлоо солилцон, болзошгүй халдлагаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ мэдээлэл солилцон хамтран ажиллалаа. Шинэ жил, сар шинийн баяр амралтын өдрүүдэд Цогтцэций сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “МИРА”, “Эрхэт түнш”, “Талст бластинг”, “Спейшл майнинг сервис”, “Бласт” ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэр, агуулахын үйл ажиллагаа, гэрээт харуул хамгаалалтын албаны үүрэг гүйцэтгэж байгаа байдалд Онцгой байдлын гал түймэр унтраах, аврах 44 дүгээр ангийн чиглэл хариуцсан байцаагч нартай хамтарсан хяналт шалгалт хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж өгч, аюулгүй байдалд нь хяналт тавин ажилласан.

“Бүхнийг хүүхдийн төлөө” аяны хүрээнд: Арга хэмжээний хүрээнд хүүхдийн эрхийг зөрчсөн, хүүхэдтэй харгис хэрцгий хандсан, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлсэн, хүүхдийг асрах хамгаалах үүргээ үл биелүүлсэн зэрэг Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг бүртгэгдээгүй ба Зөрчлийн тухай хуулиар 6 гомдол мэдээлэл хүлээн авч 2 материалд Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугар зүйлийн 7 дахь заалтаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, хялбаршуулсан журмаар 4 зөрчилд 6 иргэнийг 1.800.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Арга хэмжээний хүрээнд аймаг болон 14 сумын хэмжээнд аймаг, сумын засаг дарга, багийн нийгмийн ажилтан, Хөдөлмөр

халамжийн газартай хамтран хамгаалах шаардлагатай хагас өнчин 408, бүтэн өнчин 19, хөгжлийн бэрхшээлтэй 6 хүүхэд, хүнс тэжээлийн дэмжлэг үйлчилгээнд хамрагддаг хагас өнчин 15, хурдан морь унаач хүүхэд 63 хүүхдүүдийн дэлгэрэнгүй судалгаатай болж хөдөлмөр эрхэлдэг хүүхэд бүртгэгдээгүй байна. Газ, цавуу, будаг шингэлэгч, бензин, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис зэргийг хэрэглэдэг хүүхдийг илрүүлэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагатай хамтран холбогдох албан бичгийг хүргүүлэн судалгааг авч ажиллаж байгаа бөгөөд 2021 оны байдлаар дээрх судалгаатай холбоотой хүүхэд бүртгэгдэж эмчлэгдээгүй байна. “Хүүхэд хамгаалал” арга хэмжээний хүрээнд хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хохирч өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр постер, зурагт хуудас хэвлэж 5000 ширхгийг тараах ажилласан. Хүүхэд гэмт хэрэг, зөрчилд хохирч, өртсөн болон хүчирхийллийн хохирогч болох хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр 100 ширхэг албан мэдэгдлийг аж ахуйн нэгжээр тарааж ажилласан. Хэрсүү гурвалжин буюу хүүхдийн хохирсон талаарх мэдээллийг “Ус түгээгч”, “Хариуцлагатай худалдагч”, “Соргог хөрш” нэртэй зурагт хуудсыг гэр хорооллын худаг, дэлгүүрүүдийн худалдагч, нарт тарааж орцны хаалга зэрэг иргэдэд харагдахуйц газар байршуулан нийт 500 ширхэг хэвлэж тарааж ажилласан. Хүүхдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 төрлийн тараах материал хэвлэн замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарт тарааж ажиллав. **“Нууц” тусгай арга хэмжээний хүрээнд:** Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны 04 сарын 09-ний өдрийн А/396 дугаар захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавих, шагийн архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг зөрчлийг илрүүлж, таслан зогсоож, хуулийн дагуу арга хэмжээ тооцох, архидалттай тэмцэх зорилгоор Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгаас 2021 оны 04 сарын 15-ны өдрөөс 2021 оны 04 сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд “Нууц” тусгай арга хэмжээг тус тасгийн хэсгийн байцаагч нар, эргүүлийн томилгоот алба хаагчдын хамтаар зохион байгуулсан. Дээрх хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: “Нууц” тусгай арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан НХЖХТ-ийн даргаар хянуулж, Цагдаагийн газрын даргаар батлуулж, дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн даргад мэдэгдэн Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний санд бүртгүүлсэн. Тус арга хэмжээний төлөвлөгөөг эргүүлийн томилгоот алба хаагчдад танилцуулж, үүрэг чиглэл өгч гаргасан. Даланзадгад сумын төвд архи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй 120 аж ахуйн нэгж, согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөлтэй 49 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгаж ажиллахад зөрчил илрээгүй.

Өмнөговь аймгийн хэмжээнд хорио цээрийн дэглэм зөрчиж, зохих зөвшөөрөлгүйгээр гар дээрээс архи согтууруулах ундааны зүйл худалдан борлуулсан нийт 10 зөрчлийг илрүүлэн, нийт 0,75 литрийн 576 шил архи, 2,5 литрийн 9 пивыг хураан авч, зөрчлийн хэрэг нээж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна. Тус арга хэмжээний хүрээнд зөрчил үйлдэхдээ ашигласан 3 тээврийн хэрэгслийг журамлаж ажилласан. Аяны хүрээнд хэсгийн байцаагчаар “Police podcast” бэлтгэн олон нийтийн цахим сүлжээнд байршуулж, түгээж ажилласан.

“Зүрх зогсохгүй” аяны хүрээнд: “Ээлтэй Өмнөговь” хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах, тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль, журмын

хэрэгжилтийг хангах, зам тээврийн осол, гэмтлийг бууруулах зорилгоор Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт хэмжээнд 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 2021 оны 07 дугаар сарны 10-ны хооронд зохион байгуулж байна. Үүнд:

1. Аяны удирдамжийг боловсруулж, цагдаагийн газрын даргаар хянуулж, тус аянд зарцуулагдах 14.650.000 төгрөгийг аймгийн ГХУСАЗСЗ, Хууль эрх зүйн хэлтсээс төсвийг батлуулсан.

2. Тус аяны хүрээнд Ти Жи Эм Си ХХК, GOVI EVENT компаниудтай хамтран тухайн аяны нэр, фрэйм, ковер, логоны санааг гаргуулж, 10 постор, 10.000 тараах материал, 5 ширхэг уриалга, 5 ширхэг шторк хийлгэхээр гэрээлж ажиллалаа.

3. “Зүрх зогсохгүй” аяны хүрээнд 2015-2020 оны зам тээврийн ослын талаарх статистик мэдээг гаргаж, 2 ширхэг хулдаасан хэвлэл хэвлүүлж Даланзадгад сумын төв сааданд байршуулсан.

4. Аяны удирдамжийг ГХУСАЗСЗ, Хууль эрх зүйн хэлтсийн дарга нараар хамтран батлуулж, төсөв мөнгийг шийдвэрлүүлж, ГХУСАЗСЗ-ийн даргын нэр дээр 15 сумын ГХУСАЗСЗ-ийн дарга нарт аяныг дэмжиж ажиллах талаар үүрэг ажлын чиглэл хүргүүлсэн. Мөн Цагдаагийн газрын даргаас харьяа сум хариуцсан Цагдаагийн хэлтэс, тасаг, хэсэгт үүрэг, ажлын чиглэл хүргүүлсэн байна.

5. 2021 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр тус аяны нээлтийг замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа О.Чинзориг орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудад аяныг зохион байгуулж байгаа зорилго болон иргэдэд анхааруулга, сэрэмжлүүлгийг өгч, цагдаагийн газрын албаны тээврийн хэрэгслүүд болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас онхолдож эвдэрсэн тээврийн хэрэгслийг чирэгч машинаас чирэн чанга яригчаар 2015-2020-оны статистик мэдээ, мэдээлэл, анхааруулга сэрэмжлүүлгийг хүргэж Даланзадгад сумын төв саадыг тойрч нээлтийг үйл ажиллагааг зохион байгуулсан.

6. Замын тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын чанартай авто зам дагуу суурьшдаг малчдын бод малд зориулж гэрэл ойлгогч, цацруулагч бүхий 1000 ширхэг хүзүүвч хийлгэж Ханхонгор, Цогт-Овоо, Цогтцэций, Ханбогд сумын тарааж ажиллалаа.

7. Тус аяны хүрээнд Ти Жи Эм Си ХХК-аар тухайн аяны нэр, фрэйм, ковер, логоны санааг гаргуулж, 10 посторын хийлгэж Өмнөговь Цагдаагийн газрын Facebook, page болох цахим хаягт байршуулж, олон дагагчтай зарын группүүдэд алба хаагчдаар шэйрлүүлж олон нийтэд хүргэж ажилласан. Мөн 10.000 ширхэг тараах материалыг Улаанбаатар хотод хэвлүүлэхээр захиалсан байна.

8. Govi Event ХХК-аар аймгийн нөлөө бүхий иргэдээр 5 төрлийн уриалга хэлүүлж, иргэдийн гаргаж буй зам тээврийн осол, зөрчлийг харуулсан 5 төрлийн анхааруулга, сэрэмжлүүлэг шторк хийлгэж олон нийтэд хүргэж ажиллалаа.

9. Мөн орон нутгийн Алтанговь, Говь HD телевизүүдэд аяныг сурталчилж 2 удаа яриа өгсөн.

10. Даланзадгад сумын нутгийн удирдлагын ордны өмнөх ЛЕД дэлгэцээр 5 төрлийн шторк, 5 төрлийн уриалга, засмал зам дагуух лед самбарт 10 төрлийн посторыг байршуулсан.

11. Даланзадгад сумын төв уйзелиэр зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх анхууралга, сэрэмжлүүлгийг аяны хугацаанд иргэдэд хүргүүлж байна.

“Хүчирхийлэлгүй нийгмийг бүтээхэд иргэдийн оролцоо” аян хүрээнд: “Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Ээлтэй Өмнөговь” төслийн зардлаас 9.890.000, аймгийн Засаг даргын тамгын газраас 3.000.000 нийт 12.890.000 төгрөгийн төсөв боловсруулан шийдвэрлүүлж Гэр бүлийн

хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр иргэд, эцэг эхчүүд, аж ахуйн нэгж байгууллагууд болон хүүхдийн өмнө үүрэг хүлээх байгууллагуудыг урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах, гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийг таниулах, урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хүчирхийлэл үйлдэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлөвийг өөрчлөх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийн гаралтыг бууруулах чиглэлээр аймгийн хэмжээнд “Хүчирхийлэлгүй нийгмийг бүтээхэд иргэдийн оролцоо” 1 сарын аяныг өрнүүлэн аймгийн Хууль эрх зүйн хэлтэс, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран нээлтийн үйл ажиллагааг дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан хийж орон нутгийн Говь НД, Алтан говь, Говийн наран телевизүүд, мэдээ мэдээллийн мэлмий сайтаар нэвтрүүлэн олон нийтэд хүргэн уриалж хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар шторк, постер, подкаст бэлдэн иргэд, олон нийтэд орон нутгийн Телевизүүд болон цахим орчноор дамжуулан хүргэх нөлөөллийн ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

Ухуулга, яриа сургалт сурталчилгааны чиглэлээр: Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 95 удаа сургалт, мэдээлэл сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллагад, уулзалт, ярилцлагыг сургуулийн багш, ажилтан нарт 8 удаа хийж, нийт 1989 иргэнд төрийн болон Төрийн бус байгууллагын алба хаагчид давхардсан тоогоор 1883, хувиараа хөдөлмөр эрхэлдэг 2, малчин 6, оюутан 1, ажилгүй 46 иргэнд 163 цагийн сургалтыг сургалтыг тус тус орсон байна. “Архи ба амьдрал”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Архинд донтох өвчний үе шатууд” зэрэг 45 минутын видео хичээлийг Насан туршийн болосролын төвтэй хамтран DVD буулгаж Даланзадгад сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус 30 байгууллагын 854 ажилтанд судлуулсан байна. Мөн баривчлах байранд шүүгчийн шийтгэврээр баривчлагдсан нийт 71 иргэн түүнээс согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 56, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 13, өмчлөх эрхийн эсрэг зөрчил үйлдсэн 2 иргэн тус бүрт зан үйлд нөлөөлөх бүлгийн ярилцлага болон баривчлагдсан этгээдийн өөрсдийн оролцоотойгоор багт хувааж сонирхолтой хэлбэрээр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Зам тээврийн ослын шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх нь”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт” сэдвээр 1 цаг 30 минутын сургалтуудыг орж ажилласан.

Захиргааны хяналтаар: Хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан хорих ялыг тэнсэж хянан харгалзсан ялтанд чиглэсэн ажил арга хэмжээг тус аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Прокурорын газартай хамтран дараах ажил арга хэмжээг зохион байгуулав. Үүнд: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 42.7 дахь хэсэгт заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталсан “Загвар, хугацааны жишиг тогтоох тухай” журмыг алба хаагч нарт танилцуулж, захиргааны хяналтын материал нээх эрх бүхий алба хаагч нар өдөр тутам үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байна. 2021 оны 2 дугаар улиралд Өмнөговь аймгийн хэмжээнд захиргааны хяналтад байгаа этгээдүүдийг аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын холбогдох албан тушаалтантай хамтран 3 удаа тулгалт хийж ажилласан бөгөөд мөн хэсгийн төлөөлөгч нарын гар дээр байгаа захиргааны хяналттай этгээдүүдийн хувийн хэрэгт хэрхэн баяжилт хийж байгаа байдалд аймгийн Прокурорын

газраас 3 удаа хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан болон хорих ялыг тэнсэж хянан харгалзсан ялтан 31 хүний материалыг хэсгийн төлөөлөгч нарын гар дээрээс татаж аван хувийн хэргийн баяжилт хийж байгаа байдал, сард хэдэн удаа уулзаж хувийн хэрэгт тэмдэглэл хөтөлсөн байдалтай танилцаж, хяналт тавьж буй алба хаагчдад зөвлөмж хүргүүлэв. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын хэмжээнд захиргааны хяналтад байгаа этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр сум, баг, хороо хариуцсан хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч нарт Цагдаагийн газрын даргаас 6 заалт бүхий үүрэг, ажлын чиглэлийг хүргүүлж үр дүнг тооцов. Сумдын хэсгийн төлөөлөгч нар хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан болон хорих ялыг тэнсэж хянан харгалзсан ялтан 55 иргэдтэй ганцаарчилсан болон биечилсэн уулзалтыг хийж, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх чиглэлээр баталгаа авч багийн засаг дарга нартай хамтран ажиллав. Тайлант хугацаанд баяр амралтын өдрүүдэд захиргааны хяналтад байгаа этгээдүүдэд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр Цагдаагийн газрын даргаас тухайн бүр үүрэг, ажлын чиглэлийг хэлтэс, тасаг, сумдын хэсгийн төлөөлөгч нарт хүргүүлж байсан бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасагтай хамтран хяналт тавьж тэмдэглэлд тусган ажиллав.

Өмнөговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын захиргааны хяналт хяналт тавих эрх бүхий ажилтнаас тус цагдаагийн газрын эрх бүхий 18 алба хаагч нарт захиргааны хяналтад байгаа этгээдүүдэд чиглэсэн зарим арга хэмжээний талаар сургалтыг 3 удаа орж заавар зөвлөмж өгөв. Монгол улсын Засгийн газрын 102 дугаар тогтоолоор баталсан шинэ төрлийн коронавирус /COVID-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх халдварын эрсдэлийг бууруулах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын 2 дугаар зэрэглэлд шилжсэнтэй холбогдуулан, захиргааны хяналтад байгаа этгээдүүдийг гар утсаар холбогдон аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран хяналт тавин ажиллаж байна. Тус аймгийн нутагт захиргааны хяналтад энэ оны 03 дугаар сарын 17-ны байдлаар 68 хүн байгаа ба уг хүмүүст чиглэсэн арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж ажиллаж байгаа бөгөөд аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран хувийн хэргийн баяжилтыг тухай бүр хийж, биечлэн уулзаж зөвлөгөө өгсөн 14, ганцаарчлан уулзалт хийж зөвлөгөө өгсөн 47 хүний хувийн хэрэгт тэмдэглэл хийж ажилласан байна. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд тухайн сард хорихоос суллагдсан 2, шүүхээс тэнсэн суллагдсан 7, Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн 4, хорих ялаас тэнсэн суллагдсан 8 байгаа бөгөөд уг хүмүүсээс баталгаа авч, материалыг бүрдүүлж, холбогдох алба хаагчдад хяналт тавьж ажиллаж байна.

Хүүхдийн чиглэлээр: Өмнөговь аймгийн хэмжээнд гэмт хэрэг үйлдэж болзошгүй судалгаа хяналтын санд бүртгэлтэй нийт 9 хүүхэд, насанд хүрээгүй 4 буюу хүмүүжлийн чанартай арга хэмжээн авч ГБХЗХГ-т бүртгэлтэй байгаа, ганцаарчлан уулзаж зөвлөгөө өгсөн 4, гэмт хэрэг үйлдэж болзошгүй буюу гарын хээний бүртгэлийн санд бүртгэлтэй 1 хүүхэд байна.

Цагдаагийн байгууллагад ирж буй Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг болон хүүхдийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, гомдол мэдээлэл бүрийг хүлээн авч шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тогтмол хяналт тавьж тухайн гэмт хэрэг зөрчлийн хохирогчид аюулын зэргийн үнэлгээг хийж шаардлагатай тохиолдолд хамтран ажиллагч байгууллагад холбон зуучилж, түр хамгаалах байранд байрлуулан ажиллаж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан үхүүлга, сурталчилгаа

Телевизээр: Цагдаагийн газраас 2021 оны 2 дугаар улирлын байдлаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 22 удаа яриа таниулга өгсөн. Үүнээс орон нутгийн Мэлмий сайтад захилга өгч Хууль, эрх зүйн хэлтэс, Говийн наран АА бүлгэмтэй хамтран “Лонхонд гээгдсэн амьдрал” сэдэвт 46 минутны нэвтрүүлэгийг бэлтгэж олон нийтэд хүргэсэн. “Архины эсрэг хамтдаа”, “Би хариуцлагатай”, “Зүрх зогсохгүй” аянуудын талаар 10 удаа, МонЦамэ агентлагт 2 мэдээлэл хүргүүлсэн. “Би хариуцлагатай аяны хүрээнд “Цахим.mn, UBN.mn facebook сайтад тус бүр 1 удаа, Орон нутгийн Алтанговь, Говь HD телевизүүдэд гэмт хэрэг, зөрчлийн талаарх тоо мэдээг 5, Эко-2021 арга хэмжээг сурталчилж 1, гэр бүлийн хүчирхийлэл, бага насны хүүхдийн бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1, хүүхдийг ахуйн хүрээний осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3, Залилан 1, Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаа тус тус өгсөн байна.

Цахим хуудсаар: Цагдаагийн газрын /facebook, page/ олон нийтийн сүлжээнд 2021 оны хоёрдугаар улиралд Өмнөговь Цагдаагийн газар веб хуудсанд 56 мэдээ мэдээлэл, 16 шторк, сэрэмжлүүлэг мэдээ, уриалгыг байрлуулсан. Мөн цагдаагийн газрын фейсбүүк хуудсанд үйл ажиллагаатай холбоотой, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шторк, видео, сэрэмжлүүлэг, постор зэрэг нийт 207 мэдээ мэдээлэл байршуулж, давхардсан тоогоор 136 төрлийн мэдээллийг иргэд олон нийтэд сурталчилж ажилласан.

Үүнээс: Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээ, мэдээлэл тавигдаж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан 19 мэдээ мэдээлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн мэдээ, мэдээлэл 56, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр буюу аймгийн хэмжээнд зохион байгуулсан “Архины эсрэг хамтдаа”, “#Би хариуцлагатай”, “Зүрх зогсохгүй”, “Бүхнийг хүүхдийн төлөө”, “Байгалиа хамгаалъя”, “Хүчирхийлэлгүй нийгмийг бүтээхэд иргэн бүлийн оролцоо” аяны хүрээнд “Түмэн итгэлт”, “Ти Жи Эм Си” ХХК-тай гэрээ байгуулан 10 уриалга, 8 шторк, 25 постор, лого 2, Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн шторк, уриалга, постор, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн заалт ангиллын талаар мэдээлэл 99 удаа мэдээлэл, хүрээнд зурагт хуудас зэргийг нийтэлж иргэд олон нийтэд мэдээлэл хүргэсэн ба орон нутгийн иргэдийн хандалт ихтэй цахим хуудас Өмнөговь аймгийн автомашины зарын нэгдсэн групп /91495 гишүүнтэй/, Өмнөговь шуурхай зар /79931 гишүүнтэй/, Цагаан хад жолооч нарын групп /88201 гишүүнтэй/, Таван толгой цагаан хад ганц мод хоорондох нүүрсний тээврийн жолооч нар /98872 гишүүнтэй/, Цагаан хад жолооч нарын групп /68200 гишүүнтэй/ зэрэг орон нутгийн иргэдийн хамгийн их бүртгэлтэй нийгмийн сүлжээнд давхардсан тоогоор 19.648.606 гишүүдтэй хуудсанд нийтэлж, түгээж ажилласан.

Хүүхдийн чиглэлээр: Хүүхдийг гэмт хэрэг зөрчилд холбогдох, өртөж хохирхоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 12 төрлийн сэрэмжлүүлгийг цахим орчинд байршуулсан ба 194700 иргэн хандалт хийсэн байна.

Тараасан сурталчилгааны материал

2021 оны хагас жилийн байдлаар нийт 36020 ширхэг гарын авлага, зурган постор, санамж, сэрэмжлүүлэг тарааж ажилласан байна. Үүнээс хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 750 ширхэг гарын авлага, зурагт хуудас 5000 ширхэг, санамж сэрэмжлүүлэг 5000 ширхэг, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудас 230 ширхэг, санамж сэрэмжлүүлэг

540 ширхэг, Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 10.000 ширхэг, хулгай 500, бусдын биед гэмтэл учруулах чиглэлээр 500, бусад тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 3500 ширхэг тус тус хэвлүүлэн олон нийтэд хүргэж ажилласан байна.

Жолооч нарт зориулж Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм болон зурган хөзрийн эх бэлтгэл зохион, Улаанбаатар хотын “Интерперсс” ХХК-аар 3000 ширхгийг хэвлүүлэн ирүүлж, Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Цагаанхад чиглэлийн нүүрс тээврийн жолооч нарт тарааж ажилласан. Мөн Улаанбаатар хотын олон нийтийн сайтууд болох Цахиур.mn, UBN.mn, Монцамэ мэдээллийг өгч ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, байгууллагатай хамтран ажиллах талаар

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 01 дүгээр сарны 15-ны №13 “Олон нийтийн цагдаагийн тоо, урамшууллын хэмжээг тогтоох тухай” тогтоолоор 2020 онд Өмнөговь аймгийн хэмжээнд ажиллах олон нийтийн цагдаагийн орон тоог 45, нэг хүнд сар тутам олгох урамшууллын хэмжээг 501.000 төгрөгөөр тогтоосон шийдвэрийг гаргуулан ажиллаж байгаа билээ. Одоогийн байдлаар 4 орон дутуу байгаа тул ажлын байрны сонгон шалгаруулалт явуулж байна. Даланзадгад сумын иргэд өөрсдийн оршин суугаа нутаг дэвсгэрийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж энэ чиглэлээр нутгийн захиргааны байгууллага болон цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 28 Хөршийн холбоо нь 28 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

“Хамтарсан баг”, “Хөршийн холбоо”-г байгуулж, урамшууллын 27.000.000 /хорин долоон сая төгрөг/-ийн асуудлыг шийдвэрлүүлж ажилласан.

Гурав. Дүгнэлт

Тус аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заагдсан ерөнхий ажил, арга хэмжээ ажлын явц, үр дүн хэвийн явагдаж байгаа бөгөөд хэрэгжилт хангагдаагүй ажил, арга хэмжээ байхгүй байна.

Дөрөв. Санал

1. 2021 онд тохиох Ардын хувьсгалын болон Цагдаагийн байгууллага үүссэний 100 жилийн ойтой холбогдуулан улсын болон орон нутгийн төсөвт тусгуулсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангах.

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР